

## **ГОЛОМТ БАНК**

**Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын  
дагуу бэлтгэгдсэн Санхүүгийн тайлангууд болон  
Хараат бус аудиторын тайлан**

**2022 оны 12 дугаар сарын 31**

## **АГУУЛГА**

Байгууллагын талаарх мэдээлэл

Хараат бус аудиторын тайлан

Санхүүгийн тайлангууд

Санхүүгийн байдлын тайлан .....	2
Орлого үр дүнгийн болон Бусад дэлгэрэнгүй орлогын тайлан .....	3
Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
Мөнгөн гүйлгээний тайлан .....	5

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд

1	Танилцуулга .....	6
2	Банкны үйл ажиллагааны орчин .....	7
3	Тайлан бэлтгэх үндэслэл .....	8
4	Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд .....	18
5	Шинэ буюу өөрчлөлт орсон стандартуудын тайлбар, хэрэгжилт .....	35
6	Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд .....	36
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	37
8	Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц .....	37
9	Бусад банкуудад байршуулсан хөрөнгө .....	38
10	Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт .....	39
11	Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт .....	47
12	Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа .....	48
13	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө .....	67
14	Бусад хөрөнгө .....	68
15	Биет бус хөрөнгө .....	72
16	Үндсэн хөрөнгө .....	73
17	Ашиглах эрхтэй хөрөнгө .....	74
18	Өмчлөх бусад хөрөнгө .....	75
19	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө .....	76
20	Бусад банкуудын байршуулсан хөрөнгө .....	76
21	Харилцагчийн харилцах, хадгаламж .....	77
22	Бусад зээлийн эх үүсвэр .....	78
23	РЕПО хэлцэл .....	81
24	Бусад өр төлбөр .....	82
25	Хувьцаат Капитал .....	82
26	Хүүгийн орлого ба зардал .....	84
27	Хураамж, шимтгэлийн орлого ба зардал .....	85
28	Бусад үйл ажиллагааны орлого .....	85
29	Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал .....	86
30	Бусад олз/(гарз), цэвэр дүнгээр .....	86
31	Орлогын албан татвар .....	87
32	Өмчийн бүрэлдэхүүн хэсэг бүрд хүлээн зөвшөөрөгдсөн бусад дэлгэрэнгүй орлого .....	90
33	Ногдол ашиг .....	90
34	Нэгж хувьцаанд ногдох ашиг .....	90
35	Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулга .....	91
36	Сегментийн шинжилгээ .....	92
37	Хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ .....	95
38	Санхүүгийн эрсдэлийн удирдлага .....	95
39	Капиталын удирдлага .....	117
40	Болзошгүй өр төлбөр ба үүрэг .....	118
41	Үүсмэл санхүүгийн хэрэглүүр .....	120
42	Бодит үнэ цэнийн тодруулга .....	121
43	Санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтийн ангиллаарх тодруулга .....	131
44	Холбоотой талуудын ажил гүйлгээ .....	133
45	Хувьцаанд суурилсан төлбөр .....	138
46	Тайлант хугацааны дараах үйл явдлууд .....	139
47	Товчлол .....	140

# ГОЛОМТ БАНК ХК

## Байгууллагын талаарх мэдээлэл

### Үүсгэн байгуулах шийдвэр

Голомт Банк (цаашид “Банк” гэх) нь 1995 оны 03 дугаар сарын 06-ны өдөр анх үүсгэн байгуулагдсан.

### Гэрчилгээ ба Лиценз

Банк нь 2005 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газраас шинээр олгосон 2075377 тоот регистрийн дугаар бүхий 9016001014 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг эзэмшдэг. Банк нь 1995 оны 03 дугаар сарын 06-ны өдөр банкны үйл ажиллагаа эрхлэх 25 тоот Тусгай зөвшөөрлийг Монголбанкнаас авсан.

### Төлөөлөн Удирдах Зөвлөл

Ч.Мөнхцэцэг	<i>ТУЗ-ийн дарга</i>
Урс Е.Шварценбах	<i>ТУЗ-ийн гишүүн</i>
Д.Мөнхтөр	<i>ТУЗ-ийн гишүүн</i>
Л.Болормаа	<i>ТУЗ-ийн гишүүн</i>
О.Ганжолоо	<i>ТУЗ-ийн гишүүн</i>
Ж.Үнэнбат	<i>ТУЗ-ийн гишүүн</i>
Лопез Абелло	<i>Хараат бус гишүүн</i>
Жэймс Б.Двайер	<i>Хараат бус гишүүн</i>
Александр Пикер	<i>Хараат бус гишүүн</i>

### Гүйцэтгэх Удирдлага

К.Норихико	<i>Гүйцэтгэх захирал</i>
Г.Ганболд	<i>Ерөнхийлөгч</i>
Т.Нямсүрэн	<i>Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Эрсдэл хариуцсан захирал</i>
Д.Бадрал	<i>Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Бизнес хариуцсан захирал</i>
М.Сайнбилэг	<i>Мэдээлэл технологи хариуцсан захирал</i>
С.Мөнхтуяа	<i>Санхүү удирдлагын газрын захирал</i>
З.Мягмардорж	<i>Байгууллагын банкны газрын захирал</i>
Ц.Байгалмаа	<i>Иргэдийн банкны газрын захирал</i>
М.Наранхүү	<i>Зээлийн газрын захирал</i>
Т.Отгон	<i>Эрсдэлийн удирдлагын газрын захирал</i>
Г.Уянга	<i>Хүний нөөцийн удирдлагын газрын захирал</i>
Б.Содболор	<i>Нөөцийн удирдлагын газрын захирал</i>
Н.Очирхуяг	<i>Маркетинг, олон нийттэй харилцах газрын захирал</i>
А.Нямсүрэн	<i>Бизнес процесс менежментийн газрын захирал</i>
О.Батцэнгэл	<i>Мэдээлэл технологийн газрын захирал</i>
Ё.Пүрэвбат	<i>Бүртгэл тооцооны газрын захирал</i>
Х.Пүрэвдорж	<i>Захиргааны газрын захирал</i>

### Хаяг

Голомт Банк  
Голомт Банкны төв байр  
Сүхбаатарын талбай 5, Ш/Х-22  
Улаанбаатар 15160, Монгол улс

### Аудитор

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК  
Сэнтрал Тауэр, 6 давхар, 601 тоот  
Сүхбаатарын талбай, Сүхбаатар дүүрэг 8-р хороо  
Улаанбаатар хот 14200, Монгол Улс



## Хараат бус Аудиторын Тайлан

Голомт Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, Голомт Банк ХК ("Банк" гэх)-ийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлсэн байна.

### Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Банкны санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

### Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЭСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЭЗД)-ийн (Хараат бус байдлын олон улсын стандартыг оруулан) дагуу Банкнаас бид хараат бус болно. Бид НБОУЭСЗ-ийн МНБЭЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

### Аудитын арга барил

#### Хураангуй

<b>Материаллаг байдлын түвшин</b>	<ul style="list-style-type: none"><li>• Банкны материаллаг байдлын ерөнхий түвшин: 7,600,855 мянган төгрөг нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нийт орлогын 1%-ийг эзэлж байна.</li></ul>
<b>Аудитын гол асуудлууд</b>	<ul style="list-style-type: none"><li>• Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9, Санхүүгийн хэрэглүүр (СТОУС 9)-ын дагуу удирдлагын тооцоолсон харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа төлбөрийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын үнэлгээ.</li></ul>

Аудитын төлөвлөлтийн хүрээнд бид энэхүү материаллаг байдлын түвшинг тодорхойлж, санхүүгийн тайлангуудад материаллаг буруу илэрхийлэл байх эрсдэлийг тооцсон. Ялангуяа тодорхой бус ирээдүйн үйл явдлын талаарх таамаглалыг агуулсан нягтлан бодох бүртгэлийн төсөөллүүд зэрэг удирдлагын хийсэн томоохон тооцооллуудыг харгалзан үзсэн. Бид аудитын бүх үе шатанд бусад асуудлууд дотор гүйцэтгэх удирдлагын эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих үйлдлүүд болон залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг батлах нотолгоо байгаа эсэхийг анхаарч үзсэн.

Бид аудитын цар хүрээгээ Банкны бүтэц, үйл ажиллагаа эрхэлдэг салбар, бүртгэл хөтлөлт болон хяналтын системийг багтаан санхүүгийн тайлангуудыг бүхэлд нь дүгнэхэд хангалттай нотолгоо өгөхүйц, бидэнд үр дүнтэй ажиллах боломж олгох байдлаар тодорхойлсон.

### Материаллаг байдал

Бидний аудитын цар хүрээнд материаллаг байдал мөн нөлөөлдөг ба аудит нь санхүүгийн тайлангууд бүхэлдээ материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд үндэслэлтэй баталгаа олж авахад зориулагдсан. Буруу тайлагнал нь алдаа эсвэл залилангаас үүсч болох бөгөөд энэ нь тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр байвал материаллаг хэмээн тооцогдоно.

Бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжинд үндэслэн Банкны санхүүгийн тайлангуудад бүхэлд нь хамаарах материаллаг байдлын ерөнхий түвшинг тогтоосныг доорх хүснэгтэнд харуулав. Эдгээрийг чанарын бусад хүчин зүйлсийн хамт харгалзаж үзсэнээр бид аудитын гүйцэтгэх хугацаа, горимуудын цар хүрээг тогтоож буруу илэрхийлэл байгаа бол тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайлангуудад бүхэлдээ хэрхэн нөлөөлөхийг тодорхойллоо.

<b>Банкны материаллаг байдлын ерөнхий түвшин</b>	7,600,855 мянган төгрөг
<b>Тодорхойлохдоо ашигласан арга</b>	2022 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нийт орлогын 1%
<b>Материаллаг байдлын түвшинг тооцсон үндэслэл</b>	Банк нь арилжааны банк тул бид орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн үзүүлэлтүүдээс зохих жишиг үзүүлэлтийг тодорхойлсон. Банкны үндсэн үйл ажиллагааны хувьд орлого (үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцсон хүүгийн орлого, түүнтэй адилтгах бусад орлого, хураамж, шимтгэлийн орлого болон гадаад валютын болон үнэт металын арилжааны олз хасах гарз) нь хамгийн зохистой бөгөөд хамааралтай хэмжигдэхүүн гэж тооцогдсон. Бидний сонгосон 1% нь сонгогдсон жишиг үзүүлэлтэд ашигладаг материаллаг байдлын түвшинтэй нийцэж байна.

### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжийн хувьд тухайн тайлант хугацааны санхүүгийн тайлангуудын аудитад хамгийн чухал нөлөө үзүүлсэн зүйлсийг хэлнэ. Эдгээр асуудлуудыг бид санхүүгийн тайлангуудыг аудитлах явцаа болон аудитын дүгнэлт өгөхдөө харгалзан үздэг бөгөөд тусад нь нэмэлт дүгнэлт гаргадаггүй болно.

Аудитын гол асуудал	Бидний гүйцэтгэсэн аудит эдгээр асуудлуудыг хэрхэн авч үзсэн тухай
<p>СТОУС 9, "Санхүүгийн хэрэглүүр"-ийн дагуу харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа төлбөрийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын үнэлгээ.</p> <p>ХБЭА-ын хасагдуулгыг тодорхойлох чухал үнэлэлтийг шаарддаг санхүүгийн тайлагналын стандартын нарийн төвөгтэй байдал болон харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа төлбөрийн их хэмжээний үлдэгдэл дүнгээс шалтгаалж харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа төлбөрт тооцсон ХБЭА-ын хасагдуулгыг аудитын гол асуудал гэж бид авч үзсэн.</p> <p>Банк ХБЭА-ын үнэлгээг тооцоолохдоо:</p> <ul style="list-style-type: none"> <li>• тусгайлсан суурь; болон</li> <li>• багцад суурилан: зээлийн эрсдэлийн ижил үзүүлэлтүүдийг (жишээ нь, төлбөр төлөгдөхгүй болох магадлал, төлбөр төлөгдөхгүй болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ/алдагдал хүлээх магадлал) зээлийн багцын ижил сегментүүдэд ХБЭА-ыг тооцоолох явцад ашиглах болно.</li> </ul> <p>Үнэлэмжийн үндсэн шалгуурууд нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>• СТОУС 9-ийн дагуу харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа төлбөрийг шатлалаар нь ангилсан байдал;</li> <li>• Төлбөр төлөгдөхгүй болох магадлал, төлбөр төлөгдөхгүй болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ/алдагдал хүлээх магадлал болон төлөгдөхгүй төлбөрийн хэмжээ зэрэг эрсдэлийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцоолохдоо ашигладаг таамаглалын загварчлал болон үндсэн тооцоолол.</li> </ul> <p>Тодруулга 3.3 "Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан үндсэн тооцоолол ба үнэлэмж",</p>	<p>ХБЭА-ын хасагдуулгыг үнэлэхдээ бид дараах аудитын горимуудыг хэрэгжүүлсэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бид СТОУС 9-ийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэхийн тулд Банкнаас боловсруулсан ХБЭА-ын хасагдуулгын үнэлгээний аргачлал, загварыг үнэлсэн. Бидний гүйцэтгэсэн горимууд үндсэндээ: төлбөр төлөгдөхгүй байдлын тодорхойлолт, "зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт"-ийг тодорхойлох хүчин зүйлс, харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа төлбөрийг шатлалаар нь ангилах, эрсдэлийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцоолоход чиглэсэн.</li> <li>• Хугацаа хэтэрсэн зээлүүдийг тодорхойлох хяналтын загвар болон хяналтын үйл ажиллагааны үр дүнг бид түүврийн үндсэн дээр үнэлж, шалгасан.</li> <li>• Эрсдэлийн үнэлгээ, зээлийн эрсдэл болон макро эдийн засгийн орчныг харгалзан үзэхэд байгуулсан эрсдэлийн сан нь зохистой байсан эсэхийг тодорхойлохын тулд ХБЭА-ын хасагдуулгын түвшингийн тусгайлсан үнэлгээг түүврийн үндсэн дээр гүйцэтгэсэн. Бид Банкны зээлдэгчдийн өртөж буй эдийн засаг, салбаруудын чиг хандлагыг авч үзсэн.</li> <li>• Банкны тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээг янз бүрийн хувилбар болон үндсэн таамаглалуудаас түүвэрлэн тэр дундаа ХБЭА-ны тусгайлсан үнэлгээний хувьд барьцаа хөрөнгө цуглуулах хугацааг бид үнэлсэн. Бид ашиглагдсан хувилбаруудын хамаарал, тэдгээрийн магадлалыг үнэлж, мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцоолсон.</li> <li>• ХБЭА-ын тооцоололд харгалзан үзсэн барьцаа хөрөнгийн үнэлгээг бид түүврийн аргаар шалгаж үнэлсэн.</li> <li>• Сегментчлэл болон шатлалын ангиллыг бид түүврийн аргаар шалгасан.</li> <li>• Өгөгдлийн үнэн зөв байдал болон чанарыг шалгахын тулд бид ХБЭА-ын тооцоололд</li> </ul>

<p>Тодруулга 4 “Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд”,</p> <p>Тодруулга 12 “Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа төлбөр”, болон</p> <p>Тодруулга 38 “Санхүүгийн эрсдэлийн удирдлага” зэрэг санхүүгийн тайлангийн тодруулгуудад эрсдэлийн алдагдлын хасагдуулгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тодруулсан.</p>	<p>ашигласан өгөгдлийг зээлийн гэрээ, барьцаа хөрөнгийн гэрээ, зээлийн дансны хуулга гэх мэт эх сурвалжийн өгөгдөлтэй тулгах замаар түүвэрийн аргаар шалгасан.</p> <ul style="list-style-type: none"><li>• ХБЭА-ын үнэлгээний хувьд төлбөр төлөгдөхгүй болох магадлал, төлбөр төлөгдөхгүй болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ/алдагдал хүлээх магадлал болон төлөгдөхгүй төлбөрийн хэмжээг дахин тооцоолох үед ашигласан загварын агуулга, томъёололын зохистой байдлыг үнэлсэн.</li><li>• Бид зээлдэгчдийн үйл ажиллагаагаа явуулж буй сегмент, салбарууд болон зээлдэгчдийн шатлалын байдлаар ангилагдсан зээлийн ХБЭА-ын хувьд нарийвчилсан шинжилгээ гүйцэтгэсэн.</li><li>• Ашиглагдсан макро эдийн засгийн хувьсагчдыг (ДНБ, инфляцийн түвшин, зээлийн хүү, валютын ханш гэх мэт) тохирох эсэхийг бид ерөнхийд нь үнэлж, ирээдүйд чиглэсэн мэдээллийн ХБЭА-ын түвшинд хэрхэн нөлөөлөх талаарх Банкны үнэлгээг шалгасан. Мөн гадны эх сурвалж дахь орц мэдээллийг тулган, ашигласан загварын зохистой эсэхийг шалгасан.</li><li>• Бид СТОУС-д нийцсэн тодруулгуудын хангалттай, зохистой байдлыг үнэлсэн.</li></ul>
--	---

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэлд Жилийн тайланг (гэхдээ санхүүгийн тайлангууд болон түүнтэй холбоотой аудиторын тайланг оруулаагүй) багтаасан бөгөөд энэхүү аудиторын тайлангийн өдрөөс хойш бэлэн болохоор хүлээгдэж байгаа болно.

Санхүүгийн тайлангуудын талаарх аудитын дүгнэлтэд бусад мэдээлэл хамрагдаагүй бөгөөд бид түүнтэй холбоотой аудитын аливаа хэлбэрийн дүгнэлтийг илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбогдуулан бидний хүлээх үүрэг бол дээр дурдсан бусад мэдээллийг бэлэн болсон үед нь уншиж танилцах бөгөөд ингэхдээ бусад мэдээлэл нь аудитын явцад бидний олж авсан мэдлэгтэй эсвэл санхүүгийн тайлангуудтай материаллаг хэмжээгээр нийцэхгүй, өөрөөр хэлбэл материаллаг алдаатай илэрхийлэгдсэн байгаа эсэхийг бид харгалзан үздэг.

Жилийн тайланг уншиж танилцах үед хэрэв бид тус тайланд материаллаг алдаа байна гэж дүгнэвэл засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд энэ тухай мэдэгдэх шаардлагатай болдог.

## Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангууд бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Банкны үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Банкны үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Банкны засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

## Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцоолуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Банк үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Банкны үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.



- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд багтдаг.

Бид мөн хараат бус байдалд тавигдах ёс зүйн хэм хэмжээний тухай, хараат бус байдалд нөлөөлөх харилцаа болон бусад бүхий л нөлөөлөхүйц хүчин зүйлсийн талаар, шаардлагатай нөхцөл байдалд тэдгээрээс хараат бус байдлыг хэрхэн хамгаалах арга хандлагаа тусгасан мэдэгдлийг засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд гаргаж өгдөг.

Засаглал хариуцсан эрх бүхий этгээдтэй харилцсан зүйлсээсээ бид тухайн тайлант хугацааны санхүүгийн тайлангуудын аудитад хамгийн чухал нөлөөтэй зүйлсийг буюу аудитын гол асуудлыг тодорхойлдог. Эдгээр асуудлуудыг бид хууль тогтоомжоор олон нийтэд дэлгэхийг хориглосон эсвэл, маш цөөн тохиолдолд, энэхүү асуудлуудыг мэдээлснээс үүсэх таагүй үр дагавар нь олон нийтийн эрх ашгаас илүү өндөр хэмээн үзсэнээс бусад тохиолдолд аудитын тайландаа тусгадаг.

Энэхүү хараат бус аудиторын тайланг гаргаж буй аудитын партнер нь Айгуль Ахметова болно.

Монгол Улс, Улаанбаатар хот

2023 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Баталсан:



Шаукат Тапиа  
Удирдах Партнер  
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК



Гарын үсэг зурсан:







Даваагийн Баярмаа  
Гүйцэтгэх захирал  
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

**Голомт Банк ХК**  
**Санхүүгийн байдлын тайлан**

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
<b>Хөрөнгө</b>			
	7	1,142,404,090	694,954,420
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө			
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөц	8	357,581,959	277,343,522
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	9	1,566,963,380	1,056,447,510
Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	10	1,230,251,009	1,979,439,874
Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	11	22,513,491	18,472,715
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	12	3,697,633,345	3,339,174,837
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	13	10,276,475	17,427,586
Бусад хөрөнгө	14	283,402,128	39,972,362
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	41	436,146,109	208,917,059
Биет бус хөрөнгө	15	20,948,388	17,848,672
Үндсэн хөрөнгө	16	151,367,641	150,019,342
Ашиглах эрхтэй хөрөнгө	17	15,192,622	13,001,148
Өмчлөх бусад хөрөнгө	18	43,191,321	106,953,168
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	19	6,687,575	74,084,536
<b>Нийт хөрөнгө</b>		<b>8,984,559,533</b>	<b>7,994,056,751</b>
<b>Өр төлбөр</b>			
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	20	52,394,763	16,782,536
Харилцагчдын харилцах, хадгаламж	21	5,743,297,867	5,463,543,390
Бусад зээлийн эх үүсвэр	22	1,916,312,092	1,509,446,027
Репо хэлцэл	23	211,347,644	221,912,121
Орлогын татварын өглөг	31	30,961,395	29,389,944
Хойшлогдсон татварын өр төлбөр	31	20,743,288	9,484,597
Түрээсийн өр төлбөр	17	16,290,486	14,001,667
Бусад өр төлбөр	24	131,306,235	70,834,446
<b>Нийт өр төлбөр</b>		<b>8,122,653,770</b>	<b>7,335,394,728</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>			
Давуу эрхтэй хувьцаа		-	16,388,100
Хувь нийлүүлсэн хөрөнгө	25	202,164,327	168,638,148
Нэмэгдэж төлөгдсөн капитал	25	301,481,120	169,486,044
Хуримтлагдсан ашиг		283,420,821	242,436,053
Өмчийн бусад хэсэг		74,839,495	61,713,678
<b>Нийт эзэмшигчдийн өмч</b>		<b>861,905,763</b>	<b>658,662,023</b>
<b>Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		<b>8,984,559,533</b>	<b>7,994,056,751</b>

2023 оны 03 сарын 30-ны өдөр Банкны удирдлагыг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав.

 <b>Ч.МӨНХЦЭЦЭГ</b> Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга	 <b>ГОЛОМТ БАНК</b> ТТГ 1075 ± 2075377 <b>GOLOMT BANK</b>	 <b>К.НОРИХИКО</b> Гүйцэтгэх захирал	 <b>С.МӨНХТУЯА</b> Санхүүгийн Удирдлагын Газрын Захирал
---	---	--	--

**Голомт Банк ХК**  
**Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан**

Мянган төгрөгөөр	Тоду рлга	2022	2021
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	26	576,384,931	526,486,180
Бусад адилтгах орлого	26	33,524,234	28,291,422
Хүүгийн зардал	26	(222,857,161)	(271,257,957)
Бусад адилтгах зардал	26	(1,481,221)	(1,560,592)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>		<b>385,570,783</b>	<b>281,959,053</b>
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	12	(45,969,488)	(35,770,454)
<b>Зээлжих эрсдэлийн сангийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого</b>		<b>339,601,295</b>	<b>246,188,599</b>
Хураамж, шимтгэлийн орлого	27	84,131,978	62,493,142
Хураамж, шимтгэлийн зардал	27	(39,961,185)	(21,714,228)
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз		7,326,760	1,695,813
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн гэрээний өөрчлөлтөөс үүссэн олз		1,794,198	3,638,530
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн борлуулалтаас үүссэн гарз		(48,339)	(626)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз/(гарз)		34,725,648	(21,818,582)
Үнэт металлын арилжаанаас үүссэн олз		7,815,364	4,785,518
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз/(гарз)		(10,060,088)	153,074
Гадаад валютын арилжаанаас үүссэн олз		58,228,967	20,398,503
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх зээлийн бодит үнэ цэнийн гарз		(6,120,026)	(14,571,327)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн үнэ цэнийн гарз, бүртгэлээс хасагдахгүй		(1,688,544)	(848,111)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын эрсдэлийн алдагдлын сангийн буцаалт	10	4,181	(2,676)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын эрсдэлийн сангийн зардал		(662,323)	(1,782,503)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал		(3,584,406)	13,591
Зах зээлийн хүүгээс бага хүүтэй олгосон санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн гарз		(235,786)	(2,636,090)
Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	14	(868,016)	(539,852)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн олзоос хасах гарз		5,413	(3,973,106)
Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтын сангийн зардал болон эрсдэлийн сангийн зардал	18	(96,897,798)	(78,887,826)
Аккредитив, баталгааны эрсдэлийн сангийн зардал		(509,336)	1,958,933
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлтийн гарз		(3,372,606)	(7,426,258)
Ногдол ашгийн орлого		32,813	204,394
Үйл ажиллагааны бусад орлого	28	1,154,973	3,835,000
Удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал	29	(175,345,911)	(137,139,597)
Бусад гарз, цэвэр дүнгээр	30	(1,669,242)	(1,453,421)
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>193,797,984</b>	<b>52,570,894</b>
Орлогын албан татварын зардал	31	(77,295,936)	(26,634,228)
<b>Тайлант жилийн ашиг</b>		<b>116,502,048</b>	<b>25,936,666</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал):</b>			
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд ангилагдах зүйлс:</i>			
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт			
- Тайлант жилийн гарз		(50,471,551)	2,680,637
- Худалдан борлуулснаас ашиг, алдагдалд дахин ангилагдсан олз/(гарз)		48,339	626
Дэлгэрэнгүй орлогын тайланд шууд бүртгэсэн орлогын татвар		12,605,803	(670,316)
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд ангилагдахгүй зүйлс:</i>			
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн олз	32	(558,251)	1,153,870
Дэлгэрэнгүй орлогын тайланд шууд бүртгэсэн орлогын татвар	32	139,563	(288,468)
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>(38,236,097)</b>	<b>2,876,349</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>78,265,951</b>	<b>28,813,015</b>
<b>Банкны эзэмшигчдэд хамаарах нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг</b>	<b>34</b>	<b>163.80</b>	<b>35.92</b>
<b>Банкны эзэмшигчдэд хамаарах нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг</b>	<b>34</b>	<b>163.73</b>	<b>35.92</b>

Энэхүү санхүүгийн тайлангийн 6-140 дугаар хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

**Голомт Банк ХХК**  
**Өмчийн өөрчлөлтийн тайлан**  
**2022 оны 12 сарын 31**

Мянган төгрөгөөр	Тодруулга	Энгийн хувьцаа	Давуу эрхтэй хувьцаа	Халаасны хувьцаа/ давуу эрхтэй хувьцаа	Халаасны хувьцаа	Нэмэгдэж төлөгдсөн капитал	БДОБҮЦ-ээрх ҮЦ-ны дахин үнэлгээний нөөц	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эзэмшигчдийн өмч
<b>2021 оны 1 сарын 1-ний үлдэгдэл</b>		<b>42,240,037</b>	<b>25,778,900</b>	<b>(9,390,800)</b>	<b>(80,500)</b>	<b>291,843,805</b>	<b>(12,862,023)</b>	<b>7,495,543</b>	<b>75,680,019</b>	<b>210,853,485</b>	<b>631,558,466</b>
	Тайлант хугацааны ашиг	-	-	-	-	-	-	-	-	25,936,666	<b>25,936,666</b>
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	2,876,349	-	-	-	<b>2,876,349</b>
<b>2021 оны нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2,929,433</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>25,936,666</b>	<b>28,813,015</b>
	Хувьцааны нэрлэсэн үнийн өсөлт	126,720,111	-	-	(241,500)	(126,478,611)	-	-	-	-	-
	Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн БДОБҮЦ-ээрх өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	-	9,349,580	-	-	(9,349,580)	-
	Зарласан болон төлөгдсөн ногдол ашиг	33	-	-	-	-	-	-	-	(1,709,458)	<b>(1,709,458)</b>
	Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	-	(250,441)	-	250,441	-
	МБ-ны журмын дагуу бүртгэсэн нөөц	-	-	-	-	-	-	-	(20,575,349)	20,575,349	-
	Бусад	-	-	-	-	4,120,850	-	-	-	(4,120,850)	-
<b>2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>		<b>168,960,148</b>	<b>25,778,900</b>	<b>(9,390,800)</b>	<b>(322,000)</b>	<b>169,486,044</b>	<b>(636,094)</b>	<b>7,245,102</b>	<b>55,104,670</b>	<b>242,436,053</b>	<b>658,662,023</b>
	Тайлант хугацааны ашиг	-	-	-	-	-	-	-	-	116,502,048	<b>116,502,048</b>
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	(38,236,097)	CIE	-	-	<b>(38,236,097)</b>
<b>2022 оны нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>(38,236,097)</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>116,502,048</b>	<b>78,265,951</b>
	Шинээр гаргасан энгийн хувьцаа	33,526,179	-	-	-	131,788,974	-	-	-	-	<b>165,315,153</b>
	Халаасалсан хувьцаа	-	-	(16,388,100)	-	-	-	-	-	(14,271,600)	<b>(30,659,700)</b>
	Эргэлтээс гаргасан хувьцаа	(322,000)	(25,778,900)	25,778,900	322,000	206,102	-	-	-	(206,102)	-
	Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн БДОБҮЦ-ээрх өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	-	3,065,729	-	-	(3,065,729)	-
	Зарласан болон төлөгдсөн ногдол ашиг	33	-	-	-	-	-	-	-	(555,404)	<b>(555,404)</b>
	Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	-	(250,440)	-	250,440	-
	МБ-ны журмын дагуу бүртгэсэн нөөц	-	-	-	-	-	-	-	47,699,164	(47,699,164)	-
	Хувьцаанд суурилсан төлбөр	-	-	-	-	-	-	-	847,461	-	<b>847,461</b>
	Бусад	-	-	-	-	-	-	-	-	(9,969,721)	<b>(9,969,721)</b>
<b>2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>		<b>202,164,327</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>301,481,120</b>	<b>(35,806,462)</b>	<b>6,994,662</b>	<b>103,651,295</b>	<b>283,420,822</b>	<b>861,905,763</b>

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар бусад нөөц сан нь Монгол Банкны журмын дагуу байгуулсан нөөц сангаас бүрдэнэ. Монголбанкны журмын дагуу тооцоолсон зээлийн эрсдэлийн сан болон өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралт, СТОУС-ын дагуу тооцоолсон зээлийн эрсдэлийн сан болон өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зөрүү нь өмчийн өөрчлөлтийн тайлангийн нөөц сангийн дансанд тусгагдсан. Энэхүү нөөц санг СТОУС болон Монголбанкны журмын дагуу байгуулж, Банкны хуримтлагдсан ашигт тохируулсан.

Энэхүү санхүүгийн тайлангийн 6-140 дугаар хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**Голомт Банк ХК**  
**Мөнгөн гүйлгээний тайлан**

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022	2021
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>193,797,984</b>	<b>52,570,894</b>
Мөнгөн бус орлого, зардлын тохируулгууд:			
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	12	45,969,488	35,770,454
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгөөс үүссэн (олз)/гарз		48,339	626
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн (олз)/гарз		(7,326,760)	(1,695,813)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн гэрээний өөрчлөлтөөс үүссэн олз		(1,794,198)	(3,638,530)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн (олз)/гарз	41	(34,725,648)	21,818,582
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн гарз, бүртгэлээс хасагдахгүй		1,688,544	848,111
Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх зээлийн гарз		6,120,026	14,571,327
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт		3,584,406	(13,591)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт		662,323	1,782,503
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын эрсдэлийн алдагдлын сангийн зардал		(4,181)	2,676
Зах зээлийн хүүгээс бага хүүтэй олгосон санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн гарз		235,786	2,636,090
Үндсэн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө борлуулсны (олз)/гарз		1,669,242	1,453,421
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн (олз)/гарз		10,060,088	(153,074)
Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	14	868,016	539,852
Аккредитив, баталгааны эрсдэлийн сангийн зардлын буцаалт		509,336	(1,958,933)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний гарз	13	3,372,606	7,426,258
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн гарз	19	(5,413)	3,973,106
Элэгдлийн зардал	16,17	27,077,479	24,555,445
Хорогдуулалтын зардал	15	6,063,280	3,837,579
Данснаас хассан үндсэн хөрөнгө	16	66	18,397
Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтаас үүссэн гарз болон үнэ цэнийн бууралтын сангийн зардал	18	96,897,798	78,887,826
Хүүгийн орлого	26	(609,909,165)	(554,777,602)
Хүүгийн зардал	26	224,338,382	272,818,549
<b>Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ</b>		<b>(30,802,176)</b>	<b>(38,725,847)</b>
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөцийн цэвэр (өсөлт)		(79,911,039)	(33,853,818)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт		(290,629,936)	95,873,906
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны цэвэр бууралт / (өсөлт)		12,343,979	(2,188,600)
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өмчийн хэлбэрээрх үнэт цаасны цэвэр (өсөлт) / бууралт		(95,171)	1,029,277
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны цэвэр (өсөлт)		(567,177,200)	(514,728,118)
Бусад хөрөнгийн цэвэр (өсөлт) / бууралт		(14,297,782)	80,328,375
Өмчлөх бусад хөрөнгийн цэвэр бууралт / (өсөлт)		85,278,199	(44,115,715)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн цэвэр (өсөлт) /бууралт		(44,592,847)	76,700,121
Банкуудын байршуулсан хөрөнгийн цэвэр өсөлт		31,075,728	2,102,465
Харилцагчдын харилцах, хадгаламжийн цэвэр өсөлт		284,574,136	256,942,420
Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт / (бууралт)		60,809,914	(28,003,168)
<b>Татвар болон хүүгийн өмнөх үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(553,424,195)</b>	<b>(148,638,702)</b>
Төлсөн орлогын албан татвар		(51,720,490)	(1,075,077)
Хүлээн авсан хүү		616,840,938	557,033,125
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх хөрөнгө оруулалтаас хүлээн авсан хүүгийн орлого		4,715,191	8,317,135
Төлсөн хүү		(225,243,451)	(382,483,341)
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(208,832,007)</b>	<b>33,153,141</b>

**Голомт Банк ХК**  
**Мөнгөн гүйлгээний тайлан**

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022	2021
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт		(112,280,200)	(93,473,456)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өмчийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого		138,979	12,837,742
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого		7,516,430	18,648,928
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	16	(21,121,361)	(25,795,226)
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	16	508,280	704,525
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	15	(9,162,995)	(4,931,907)
Эргэлтийн бус хөрөнгийн урьдчилгаа	14	(230,000,000)	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(364,400,867)</b>	<b>(92,009,394)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
РЕПО хэлцлээс орж ирсэн орлого		424,211,523	562,558,030
РЕПО хэлцлийн эргэн төлөлт		(447,033,190)	(367,560,485)
Бусад зээлийн эх үүсвэрээс орж ирсэн орлого	22	1,201,130,206	1,205,497,008
Бусад зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт	22	(970,908,033)	(854,325,119)
Түрээсийн өр төлбөрийн эргэн төлөлт		(5,758,791)	(5,205,254)
Шинээр гаргасан энгийн хувьцаа		165,315,153	-
Энгийн хувьцааны буцаан худалдан авалт		(30,659,700)	-
Төлсөн ногдол ашиг	33	(555,404)	(1,709,458)
Бусад төлөлт		(6,600,000)	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>329,141,762</b>	<b>539,254,722</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө		84,779,713	7,540,251
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт</b>		<b>(159,311,400)</b>	<b>487,938,720</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,434,725,888	1,946,787,169
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7</b>	<b>2,275,414,488</b>	<b>2,434,725,888</b>

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө ашиглахыг шаарддаггүй МИК-ТЗК болон ҮЦСК-ТЗК-ийн хэлцлүүд нь Мөнгөн гүйлгээний тайланд ороогүй бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 3 болон 10-аас харна уу.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанаас өмчлөх бусад хөрөнгө рүү, өмчлөх бусад хөрөнгөөс борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө рүү шилжсэн мөнгөн бус гүйлгээ нь энэ тайланд ороогүй (Тодруулга 4.29, 13, 18 болон 19-өөс харна уу).

## **1 Танилцуулга**

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Голомт Банк ХК (“Банк”)-ийн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (“СТОУС”)-ын дагуу бэлтгэгдсэн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ.

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банкийг шууд хянадаг, эцсийн шатны толгой компани нь Голомт Файнэншил Групп ХХК (2021 оны 12 сарын 31: Голомт Файнэншил Групп ХХК) байна. Банк нь Монгол Улсын хууль, эрх зүйн хүрээнд үүсгэн байгуулагдсан хувьцаат компани юм.

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Голомт Файнэншил Групп ХХК-ийн эзэмшигч Д.Баясгалан нь 2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Голомт Банкны эцсийн шатны эзэмшигч юм.

2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг Тодруулга 25-аас харна уу.

Банк нь 2005 оны 12 сарын 5-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас олгосон 2075377 тоот регистрийн дугаартай, 9016001014 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээтэй. Банк нь Монгол улсын төв банк болох Монголбанкнаас 1995 оны 3 сарын 6-нд олгосон 25 дугаартай банкны үйл ажиллагаа явуулах бүрэн зөвшөөрөлтэй.

Банкны хүчин төгөлдөр дүрмийн дагуу Банкны үндсэн үйл ажиллагаа нь:

- Хадгаламж;
- Зээлийн үйлчилгээ;
- Картын үйлчилгээ;
- Баталгаа ба аккредитив;
- Мөнгөн шилжүүлэг;
- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, болон арилжаалах;
- Үнэт металл худалдах, худалдан авах, хадгалах, болон арилжаалах;
- Гадаад төлбөр, тооцоо;
- Үнэт цаас гаргах, арилжаалах;
- Санхүүгийн түрээсийн үйлчилгээ;
- Зээл болон бусад санхүүгийн хэрэглүүр худалдан авах, худалдах;
- Кастодиан банкны үйлчилгээ;
- Хууль эрх зүйн хүрээнд хязгаарлагдаагүй бусад санхүүгийн үйлчилгээ болон Монголбанк ба Засгийн Газрын бусад байгууллагуудын хүлээн зөвшөөрсөн бусад үйлчилгээг үзүүлнэ.

Банк нь 2011 оны 6 сарын 2 болон 2014 оны 8 сарын 27 болон 2014 оны 10 сарын 21-ний өдөр тус бүр Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 163 тоот, 295 тоот болон 358 тоот тогтоолын дагуу андеррайтер, кастодиан банкны үйлчилгээ болон даатгалын зуучлалын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос (“СЗХ”) авсан.

Банк нь 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсад 77 салбар, тооцооны төвүүдтэй (2021 оны 12 сарын 31: 76 салбар, тооцооны төвүүдтэй), мөн 25 касс (2021 оны 12 сарын 31: 24 касс)-тайгаар үйл ажиллагаагаа явуулсан.

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банкны ажилтны тоо 2,266 (2021 оны 12 сарын 31: 2,226).

Банкны бүртгэгдсэн албан ёсны хаяг, байршил нь: Монгол Улс, Улаанбаатар хот-15160, Сүхбаатарын талбай 5, шуудангийн хайрцаг-22.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол төгрөгөөр (“Төгрөг”) толилуулсан.

Энэхүү тайланд ашигласан товчилсон үгсийн тайлбарыг Тодруулга 47-т оруулав.

## **2 Банкны үйл ажиллагааны орчин**

### **2.1 Ерөнхий**

Монгол улс хөгжиж буй зах зээлийн олон шинж чанарыг агуулдаг бөгөөд тэр дундаа харьцангуй өндөр инфляци, зээлийн хүүгийн түвшинтэй. Уул уурхайн салбар дахь боловсруулах үйлдвэрлэлийн түвшин бага байгаагаас шалтгаалж нүүрс, зэс зэрэг ашигт малтмалын түүхий эдийн нөөцийн экспорт нь эдийн засгийн гол орлогыг бүрдүүлдэг. 2017-2019 онуудад эдийн засаг жилд дунджаар 6 орчим хувиар өссөний дараа, КОВИД-19 тахлын сөрөг нөлөөгөөр агшиж, 2020 онд эдийн засаг 4.6%-иар буурч, улмаар 2021 онд 1.6%-иар бага зэрэг сэргэсэн. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2022 оны 12 сарын 31-ний байдлаар ДНБ-ий бодит өсөлт 4.8 хувьтай байна.

Монгол улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ Стандарт энд Пүүр'с кредит рейтинг тогтоох байгууллагын 2022 оны 7 сарын 21-ний өдрийн үнэлгээгээр тогтвортой төлөвтэй буюу "В" түвшинд байна. Мүүди'с үнэлгээний агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "В3" тогтвортой төлөвтэй, Фитч үнэлгээний агентлагаас тогтвортой төлөвтэй буюу "В" түвшинд байна гэж зарласан.

2022 онд Украины дайны нөлөөгөөр Монгол Улс инфляцийн өндөр дарамтад өртсөн бөгөөд энэ нь улам даамжирч, хүнсний бүтээгдэхүүн, шатахууны үнэд голчлон нөлөөлсөн. Түүнчлэн, БНХАУ-ын Ковидыг тэглэх бодлого, эдийн засгийн идэвхжил суларсан нь хил хаагдсан, нийлүүлэлт тасалдсан, түүхий эдийн эрэлт муу зэргээс шалтгаалан Монголоос Хятад руу экспортлох гол бүтээгдэхүүнд ихээхэн хохирол учруулсан.

2022 оны 12 сарын 31-ний байдлаар үндэсний мөнгөн тэмдэгт болох монгол төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2021 оны 12 сарын 31-ний өдрийн ханштай харьцуулахад 21%-иар уналаа. Үүний хариуд Төв банк мөнгөний бодлогоо эрс чангаруулж, бодлогын хүүг 2022 оны 1-р сард 6% байсан бол 2022 оны 12-р сар гэхэд 13%-д хүргэв. Монгол Улсын хүлээгдэж буй бодит ДНБ-ий өсөлт 2023 онд 5%-д хүрнэ гэж таамаглаж байгаа хэдий ч Хятадтай хилийн маргаан үргэлжилж, Украины дайны улмаас импортын үнэ өссөн зэрэг нь эдийн засгийн сэргэлтийг хязгаарлах төлөвтэй байна. Хятад улс 2023 оны нэгдүгээр сарын эхээр хилээ нээж, Оюутолгойн далд уурхайн олборлолтыг 2023 оны эхний хагаст эхлүүлэхээр төлөвлөж байгаа нь 2023 он болон цаашдын эдийн засгийн хэтийн төлөвт эерэгээр нөлөөлөхөөр байна.

Гэсэн хэдий ч эдийн засгийг урьдчилан таамаглахад тодорхойгүй байдаг тул удирдлагын одоогийн хүлээлт, тооцоолол нь бодит үр дүнгээс эрс өөр байж болно.

Ирээдүйд эдийн засгийн болон удирдах байгууллагуудын зохицуулалтын арга хэмжээ, нөхцөл байдал нь Банкны удирдлагуудын өнөөгийн хүлээлтээс ялгаатай байх магадлалтай. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг (ХБЭА) хэмжих зорилгоор Банк ирээдүйд чиглэсэн мэдээллүүд, тэр дундаа таамаглалууд болон макро эдийн засгийн хувьсагчдыг ашигладаг. Гэсэн хэдий ч эдийн засгийн урьдчилсан таамаглалуудын хувьд тэдгээр тохиолдлын биелэх магадлал, зураглал нь ерөнхийдөө маш тодорхойгүй байдаг тул бодит үр дүн нь төлөвлөснөөс эрс өөр байж болно. Тодруулга 4 болон Тодруулга 38-аас ХБЭА-ийн тооцоололд банк ирээдүйд чиглэсэн мэдээллийг хэрхэн тусгаж өгсөн талаар илүү дэлгэрэнгийг үзнэ үү.

Банкны системийн хувьд онцлох үйл явдлуудын нэг нь Төрийн банк болон Голомт банк хоёр банк анх удаа олон нийтэд хувьцаагаа санал болгосон юм. Банкны тухай шинэ хуулийн дагуу 2023 оны 6-р сарын эцэс гэхэд системийн нөлөө бүхий 5 банк нээлттэй хувьцаат компани болох үүрэгтэй.



## **2.2 Валютын арилжаа**

Гол гадаад валют болох Ам.доллар болон Евро зэрэг нь Монгол Улсын ихэнх бизнесийн төлбөр тооцоонд ашиглагдаж, суурь эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг. Доорх хүснэгт нь Монгол Улсын Төв Банкнаас зарласан Ам.доллар болон Еврогийн төгрөгтэй харьцах ханшийг харуулав.

<b>Огноо</b>	<b>Ам.доллар</b>	<b>Евро</b>
2022 оны 12 сарын 31	3,444.60	3,669.02
2021 оны 12 сарын 31	2,848.80	3,222.99
2020 оны 12 сарын 31	2,849.51	3,495.78
2019 оны 12 сарын 31	2,733.52	3,061.00
2018 оны 12 сарын 31	2,642.92	3,028.65

## **3 Тайлан бэлтгэх үндэслэл**

### **3.1 Ерөнхий зарчмууд**

Банкны эдгээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)-ын дагуу түүхэн бодит өртөг дээр үндэслэн бэлтгэгдсэн бөгөөд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ (“ААБҮЦ”)-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хэрэглүүр болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (“БДОБҮЦ”)-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хэрэглүүрүүдийн өөрчлөгдсөн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь бодит үнэ цэнэд суурилсан. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг Тодруулга 4-т толилуулав. Эдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь бүх тайлант жилүүдэд тасралтгүй мөрдөгдөн ирсэн. Тодруулга 5-аас харна уу.

Банк нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтөлдөг. Банкны эдгээр санхүүгийн тайлангууд нь СТОУС-тай бүх материаллаг зүйлсийн хувьд нийцэхийн тулд шаардлагатай бол залруулгуудыг хийж, нягтлан бодох бүртгэлийн суурийн дагуу бэлтгэгдсэн.

### **3.2 Бүртгэлийн болон тайлагналын валют**

Банкны бүртгэлийн мөнгөн тэмдэгт нь түүний үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн орчны үндсэн мөнгөн тэмдэгт байна. Банкны бүртгэлийн болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг юм. Эдгээр санхүүгийн тайлангуудад өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх үзүүлэлтүүд мянгачлан илэрхийлэгдсэн.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж**

Банк нь эдгээр санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүдэд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнд нөлөөлөх тооцоолол болон таамаглалыг хийдэг. Удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх тухайн нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт зэрэг бусад хүчин зүйлүүдэд үндэслэдэг чухал тооцоолол дүгнэлтүүд нь байнга дахин хянагдаж байдаг. Удирдлага нь мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэрэгжүүлэхдээ тооцооллоос гадна тодорхой дүгнэлт хийдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд хамгийн мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд мэдэгдэхүйц тохируулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлс хамаарна. Үүнд:

#### **3.3.1 Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт**

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (“ХБЭА”)-ын хэмжилт нь аргачлал, загвар болон өгөгдлийн орц зэргийн сонголтыг өөртөө багтаадаг чухал тооцоолол юм. ХБЭА-ын хэмжилтийн аргачлалын дэлгэрэнгүйг Тодруулга 38-аас харна уу. Дараах бүрэлдэхүүн хэсгүүд нь эрсдэлийн алдагдлын санд ихээхэн нөлөө үзүүлдэг:

- ХБЭА-ын үнэлгээний зорилгоор санхүүгийн хөрөнгийг ангилах;

### 3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)

- ХБЭА-ын үнэлгээний түвшинг тусгай хэрэглүүрийн эсвэл багц хэрэглүүрийн суурьт үндэслэн тодорхойлох;
- Банкны хэрэглэсэн дефолтын тодорхойлолт;
- тусгай үнэлгээний зээлийн эрсдэлийн зэрэглэлийг дефолтын магадлалд (PD) хуваарилах дотоодын зээлийн үнэлгээний загвар боловсруулах, ашиглах;
- санхүүгийн хэрэглүүрүүд болон зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэгтэй холбоотой дефолт болох үеийн үлдэгдлийг ("EAD") үнэлэхэд ашигладаг дотоод загварыг боловсруулах, ашиглах;
- барьцаа хөрөнгийг үнэлэхэд гарсан дүгнэлтийг багтаасан дефолт бий болгох алдагдал ("LGD")-ын үнэлгээ;
- зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг үнэлэх шалгуур нөхцөл;
- макро эдийн засгийн хэтийн төлөв, тэдгээрийн магадлалын жинлэсэн тооцооллын хувилбар сонголтууд.

Банк нь ХБЭА-ыг хэмжих зорилгоор макро эдийн засгийн таамаглалын загвар зэрэг ирээдүйд чиглэсэн хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдээллийг ашигласан. 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар ХБЭА-ын тооцоололд хамааралтай хамгийн хэрэглэгдэхүйц ирээдүйд чиглэсэн таамаглал болон магадлалын жинлэгдсэн хувиудыг дор үзүүлэв:

Өгөгдөл	Хувилбар	Жинлэгдсэн хувь	Таамаглалууд:		
			2022	2023	2024
ДНБ-ний өсөлт	Суурь	67.5%	2.8%	5.6%	5.0%
	Дээд	18.5%	3.3%	6.8%	6.6%
	Доод	14.0%	1.6%	-1.5%	2.9%
Инфляцийн хувь	Суурь	67.5%	12.2%	10.4%	7.1%
	Дээд	18.5%	11.1%	8.9%	7.0%
	Доод	14.0%	13.4%	12.7%	8.4%
Төг/Ам.дол/Жилийн өсөлт/	Суурь	67.5%	20.9%	6.9%	6.8%
	Дээд	18.5%	20.3%	5.0%	4.7%
	Доод	14.0%	22.7%	7.2%	7.5%
Зээлийн хүү	Суурь	67.5%	15.4%	17.7%	17.1%
	Дээд	18.5%	15.4%	17.2%	16.8%
	Доод	14.0%	15.4%	18.4%	18.3%

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх таамаглал болон магадлалын хувиудыг дор үзүүлэв:

Өгөгдөл	Хувилбар	Жинлэгдсэн хувь	Таамаглалууд:		
			2022	2023	2024
ДНБ-ний өсөлт	Суурь	65%	5.5%	6.4%	6.9%
	Дээд	18%	10.1%	7.12%	8.03%
	Доод	17%	1.7%	1.9%	3.4%
M2 /Жилийн өсөлт/	Суурь	65%	10.3%	0.7%	7.8%
	Дээд	18%	9.8%	1.9%	7.1%
	Доод	17%	11.0%	-0.8%	8.7%
Төг/Ам.дол/Жилийн өсөлт/	Суурь	65%	2.4%	1.1%	-3.2%
	Дээд	18%	5.0%	-5.7%	-1.5%
	Доод	17%	1.0%	6.3%	-1.3%
Зээлийн хүү	Суурь	65%	14.7%	14.9%	15.5%
	Дээд	18%	14.8%	15.1%	15.9%
	Доод	17%	14.6%	14.7%	15.0%

Банк нь 2021 онтой харьцуулахад магадлалын хувилбарын суурь хувийг нэмэгдүүлж, доод хувийг бууруулсан нь экспортын нөхцөл байдал сайжирсантай холбоотой. 2021 оны эцэс гэхэд Монгол Улс нийт 15 сая тонн нүүрс экспортолсон бол 2022 онд 30 гаруй сая тонн болсон нь Монголын эдийн засаг сэргэж эхэлснийг харуулж байна. ОУВС-аас Монголын эдийн засгийн сэргэлтийн өөрчлөлтийг тусган аравдугаар сард 1%-иас 2.5% хүртэл өсгөсөн.

### **3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)**

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)**

##### **3.3.2 Эргэлтийн зээлийн хэрэгслүүд (жишээ нь, зээлийн карт, овердрафт)**

Зарим зээлийн хувьд Банкны эрсдэлийн алдагдалд өртөх магадлал нь зээлийн гэрээний хамгийн их хугацаанаас хэтэрч болно. Энэ нь зээл болон зээлийн шугамын ашиглагдаагүй үлдэгдлийн аль алиныг агуулдаг бөгөөд зээлийн эргэн төлөлтийг шаардах, ашиглагдаагүй шугамыг цуцлах зэрэг Банкны гэрээгээр олгогдсон эрх нь зээлийн алдагдалд өртөх эрсдэлийг хязгаарладаггүй.

Ийм зээлүүдийн хувьд Банк зээлийн эрсдэлд өртөж болох хугацааны туршид хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тооцоолдог бөгөөд зээлийн эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг бууруулахгүй. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд үнэлгээ шаардагддаг. Удирдлага нь энэхүү тохиолдолд хамаарах жижиглэнгийн болон арилжааны зээлийг тодорхойлохдоо үнэлгээ хийсэн.

Банк энэхүү онцгой тохиолдлыг дараах шинж чанар бүхий зээлүүдэд хэрэглэсэн: (а) тогтоосон хугацаа эсвэл эргэн төлөлтийн хуваарь байхгүй, (б) зээлийн гэрээг цуцлах зээлийн эрсдэлийн удирдлагын өдөр тутмын ажил нь практикт хэрэгждэггүй бөгөөд гэрээг Банк зээлийн эрсдэлийн түвшин нэмэгдэж байгааг мэдсэн тохиолдолд зөвхөн цуцалдаг, (в) зээлийн багцын түвшинд хянагддаг. Цаашилбал, Банк зээлийн эхлэх үе болон эргэн төлөгдөх хугацаа зэргийг оруулан хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжих хугацааг тодорхойлохдоо үнэлгээ хийдэг.

Банк нь дараах түүхэн мэдээлэл болон туршлагыг авч үзсэн: (а) Банк нь хэзээ зээлд хамгийн сүүлд томоохон өөрчлөлт бий болсон зэргийг харгалзан ижил төстэй зээлийн зээлийн эрсдэлд өртсөн хугацааг үнэлэн зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн эхэн үед тодорхойлдог, (б) зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлттэй ижил төстэй санхүүгийн хэрэглүүрүүдийн дефолтын хугацаа, (в) зээлийн эрсдэлийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа (жишээлбэл, ашиглаагүй зээлийн шугамын хэмжээг бууруулах эсвэл зогсоох), урьдчилгаа төлбөрийн хувь болон дуусгавар хугацааг бий болгох бусад хүчин зүйлүүд. Эдгээр хүчин зүйлийг харгалзан үзэхдээ Банк зээлийн багцыг дэд бүлгүүдэд хувааж, түүхэн мэдээлэл, туршлага болон ирээдүйн холбогдох мэдээлэлд үндэслэн хамгийн их хамааралтай хүчин зүйлсийг ашигладаг.

##### **3.3.3 Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (“SICR”)**

Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохын тулд Банк тайлант үеийн эцэст санхүүгийн хэрэглүүрийн бүх хугацаан дахь дефолт болох эрсдэл болон анх хүлээн зөвшөөрөх үеийн дефолт болох эрсдэлийг харьцуулна. Үнэлгээгээр тайлант үеийн эцэст тодорхой нэг зээлийн эрсдэлийн түвшинд хүрэх гэхээсээ илүү зээлийн эрсдэлийн харьцангуй өсөлтийг нь авч үздэг. Банк бүхий л боломжит ашиглаж болохуйц бэлэн байгаа ирээдүйд чиглэсэн мэдээллийг хэт их зардал, хүчин чармайлт гаргалгүйгээр авч үздэг.

Банк нь зөрчил дутагдал болон зээлийн эрсдэлийн үнэлгээнд хэрэглэх ирээдүйд чиглэсэн мэдээллээс өмнө зээлийн эрсдэлийн өсөлтийн төлөв байдлын үзүүлэлтүүдийг тухайн хэрэглүүр эсвэл багцын түвшинд тодорхойлдог. SICR-ийг тодорхойлохын тулд удирдлага нь үнэлгээнд үндэслэсэн тодорхой шалгуурыг авч үздэг. Тодруулга 38-аас харна уу. SICR-ийн шалгуур үзүүлэлтүүд:

- Бизнесийн болон жижиг дунд бизнесийн зээлийн хувьд 30 хоногоор хугацаа хэтэрсэн.
- Нөхцөл өөрчилсөн статустай;
- Монголбанкны “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу эрсдэлийн ангилал нь “Анхаарал хандуулах” гэж ангилсан;
- Дефолт болсон статустай.

Хэрэв харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны ХБЭА-ыг хугацааны турш дахь ХБЭА (Үүнд: одоогийн байдлаар 12 сарын ХБЭА-аар хэмжигдэх 1-р шатлалд байгаа зээлүүд орно)-аар тооцсон бол 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар ХБЭА-ын сан нь 4,488,994 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 12,540,769 мянган төгрөг)-өөр нэмэгдэх байсан. 2021 оноос буурсан нь 2022 онд барьцаа хөрөнгө, эргэн төлөлтийн хувь зэргийг багтаасан ECL тооцооллын үзүүлэлтүүд сайжирсантай холбоотой.

### 3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)

##### 3.3.4 Бизнес загварын үнэлгээ

Бизнес загварт үндэслэн санхүүгийн хөрөнгийг ангилна. Удирдлага бизнес загварын үнэлгээг хийхдээ санхүүгийн хэрэглүүрүүдийн багц болон ижил байдлын түвшинг тодорхойлохдоо үнэлэлт өгсөн. Борлуулалтын гүйлгээг үнэлэхдээ Банк нь түүхэн давтамж, цаг хугацаа болон үнэ цэнэ, борлуулалтын зорилго, ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны тухай хүлээлт зэргийг авч үздэг. Зээл чанаргүйдсэнээс үүдэн гарах боломжит алдагдлыг багасгах зорилготой борлуулалтын гүйлгээ нь “цуглуулах зорилгоор эзэмших” бизнесийн загвартай таарч байна. Зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хамааралгүй дуусгавар хугацаанаас өмнөх бусад борлуулалтууд ч мөн дангаараа болон бүлгээрээ олон давтамжтай биш эсвэл үнийн дүнгийн хувьд их биш гэдгийг харгалзан “цуглуулах зорилгоор эзэмших” бизнесийн загвартай таарч байна. Банк борлуулалтын гүйлгээний ач холбогдлыг борлуулалтын үнийг нь багцын ашиглалтын дундаж хугацаанд бизнес загварын үнэлгээнд хамаарах багцын өртөгтэй харьцуулах замаар үнэлдэг. Мөн түүнчлэн зөвхөн стрессийн тохиолдлын үед эсвэл Банкны хяналтаас гадуур нэг удаагийн үйл явдлын үр дүнд хийгдэж болох санхүүгийн хөрөнгийн борлуулалт нь байнга давтагддаггүй бөгөөд Банкны зүгээс таамаглах боломжгүй байх ба бизнесийн загварын зорилгын хувьд тохиолдлын гэж үзэх учир тухайн санхүүгийн хөрөнгийн ангилалд нөлөөлөхгүй.

“Цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмших” бизнес загвар нь гэрээт мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эзэмшдэг боловч хөрвөх чадварыг хангах, тодорхой нэг өгөөжид хүрэх, эсвэл тухайн хөрөнгийг санхүүжүүлэхэд ашигласан өр төлбөрийн хугацааг санхүүгийн хөрөнгийн хугацаатай нь уялдуулах гэх мэт зорилгоор худалдан борлуулах нь уг бизнес загварын зорилго юм.

Үлдэгдэл дүнгийн ангилалд борлуулснаас үүсэх мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор удирдаж байгаа санхүүгийн хөрөнгийн багцууд багтах бөгөөд жишээ нь, өмнө нь худалдан борлуулсан төлөвтэй байх ёстой. Гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах нь энэ бизнес загварын хувьд заримдаа тохиолддог.

Банк өрийн үнэт цаасны ойролцоогоор 82% (2021 оны 12 сарын 31: 91%) нь хөрвөх чадвартай багц гэж үзэн “цуглуулах ба борлуулах зорилгоор эзэмших” ангилалд багтаж, үлдсэнийг нь зөвхөн стрессийн тохиолдлын үед зарагдах үнэт цаасууд гэж үзсэн учир “цуглуулах зорилгоор эзэмших” ангилалд оруулсан.

Банк нь бүх төрлийн зээлийн бизнес загварыг үнэлсэн ба Монголын ипотекийн корпораци ХХК (“МИК-ОССК” ХХК)-д буцаах үүрэггүй худалдах ипотекийн зээлийн багц болон Үнэт цаасны санхүүжилтийн корпораци ХХК (“ҮЦСК” ХХК)-д худалдах ЖДҮ-ийн зээлийн багцаас бусад зээлүүд нь “цуглуулах зорилгоор эзэмших” гэсэн бизнес загварыг хангаж байгаа гэж дүгнэсэн.

##### 3.3.5 Мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй эсэх үнэлгээ (“ЗХҮТ”)

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлт (“ЗХҮТ”)-өөс бүрдэж буй эсэхийг тодорхойлоход үнэлэлт өгөх шаардлагатай.

Банк нь гэрээний хугацаа эсвэл мөнгөн урсгалын дүнг өөрчлөх боломжтой гэрээний заалтуудыг тодорхойлж, дүгнэлт хийсэн. Зээлийн хугацаанаас өмнөх эргэн төлөлт болон урьдчилгаа төлбөрийн дүн нь хуримтлагдсан хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэх бөгөөд нэмэлтээр гэрээг хугацаанаас өмнө дуусгахтай холбоотой тодорхой хэмжээний нөхөн олговор авдаг тохиолдолд уг зээл нь ЗХҮТ-ийн шалгуурыг хангана. Хөрөнгийн үндсэн дүн нь дараа үеийн үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хассан анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ юм. Жишээ нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан тодорхойлсон хүүгийн цэвэр дүн.

Үндсэн төлөлтийг үл харгалзан стандарт нь мөн ЗХҮТ шалгуурыг хангах дараах нөхцөлүүдтэй урьдчилсан эргэн төлөлттэй хэрэглүүрүүдийг хүлээн зөвшөөрдөг: (i) урамшуулал эсвэл хямдруулалттай үүссэн хөрөнгө, (ii) хуримтлагдсан хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэх, мөн нэмэлтээр гэрээг хугацаанаас өмнө дуусгахтай холбоотой тодорхой хэмжээний нөхөн олговор

### **3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)**

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)**

авдаг урьдчилгаа төлбөр, (iii) урьдчилгаа төлбөрийн бодит үнэ цэнэ нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үед материаллаг бус байх. ЗХҮТ шалгуурыг хангаагүй хэрэглүүрүүд ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. Орон сууц болон уул уурхайн бус экспортлогчид, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй санхүүгийн хэрэглүүрүүдтэй холбоотой.

Банкны зээлийн гэрээ нь Банктай дахин өөр гэрээ хэлцэл байгуулах эсвэл тодорхой шалгуурт хүрсэн тохиолдолд хүүний түвшинг бууруулахад чиглэсэн заалтыг агуулдаг. Үүнд: Банкинд байршуулсан харилцах дансны гүйлгээг хамгийн бага байхаар хадгалах зэрэг орно. Тухайн хэрэглүүр дэх энэхүү заалт нь Банкны нийт ашгийн хэмжээг бууруулахгүй болон зээлийн үндсэн шинж чанарыг алдагдуулахгүй бол мөнгөн урсгал нь ЗХҮТ-ийн шалгуурыг хангана гэж үздэг. Банк нь стандартын жишээг авч үзсэн бөгөөд уг заалт нь хууль тогтоомжоос үүдэн бий болсон ба гэрээний нэг хэсэг биш юм. Хэрвээ хууль тогтоомж өөрчлөгдвөл уг заалт нь цаашид хэрэгжихгүй (зарим орны хууль тогтоомжууд гэх мэт) буюу ЗХҮТ-ийн үнэлгээнд хамаарахгүй.

#### **3.3.6 Санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт**

Хэрэв санхүүгийн хөрөнгүүд гэрээгээр өөрчлөгдсөн үед (өөрөөр хэлбэл дахин тохиролцох гэх мэт) Банк уг өөрчлөлтийн ач холбогдлыг үнэлж, анхны хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх, шинэ хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлдэг. Энэхүү үнэлгээ нь ач холбогдол бүхий үнэлэмжийг шаарддаг нягтлан бодох бүртгэлийн холбогдох бодлогод тусгагдсан чанарын хүчин зүйлсэд үндэслэдэг. Тухайлбал, Банк нь үнэ цэнийн бууралттай дахин тохиролцсон зээлийг үл хүлээн зөвшөөрөх, шинээр хүлээн зөвшөөрөгдсөн зээлийг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед нь үнэ цэнийн бууралттай хэмээн тооцох эсэхийг шийдэхэд үнэлэмжийг ашигладаг. Хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт нь эрсдэл болон өгөөжөөс шалтгаална. Үүнд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний (үүнд гэрээний мөнгөн гүйлгээ орохгүй) өөрчлөгдөх боломж, уг өөрчлөлтийн үр дүнд бий болсон зөрүү гэх зэрэг орно. Удирдлага нь гэрээний өөрчлөлтийг харгалзан тухайн нөхцөл байдал бүрд оруулах өөрчлөлтийг үнэлдэг бөгөөд эдгээр зээлийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэл, өгөөж нь өөрчлөгдөөгүй гэж тодорхойлсон. Тиймээс бүх өөрчлөлтийг хийхдээ эдгээр зээлүүдийг бүртгэлээс хасаагүй эсвэл үнэ цэнэ нь буурсан ангиллаас дахин ангилаагүй болно.

#### **3.3.7 Хөрөнгийг данснаас хасах бодлого, журам**

Банк нь санхүүгийн хөрөнгийн төлбөрийн эргэн төлөгдөх үйл ажиллагаа дуусгавар болсон, эргэн төлөгдөх үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь акталдаг. Энэхүү үндэслэлийг хийхэд ашиглагдах мөнгөн гүйлгээг тодорхойлох нь үнэлгээ шаардагддаг. Удирдлага нь дараах тохиолдлуудад эргэн төлөгдөх үндэслэлгүй хэмээн үздэг. Үүнд: зээл нь шүүхийн шийдвэрээс хойш хамгийн багадаа 180 хоногийн хугацаа хэтэрсэн, татан буугдсан эсвэл дампуурлаа зарлаж буй тохиолдолд, зээлийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүнийг шилжүүлэн авах зардлаас бага үед, хууль сахиулах үйл ажиллагаа бүрэн дууссан гэх мэт.

#### **3.3.8 Холбоотой талын ажил гүйлгээний анхны хүлээн зөвшөөрөлт**

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Банк нь холбоотой талуудтай ажил гүйлгээ хийдэг. СТОУС 9 нь санхүүгийн хэрэглүүрийг тэдгээрийн бодит үнэ цэнэд суурилан анхны хүлээн зөвшөөрөлтөөр бүртгэхийг шаарддаг. Энэхүү ажил гүйлгээг зах зээлийн эсвэл зах зээлийн бус (өөрөөр хэлбэл энэхүү ажил гүйлгээтэй холбоотой идэвхтэй зах зээл байхгүй) хүүтэй уялдсан эсэхийг тодорхойлоход үнэлгээ хийдэг. Энэхүү үнэлгээнд өөр бусад хамааралгүй этгээдтэй хийсэн ижил төрлийн ажил гүйлгээний үнийн дүн болон үр ашигт хүүгийн шинжилгээг ерөнхий зарчим болгодог. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний нөхцөл болон дансдын үлдэгдлийг тодруулсан Тодруулга 44-өөс харна уу.

### **3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)**

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)**

##### **3.3.9 Барилга байгууламж болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ**

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг гүйлгээний зардлыг оролцуулан анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч, дараа нь тайлант хугацааны эцэст зах зээлийн нөхцөл байдлыг үндэслэн бодит үнэ цэнээр дахин хэмждэг. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ гэдэг нь гүйлгээний зардлыг хасахгүйгээр, үйл ажиллагааны хэвийн нөхцөлд хөрөнгийг борлуулахад авах үнэ юм.

Банкны хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг ижил байршил, адил төрлийн үл хөдлөх хөрөнгийг үнэлж байсан туршлагатай хараат бус мэргэжлийн хөрөнгийн үнэлгээчний хийсэн үнэлгээнд тулгуурлан тодорхойлно. Түрээсийн орлогыг тухайн жилийн бусад үйл ажиллагааны орлогод бүртгэнэ. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарзыг тухайн жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч тусад нь тайлагнана. Бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан таамаглал ба үнэлгээний аргыг Тодруулга 42-д дурдсан.

##### **3.3.10 Түрээсийн хугацааны тодорхойлолт**

Банк оффисын барилгыг гэрээний дагуу гуравдагч этгээдээс түрээслэдэг ба гэрээний хугацаа дуусахаас өмнөх 5-30 хоногийн дотор талууд өөрөөр тохиролцоогүй тохиолдолд түрээсийн гэрээг ижил нөхцөлөөр сунгасанд тооцдог. Банк түрээсийн хугацааг тодорхойлохдоо түрээсийн хугацааг цуцлахад гарч болзошгүй торгууль, түрээсийн сайжруулалт, нүүлгэн шилжүүлэх өртөг мөн уг түрээсийн байрны Банкны үйл ажиллагаан дахь ач холбогдол зэргийг харгалзан үздэг. Үүний үр дүнд хамгийн их ач холбогдолтой оффисын барилгуудыг түрээслэх хугацаа нь 1-10 жилийн хугацаатай байна.

##### **3.3.11 Засгийн Газар, Монголбанк, төрийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн эх үүсвэр**

Банк нь Монгол Улсын Засгийн Газрын байгууллагууд (Монгол Улсын Хөгжлийн Банк, Монголбанк г.м), төрийн өмчит байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас урт хугацаат санхүүжилтийг хэвийн зээлийн хүүтэй ижил хүүгээр авдаг бөгөөд тус зээлийн хүү нь Банкны бусад зээлдүүлэгчдээс авдаг зээлийн хүүгээс доогуур байж болзошгүй. Ийм санхүүжилтийн үр дүнд Банк эдгээр эх үүсвэрүүдийг зээлдэгчийн тодорхойлсон зорилтот харилцагчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлүүлэх боломжтой. Удирдлага эдгээр хэрэглүүрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед олз, гарз үүсэх эсэхийг авч үзсэн. Ажил гүйлгээнүүд нь холбоогүй талуудтай хийгддэг тул удирдлагын үнэлэлтээр эдгээр эх үүсвэрүүд болон холбогдох зээл олголтууд нь зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн үед нь олз, гарз үүсэхгүй гэж дүгнэсэн. Энэ үнэлэлтийг хийхдээ удирдлага эдгээр хэрэглүүрүүд нь үндсэн зах зээлийг илэрхийлдэг гэж үзэж байгаа.

Энэхүү удирдлагын үнэлэлт нь мөн Засгийн газраас хэрэгжүүлж буй орон сууцны зээлийн хөтөлбөрийн хувьд жилийн 1%, 2% болон 4%-ийн хүүтэй Монголбанкнаас авсан эх үүсвэртэй хамааралтай ба орон сууцны зээлийг Монголбанкны тодорхойлсон жилийн 5%, 6% болон 8%-ийн хүүгийн хөнгөлөлттэй хувь хэмжээгээр санхүүжүүлэхэд ашиглагдаж байгаа болно.

Засгийн Газар, Монголбанк, төрийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас зээлээр авсан эх үүсвэрүүд нь 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 491,914,382 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 395,013,299 мянган төгрөг)-ийн дүнтэй байсан (Тодруулга 22-оос харна уу).

### 3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)

##### 3.3.12 Монголын ипотекийн корпораци (МИК)-ийн орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас (ипотекийн зээлийн багцыг үнэт цаасжуулах ажил гүйлгээ)

2022 онд банк 4 удаагийн МИК-ийн орон сууцны зээлийн багц худалдаж, үнэт цаасжуулах гүйлгээнд оролцсон. 5%, 6% болон 8%-ийн хүүтэй орон сууцны зээлийн багцыг Монголын Ипотекийн Корпораци ОССК-ийн 100%-ийн эзэмшлийн компани болох МИК ТЗК29, МИК ТЗК30, МИК ТЗК31, МИК ТЗК32 тусгай зориулалтын компанид зарж, оронд нь 1.0%, 4.5%, 9.0%, 13.0%-ийн хүүтэй, ипотекийн зээлээр баталгаажсан давуу эрхтэй бонд болон 9.0%, 10.5%-ийн хүүтэй ипотекийн зээлээр баталгаажсан энгийн бонд хүлээн авсан.

Дээрх зээлийн багцыг МИК-ийн тусгай зориулалтын компанид үүрэггүй худалдсан. Давуу эрхтэй бондын үндсэн төлбөрийг бүрэн эргүүлэн төлөгдсөний дараа энгийн бондын үндсэн төлбөрийг авах боломжтой ба давуу эрхтэй бонд эзэмшигчид нь төлбөрийн хувьд давуу эрхтэй байдаг. Банк нь зарагдсан зээл тус бүрийн хувьд үйлчилгээ үзүүлэгч гэгдэх ба харилцагчаас зээлийн төлбөрийг цуглуулж, үйлчилгээний шимтгэлд цуглуулсан төлбөрөөс 2.5%-ийн шимтгэл авна. МИК ТЗК-уудад үлдсэн цэвэр хөрөнгө нь (хэрэв байгаа бол) МИК-ТЗК (тухайлбал, МИК ОССК ХХК)-ийн хувьцаа эзэмшигчид хамаарагдана.

Түүнчлэн, МИК-ТЗК-ийн цэвэр хөрөнгө нь дутсан тохиолдолд үүнийг давуу эрхтэй болон энгийн бонд эзэмшигчид МИК-д буцаах нөхцөлгүйгээр хариуцна (төлбөр болон давуу эрхийн хувьтай тэнцүү хэмжээгээр). Энэхүү гэрээний дагуу Банкны эзэмшиж буй давуу эрхтэй бонд нь Монголбанкнаас анх 5%, 6%, 8%-ийн хүүтэй орон сууцны зээлийг санхүүжүүлэх зорилгоор авсан 1%, 2%, 4%-ийн хүүтэй эх үүсвэрийг буцаан төлөхөд ашиглагдана.

Удирдлага эдгээр зээлүүдийг СТОУС-д заасан данснаас хасах шаардлагыг хангасан эсэхийг үнэлж үзсэн. Банк агент шиг зээлийн багцнаас мөнгө хүлээн авсан боловч эдгээр 5%, 6% болон 8%-ийн орон сууцны зээлийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ шилжүүлснээр бүх эрсдэл өгөөжийг давхар шилжүүлсэн гэж удирдлагаас дүгнэсэн.

Тус шийдвэрийг гаргахдаа удирдлага банк бүрийн бүлгийн буюу ерөнхий эрсдэлийн багц нь өөр өөр зээлдэгч, үүрэг хүлээгч, ипотекийн хөрөнгийн байршил зэргээс хамаараад зарсан зээлийн эрсдэлийн багцаас эрс ялгаатай гэж үзсэн. Мөн эдгээр хэрэглүүрийн хувьд анх хүлээн зөвшөөрөлтийн үед олз, гарз үүсэх эсэхийг тооцсон.

Эдгээр хэлцлийг зах зээлийн оролцогч талууд сайн дураараа хийсэн ба эдгээр хэрэглүүрүүд нь зах зээлийн хүүгээр тооцогдсон тул олз, гарзыг анхны хүлээн зөвшөөрөлтөнд бүртгэх шаардлагагүй гэж удирдлага үнэлсэн. Энэхүү үнэлгээг хийснээр удирдлага мөн эдгээр хэрэглүүрүүд нь үндсэн зах зээлийг төлөөлнө гэж үзэж байна.

##### 3.3.13 Үнэт цаасны санхүүжилтийн корпораци (ҮЦСК)-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

2022 онд банк 3 удаагийн ҮЦСК-ийн репо зээлийн багц худалдаж, үнэт цаасжуулах гүйлгээнд оролцсон. 10-10.5%-ийн хүүтэй уул уурхайн бус экспорт, жижиг дунд үйлдвэрлэгчид, боловруулах үйлдвэрлэлийн зээлийн багцыг Үнэт цаасны санхүүжилтийн корпораци ХХК-ийн 100%-ийн эзэмшлийн компани болох ҮЦСК ТЗК2, ҮЦСК ТЗК3, ҮЦСК ТЗК4, тусгай зориулалтын компанид зарж, оронд нь 9.0%, 9.5%-ийн хүүтэй, хөрөнгөөр баталгаажсан энгийн болон давуу эрхтэй бонд хүлээн авсан.

Дээрх зээлийн багцыг ҮЦСК-ийн тусгай зориулалтын компанид үүрэггүй худалдсан. Давуу эрхтэй бондын үндсэн төлбөрийг бүрэн эргүүлэн төлөгдсөний дараа энгийн бондын үндсэн төлбөрийг авах боломжтой ба давуу эрхтэй бонд эзэмшигчид нь төлбөрийн хувьд давуу эрхтэй байдаг. Банк нь зарагдсан зээл тус бүрийн хувьд үйлчилгээ үзүүлэгч гэгдэх ба харилцагчаас зээлийн төлбөрийг цуглуулж, үйлчилгээний шимтгэлд цуглуулсан төлбөрөөс 0.5%-ийн шимтгэл авна. Түүнчлэн,

### **3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)**

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)**

ҮЦСК-ТЗК-ийн цэвэр хөрөнгө нь дутсан тохиолдолд үүнийг давуу эрхтэй болон энгийн бонд эзэмшигчид ҮЦСК-д буцаах нөхцөлгүйгээр хариуцна (төлбөр болон давуу эрхийн хувьтай тэнцүү хэмжээгээр).

Удирдлага эдгээр зээлүүдийг СТОУС-д заасан данснаас хасах шаардлагыг хангасан эсэхийг үнэлж үзсэн. Банк агент шиг зээлийн багцнаас мөнгө хүлээн авсан боловч эдгээр 10-10.5%-ийн зээлийн мөнгөн гүйлгээг хүлээн авах эрхээ шилжүүлснээр бүх эрсдэл өгөөжийг давхар шилжүүлсэн гэж удирдлагаас дүгнэсэн.

Эдгээр хэлцлийг зах зээлийн оролцогч талууд сайн дураараа хийсэн ба эдгээр хэрэглүүрүүд нь зах зээлийн хүүгээр тооцогдсон тул олз, гарзыг анхны хүлээн зөвшөөрөлтөнд бүртгэх шаардлагагүй гэж удирдлага үнэлсэн. Энэхүү үнэлгээг хийснээр удирдлага мөн эдгээр хэрэглүүрүүд нь үндсэн зах зээлийг төлөөлнө гэж үзэж байна.

##### **3.3.14 Ханшийн тэгшитгэлийн зөрүү болон үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хойшлогдсон татвар**

Одоо мөрдөгдөж буй татварын хууль тогтоомж болон холбогдох татварын нэмэлт хууль тогтоомжид үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх олз, гарзад хойшлогдсон татвар хүлээн зөвшөөрөх талаар тусгагдаагүй байдаг. Холбогдох татварын хууль нь зөвхөн ханшийн тэгшитгэлийн олз, гарзын татварыг хэрхэн тооцох талаар тусгасан бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд зөвхөн гадаад валютын хэрэгжсэн ханшийн тэгшитгэлийн олзод татвар ногдуулах, хэрэгжсэн гарзыг татвар ногдуулах орлогоос хасах, хэрэгжээгүй олз, гарзыг хэрэгжих хугацаа хүртэл хойшлуулж бүртгэх хэмээн заасан. Тиймээс үүсмэл санхүүгийн хэрэглүүр (урт хугацаат свопийг оруулсан)-ийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хэрэгжээгүй олз гарз болон олон улсын санхүүгийн байгууллагаас авсан урт хугацааны эх үүсвэрээс үүсэх хэрэгжээгүй ханшийн тэгшитгэлийн зөрүүг хүлээн зөвшөөрөх хүртэл (зээлийн дуусгавар болох хугацаа хүртэл) татвар ногдохгүй орлого эсвэл татвараас хасагдахгүй зардал гэж үздэг ба дээрх хэрэгжээгүй олз, гарз нь татвар ногдох эсвэл хасагдах түр зөрүүг үүсгэдэг. 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хүлээн зөвшөөрсөн цэвэр хойшлогдсон татварын өр төлбөр нь 50,744,204 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 38,857,755 мянган төгрөг) байна. Дэлгэрэнгүйг тодруулга 31-ээс харна уу.

Дээрх шийдвэрийг гаргахдаа банкны удирдлага СТОУС-ын үндсэн зарчмууд, тухайн гүйлгээний шинж чанар, дээрх ажил гүйлгээтэй ижил төрлийн гүйлгээг татварын хуулиар зохицуулсан байдал (жишээ нь: гадаад валютын ажил гүйлгээний олз, гарз болон гадаад валютаарх илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгийн ханшийн тэгшитгэлийн зөрүүтэй холбоотой татварын хууль гэх мэт) мөн татварын байгууллагын сүүлийн үеийн практик, өмнөх татварын шалгалтын дүгнэлт, банкны салбарт хэрэглэдэг татварын практикууд болон хэрэгжсэн, хэрэгжээгүй олз, гарзын хоорондын зөрүүг хэрхэн авч үзэх байдал зэрэг хүчин зүйлсийг тооцож үзсэн.

Татварын болон нэмэлт хууль тогтоомжид үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хувьд үүссэн хэрэгжээгүй болон хэрэгжсэн олз, гарзыг татварын зорилгоор хэрхэн авч үзэх талаар тусгайлан заагаагүй бөгөөд татварын зорилгоор бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олзыг хэрэгжсэн, хэрэгжээгүйгээр нь ялгахыг шаарддаг. Энэхүү шаардлагыг харгалзан үзсэний үндсэн дээр удирдлага нь татварын байгууллагын өөр байр суурьтай байж болох нөхцөл, нээлттэй дериватив поцизийн хэрэгжээгүй олзыг татвар ногдох орлого гэж бүртгэн нэмэлт татвар ногдуулах эсвэл татварыг бүртгэх эсвэл Банкны Нягтлан бодох бүртгэлийн бодлогоо (Тодруулга 4) эргэн хянах эрсдэлийг үнэлж дүгнэсэн.

Гадаад валютын деривативын үнэ цэнэд гарсан зарим өөрчлөлт нь хэрэгжээгүй олз, гарзыг илэрхийлэх бөгөөд өмнөх тайлант үеүдэд татвар ногдох орлого болон хасагдах зардал гэж бүртгэгдсэн холбогдох олз, гарзаас бусад хэрэгжээгүй олз, гарз нь түр зөрүү үүсгэдэг (Тодруулга 3 болон 31). Төв Банктай хийсэн урт хугацаат своп хэлцэл нь олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан ам.долларын урт хугацаат зээлийг төгрөг рүү хөрвүүлдэг своп хэлцэл юм.



### **3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)**

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)**

Орлогын албан татварын талаар дэлгэрэнгүй болон Монгол улсад мөрдөгдөж буй татварын хуулийн тодорхойгүй байдлыг Тодруулга 31-ээс харна уу.

##### **3.3.15 Монголбанкны журам болон СТОУС-ын зөрүүгээс үүдэлтэй хойшлогдсон татвар**

Банк нь СТОУС-ын дагуу үнэ цэнэ бууралтын сан байгуулахаас гадна Монголбанкны (Төв Банк) тайлагналын шаардлагын дагуу үнэ цэнэ бууралтын санг Монголбанк болон Сангийн яамны хамтарсан тушаалаар батлагдсан Активыг ангилал, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын дагуу зээлийн ангилалд үндэслэн байгуулдаг. Эдгээр журмын дагуу Банк нь харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны чанарыг хугацааны болон чанарын хүчин зүйлсэд үндэслэн тодорхойлдог. Хугацааны хүчин зүйлсэд хугацаа хэтэрсэн байдал (өөрөөр хэлбэл эргэн төлөлтийн хоцролт) гэх мэт хугацааны шинжтэй хүчин зүйлс хамаардаг. Харилцагчид олгосон зээл нь дараах байдлаар ангилагддаг: хэвийн, анхаарал хандуулах, чанаргүй. Чанаргүй зээл нь хэвийн бус, эргэлзээтэй болон муу гэсэн дэд ангиллаар ангилагддаг. Ангилал бүрд тусгайлан тооцсон хувийн дагуу эрсдэлийн санг байгуулдаг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу хэвийн зээлд байгуулсан эрсдэлийн сангийн зардлыг тайлант хугацааны татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал гэж үздэг. 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банк нь СТОУС-ын дагуу хэвийн зээлд байгуулсан үнэ цэнэ бууралтын эрсдэлийн сангийн дүнг тодорхойлсон бөгөөд СТОУС-ын дагуу үнэ цэнэ бууралтын эрсдэлийн санг үнэлэн, холбогдох үнэ цэнэ бууралтын эрсдэлийн сангийн зардлыг татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал хэмээн тайлагнасан.

Удирдлагын зүгээс хэвийн зээлийн эрсдэлийн сангийн зардал, түүний буцаалтын нягтлан бодох бүртгэл болон татварын тооцооллын талаар мөн Монголбанкны журам болон СТОУС-ын дагуу байгуулсан эрсдэлийн сангийн зөрүүнээс үүссэн татварын нөлөөллийг нарийвчлан үзсэн бөгөөд эдгээр нь татварын түр зөрүү үүсгэж, улмаар хойшлогдсон татварын хөрөнгө болох 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 4,776,735 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 3,691,282 мянган төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө)-ийг эдгээр санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн. Удирдлагын зүгээс хэвийн зээлийн санг буцаасантай холбоотой гарах орлогыг татвар ногдуулах орлого биш гэж үздэг бөгөөд хойшлогдсон татварын хөрөнгө нь ирээдүйд нөхөгдөх боломжтой байдаг.

Үүнээс гадна Монголбанкны журмын дагуу байгуулсан эрсдэлийн сан нь татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцогддог ба 2022 оны 12 сарын 31-ний өдөр болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар СТОУС-ын дагуу байгуулсан эрсдэлийн сангаас их байсан.

Татварын хууль тогтоомжид хэвийн зээлийн санг буцаасантай холбоотой орлогын тухай тусгайлан заагаагүй ба Монголын татварын хууль тогтоомжийг олон янзаар тайлбарладаг зэрэг нөхцөл байдлыг (Тодруулга 31) харгалзан үзвэл Татварын байгууллагаас уг орлогод албан татвар ноогдуулах байр суурьтай хандах магадлалтай тул уг хойшлуулсан татварыг буцаан авах боломжгүй байх магадлалтай гэж үзсэн.

Мөн дээр дурдсан Монголбанкны журмын дагуу 90-ээс дээш хоногийн хугацаа хэтрэлттэй зээлийн хүүгийн орлого нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөхгүй ба СТОУС-д уг хүүгийн орлогыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Татварын байгууллага нь Монголбанкны дээрх журмыг татвар суутгах орлого болон татвараас хасагдах зардлыг тооцохдоо мөрддөг тул дээрхтэй холбоотой СТОУС-ын дагуу санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн хүүгийн орлогыг татвар суутгахгүй орлого гэж үзэх буюу энэ нь татварын түр зөрүүг үүсгэнэ. Энэхүү хүүгийн орлогыг харилцагчаас авсны дараа татвар суутгах орлого гэж үзэн, татварын тайланд татвар ногдох орлого гэж хүлээн зөвшөөрнө.

### **3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)**

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)**

Үүнээс үүдэн Банк нь 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 9,370,561 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 11,852,602 мянган төгрөг)-ийн хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. Удирдлагын зүгээс Татварын байгууллагаас уг хүүгийн орлогод албан татвар ногдуулах байр суурьтай хандах магадлалтай, эсвэл Банкны татварын бүртгэлийг буруу гэж үзэн нэмэлт татвар ногдуулах эрсдэлтэй гэж үзсэн. Гэвч энэхүү санхүүгийн мэдээллийг тайлагнах өдрийн байдлаар мэдэгдэж буй мэдээлэл, татварын байгууллагын сүүлийн үеийн практик, өмнөх татварын шалгалтын дүгнэлт, Монгол Улсын Банкны салбарын татварын практикт үндэслэн Удирдлагын зүгээс дээр дурдсан эрсдэл бага гэж үзсэн. Орлогын албан татварын дэлгэрэнгүйг Тодруулга 31-ээс харна уу.

##### **3.3.16 Урт хугацаат дериватив хэрэглүүрийн бодит үнэ цэнэ**

Банк нь 2018 оноос эхлэн 2022 оны хооронд Монголбанкттай урт хугацаат гадаад валютын хүүний своп хэлцэл хийсэн. Эдгээр дериватив хэрэглүүр нь ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигддэг. Энэхүү хэлцэл нь 1-8 жилийн дуусгавар болох хугацааг хүүний түвшинтэй харьцуулан тооцсон томьёонд үндэслэсэн бөгөөд төгрөг, ам.долларын хооронд солилцох своп хэлцэл юм. Банк нь ийм төрлийн своп хэлцлийн бодит үнэ цэнийг үнэлэх үнэлгээний загвар, аргачлал боловсруулсан. Энэхүү загвар аргачлал нь бүхэлдээ зах зээлийн ашиглагдахуйц мэдээлэлд үндэслэгддэг. Банк нь 2-р түвшний үнэлгээний загварт үндэслэгдсэн своппийн бодит үнэ цэнийг үнэлдэг ба дериватив хэрэглүүрийн эхний өдрийн олзыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Удирдлагын зүгээс урт хугацаат гадаад валютын хүүний сповын бодит үнэ цэнийг хамгийн боломжит хэмжээнд тооцоолсон. Уг хэрэглүүрийн бодит үнэ цэнийн үнэлгээнд ашиглагдсан дэлгэрэнгүй мэдээлэл болон таамаглалыг Тодруулга 42-оос харна уу.

##### **3.3.17 Зах зээлийн хүүгийн түвшингээс доогуур олгосон бусад санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт**

СТОУС 9-д санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх дүн нь түүний бодит үнэ цэнэ байна гэж заасан. Санхүүгийн хэрэглүүр нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй үед зах зээлийн эсвэл зах зээлийн бус хүүгээр үнэлэгдсэн эсэхийг тодорхойлоход холбогдох үнэлгээг ашигладаг. Тус үнэлэлтийг хийхдээ холбоогүй талуудын хооронд хийгдсэн ижил төстэй ажил гүйлгээ болон үр ашигт хүүгийн хувь хэмжээний шинжилгээг ашиглана.

Зах зээлийн хүүний түвшингээс доогуур олгогдсон санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзыг тодорхойлохдоо удирдлага бэлэн байгаа мэдээлэлд тулгуурлан үнэлэлт хийдэг. Үүнд: Монголын арилжааны банкуудын зээлийн жинлэсэн дундаж хүү нь төгрөгөөр санхүүжүүлж байгаа зээлийн хувьд зах зээлийн хүүний түвшинтэй ойролцоо, үндэслэлтэй хүүг илэрхийлдэг.

##### **3.3.18 Санхүүгийн өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралт**

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн өмчлөх бусад хөрөнгө нь Банкны хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулах явцад хураан авсан 1 компанийн хувьцааг илэрхийлнэ.

Банкны зүгээс уг хөрөнгийг худалдах хэлэлцээрийг хийж байгаа бөөд бодит үнэ цэнийг гэрээний борлуулалтх санал болон өмнө нь хийгдсэн ижил төстэй гүйлгээнд үндэслэн тооцсон. Үүнтэй холбоотой 45,272,561 мянган төгрөгийн (2021: 30,337,628 мянган төгрөг) үнэ цэнийн бууралтыг 2022 онд хүлээн зөвшөөрсөн. (Тодруулга 18-аас харна уу).

### 3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)

##### 3.3.19 Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгө

2022 онд хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгө (Тодруулга 31) нь санхүүгийн болон санхүүгийн бус өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралттай холбоотой (Тодруулга 3.3.18). 2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний байдлаар хөрөнгө борлуулсан ч өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтыг ирээдүйд эргэж нөхөгдөх боломжгүй гэж үзсэн тул хойшлуулсан татварын боломжит хөрөнгийг 2022 оны 12 сарын 31-ны байдлаар хүлээн зөвшөөрөөгүй.

### 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Банкны эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй бол тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үе бүрд тууштай хэрэгжүүлсэн болно (Тодруулга 5-аас харна уу).

#### 4.1 Санхүүгийн хөрөнгө

Банк санхүүгийн хөрөнгүүдийн ангиллыг анхны хүлээн зөвшөөрөлтөөр тодорхойлдог. Анхны хүлээн зөвшөөрөлтөөрх санхүүгийн хөрөнгүүдийн ангилал нь тэдгээрийг олж эзэмших болсон зорилго болон тэдгээрийн шинж чанараас хамаарна. Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангиллаас хамааран тэдгээрийг дор тайлбарласны дагуу бодит үнэ цэнэ эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгадаг.

##### (i) Хэмжилтийн үндсэн нэр томъёо

*Бодит үнэ цэнэ* нь зах зээлд оролцогчдын хооронд хөрөнгө худалдах эсвэл өр төлбөр барагдуулах гүйлгээг хэмжилтийн өдөр зохион байгуулалттай явуулахад хүлээн авах эсвэл төлөх үнэ юм. Бодит үнэ цэнийн хамгийн тод жишээ бол идэвхтэй зах зээл дээрх үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө болон өр төлбөрийн хэлцлүүд нь үнийн мэдээллээр тогтмол хангахуйц түвшинд явагддаг зах зээлийг хэлнэ. Идэвхтэй зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжихдээ тухайн хөрөнгө болон өр төлбөрийн заасан үнэ болон тухайн байгууллагын эзэмшиж буй хэмжээгээр тооцдог. Зах зээлийн ердийн өдөр тутмын арилжааны хэмжээ нь эзэмшиж буй дүнгийн түвшинд хүрэхгүй бөгөөд позицийг нэг арилжаагаар худалдан борлуулах захиалга өгснөөр заасан үнэнд нөлөөлж болох юм.

Идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй санхүүгийн үүсмэл хэрэглүүр болон бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн багцыг хэмжихдээ бүлэг санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг ашиглана. Ингэхдээ хэмжилтийн өдрийн байдлаар зах зээлд оролцогч нарын хооронд хийсэн захиалгын хэлцлээр тухайлсан эрсдэлийн дүнгийн хувьд цэвэр урт позицийг (өөрөөр хэлбэл хөрөнгө) зарахад хүлээн авах үнэ эсвэл цэвэр богино позицийг (өөрөөр хэлбэл хөрөнгө) шилжүүлэхэд төлөх үнэнд суурилна. Энэ нь давтагдах байдлаар бодит үнэ цэнээр бүртгэгдсэн хөрөнгийн хувьд хамааралтай ба Банк (а) Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг зах зээлийн тодорхой эрсдэлийн хувьд эсвэл байгууллагын баримтжуулсан эрсдэлийн удирдлага болон хөрөнгө оруулалтын стратегийн дагуу тухайн харилцагч талын зээлийн эрсдэлийн хувьд удирддаг бол (б) Хөрөнгө болон өр төлбөрийн мэдээллийг эрх бүхий албан тушаалтнуудад мэдээлдэг бол (в) Зах зээлийн эрсдэл, тухайлбал, санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрөөс үүсэх тухайн зах зээлийн эрсдэлд (эсвэл эрсдэлүүд) өртөх хугацаа нь үндсэндээ ижил байдаг.

Удирдлагын зүгээс үнэлгээний аргачлал нь санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн үнэ цэнийг илүү нарийн тооцно гэж үзэж байна. Үнэ цэнийн тооцооллын гол өгөгдөлд эрсдэлгүй хүүнд суурилсан төгрөгийн дискаунт хүү, улсын эрсдэлийн нэмэгдэл, валютын эрсдэлийн нэмэгдэл, засгийн газрын үнэт цаасны хүүнд суурилсан ам.долларын дискаунт хүү, ам.долларын банк хоорондын захын хүүнд суурилсан ам.долларын суурь хүү, бодлогын хүүнд суурилсан төгрөгийн суурь хүү, тогтмол хүү ба Z тархалт зэрэг хувьсагчуудыг ашигладаг.

## 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

### 4.1 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Гадаад зах зээлийн мэдээлэл авах боломжгүй тохиолдолд санхүүгийн тодорхой хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцохдоо хорогдуулсан мөнгөн гүйлгээний загвар, сүүлийн үеийн сунгасан гарын зарчмын дагуу хийгдсэн хэлцэлд ашигласан загвар болон санхүүжигч талын санхүүгийн тайлан мэдээ зэрэг үнэлгээний аргачлалыг ашиглана. Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангилал тус бүрд үнэлэх ба эдгээр түвшин нь (i) Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно. (ii) Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд материаллаг боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) үнэлгээний аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ (iii) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (зах зээлээс шууд ашиглах боломжгүй өгөгдөлийг шаарддаг) үнэлгээг тодорхойлно. Бодит үнэ цэнийн ангилал дахь түвшингүүдийн хоорондын шилжүүлгийг тайлант хугацааны эцэст хийгдсэн гэж үзнэ. Тодруулга 42-оос харна уу.

*Гүйлгээний зардлууд* нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, худалдах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардал юм. Гүйлгээний зардалд агент (борлуулагч агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах байгууллага болон хөрөнгийн зах зээлийн байгууллагуудад төлсөн төлбөрүүд, мөн шилжүүлгийн татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн шимтгэл буюу хөнгөлөлт, санхүүжилтийн зардлууд, захиргааны дотоод буюу хадгалалтын зардлууд орохгүй.

*Хорогдуулсан өртөг* нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт, мөн үнийн аливаа нэмэгдэл буюу хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн дискаунтчилсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлан дахь тэнцэлд хамаарах хэсэгт дансны үнээр тусгасан болно.

*Үр ашигт хүүгийн арга* нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгахгаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм.

Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид хямдруулж санхүүгийн хэрэглүүрийн нийт дансны үнийг гаргаж авах хүүгийн хувь болно.

Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалыг хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтчлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал буюу хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Эдгээр урамшуулал, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд өгч авалцах бүх шимтгэл, хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно. Худалдаж авахад эсвэл шинээр олгоход үнэ цэнийн бууралттай ("POCI") санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед үр ашигт хүүний түвшинг зээлийн эрсдэлд тохируулахыг хэлнэ. Үүнд: анх хүлээн зөвшөөрөхдөө гэрээний төлбөрийн оронд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн тооцоолно.

#### (ii) Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хэрэглүүрийг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Бусад бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анх гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр бүртгэгддэг. Гүйлгээний үнэ нь анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо болдог. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарз нь бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л бүртгэгдэх бөгөөд үүнийг зөвхөн

## **4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

### **4.1 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)**

ижил төрлийн хэрэглүүрийг сүүлийн үед арилжсан талаарх зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэлд үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад бүртгэнэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүд болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хувьд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хүлээн зөвшөөрч, үр дүнг шууд бүртгэлийн гарзаар бүртгэдэг.

Зохицуулалт эсвэл зах зээлийн жишгээр тогтоогдсон ("хэвийн" борлуулалт болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л худалдан авалт болон борлуулалтыг арилжаа хийсэн өдөр буюу Банк тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн өдөр бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Банк тухайн хэрэглүүрийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

Банк идэвхтэй зах зээлд арилжаалагдаагүй урт хугацаат гадаад валютын хүүгийн СВОП хэлцэл болон гадаад валютын СВОП хэлцлийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо хямдруулсан мөнгөн урсгалын үнэлгээний аргачлалыг ашигладаг. Анхны хүлээн зөвшөөрөлтөөрх бодит үнэ цэнэ болон дараа үед тодорхойлсон дүнгийн хооронд зөрүү үүсч болно. Хэрэв үнэлгээний зөвхөн 1 эсвэл 2-р түвшний өгөгдлийг ашигладаг бол зөрүүг шууд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

#### **(iii) Ангилал болон дараа үеийн хэмжилт – хэмжилтийн ангилал**

Банк дараах хэмжилтийн ангиллаар санхүүгийн хөрөнгүүдийг ангилдаг: бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх, бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх болон хорогдуулсан өртгөөр. Санхүүгийн өрийн хэрэглүүрийн ангилал ба дараа үеийн хэмжилт нь дараах зүйлсээс хамаарна: (i) холбогдох хөрөнгүүдийн багцыг удирдах Банкны бизнес загвар ба (ii) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлог шинж.

#### **(iv) Ангилал болон дараа үеийн хэмжилт – бизнес загвар**

Банк мөнгөн урсгалыг бий болгохын тулд хөрөнгийг хэрхэн удирддаг болохыг бизнесийн загвар харуулдаг. Банкны зорилго нь: (i) зөвхөн хөрөнгийн гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах ("гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмших"), эсвэл (ii) хөрөнгийг борлуулснаас үүсэх мөнгөн гүйлгээ ба гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах ("гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмших") эсвэл хэрэв (i) ба (ii) алинд ч хамаарахгүй бол санхүүгийн хөрөнгийг "бусад" бизнесийн загварт ангилж, ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Бизнесийн загварыг үнэлгээний өдөр боломжит багцад зориулан тогтоосон зорилтондоо хүрэхийн тулд Банкны хийж буй үйл ажиллагааны талаарх бүх нотолгоонд үндэслэн Банкны хөрөнгийг (багцын түвшинд) тодорхойлно. Бизнесийн загварыг тодорхойлоход Банкны авч үздэг хүчин зүйлс нь багцын зорилго ба бүрэлдэхүүн, тухайн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хэрхэн цуглуулсан, эрсдэлийг хэрхэн үнэлж, удирдаж байсан, хөрөнгийн гүйцэтгэлийг яаж үнэлсэн, цалин хөлс, урамшууллын системд хэрхэн тусгагдсан талаар өнгөрсөн туршлагад үндэслэдэг. Санхүүгийн хөрөнгийн бизнес загварыг тодорхойлоход Банкны гаргасан шийдвэрийг тодруулга 3-аас харна уу.

#### **(v) Ангилал болон дараа үеийн хэмжилт – мөнгөн урсгалын онцлог**

Бизнес загвар нь хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших эсвэл хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон борлуулах зорилгоор хөрөнгийг эзэмших загвар бол Банк мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй (ЗХҮТ) эсэхэд үнэлгээ өгнө.

## **4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

### **4.1 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)**

Гэрээний мөнгөн урсгал нь ЗХҮТ-ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуугдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ Банк гэрээний мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд нийцтэй эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг авч үздэг. Гэрээний нөхцөлүүдэд эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх өөрчлөлтийг тусгасан байвал санхүүгийн хөрөнгө нь ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэж ангилагдана. ЗХҮТ-ийн үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа үед дахин хийгдэхгүй. Санхүүгийн хөрөнгийн хувьд ЗХҮТ-ийн тестийг хийхэд Банкны гаргасан шийдвэрийг тодруулга 3-аас харна уу.

#### **(vi) Дахин ангилал**

Тухайн багцыг удирдах бизнес загвар нь бүхэлдээ өөрчлөгдсөн тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийн дахин ангиллыг хийдэг. Дахин ангилал нь тухайн бизнес загвар өөрчлөгдсөнөөс хойш эхний санхүүгийн тайлангийн жилээс эхлэн хэрэгжинэ. Банк нь ямар нэг бизнес загвараа өөрчлөөгүй болно.

#### **(vii) ХБЭА-ын зээлжих эрсдэлийн сан**

Банк нь хорогдуулсан өртөг болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн өрийн хэрэглүүр болон зээл, санхүүгийн баталгаатай холбоотой хүлээгдэж буй алдагдлыг ирээдүйн таамаглалын нөхцөл байдалд суурилан үнэлдэг. Банк нь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг ("ХБЭА") хэмжиж, зээлжих эрсдэлийн хасагдуулгыг тайлант хугацаа бүрийн эцэст хүлээн зөвшөөрдөг.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт нь (i) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жинлэсэн дүн; (ii) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; болон (iii) тайлант хугацаа бүрийн эцэст өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн нөхцөл байдлын таамаглалын талаар хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээлэлд үндэслэнэ.

Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүрийг санхүүгийн байдлын тайланд ХБЭА-ын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр тайлагнана. Зээл болон санхүүгийн баталгааны хувьд ХБЭА-ын санг санхүүгийн байдлын тайланд өр төлбөр гэж тусад нь хүлээн зөвшөөрдөг. БДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн хувьд ХБЭА-ын хасагдуулгыг хассан хорогдуулсан өртгийн өөрчлөлтийн дүн нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд дансны үнийн бусад өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод БДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн гарзыг хассан дүнгээр олз гэж тайлагнагдана.

Банк нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах зээлийн чанарын өөрчлөлтөд үндэслэсэн үнэ цэнийн бууралтын "3 шатлал" бүхий дараах загварыг ашигладаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед ямар нэг үнэ цэнийн бууралтгүй зээлүүд нь "1-р шатлал"-д ангилагдана. 1-р шатлалын зээлүүдийн ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл (12 сарын ХБЭА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн дефолтоос үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэсгийн хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ.

Хэрэв Банк анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг тогтоовол хөрөнгийг "2-р шатлал"-д шилжүүлэн ангилах бөгөөд ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх ба энэ нь гэрээ дуусах хүртэл боловч хэрэв байгаа бол хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг авч үзнэ (Ашиглалтын хугацааны ХБЭА). Тодруулга 38-аас банк зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг хэрхэн тодорхойлсныг харна уу. Хэрэв Банк санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурсан гэж тодорхойлсон бол хөрөнгийг "3-р шатлал" руу шилжүүлэн ангилах ба ХБЭА нь ашиглалтын хугацааны турш дахь хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэнэ.

## **4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

### **4.1 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)**

Худалдан авсан, шинээр гаргасан үнэцэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЭА нь үргэлж хөрөнгийн ашиглалтын хугацааны турш дахь ХБЭА-тай ижил хэмжигдэнэ. ХБЭА-ын загварыг хэмжихэд ашиглагдсан мэдээллүүд, таамаглал, тооцооллын аргууд болон ХБЭА-ын загварт ирээдүйд чиглэсэн мэдээллийг Банк хэрхэн ашигласан талаарх тайлбарыг тодруулга 38-аас харна уу.

Үүнээс гадна зээл болон ашиглаагүй байгаа зээлийн шугамыг хоёуланг нь багтаасан зээлийн карт гэх мэт санхүүгийн зарим хэрэглүүрүүдийн хувьд Банк хугацааны туршид хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тухайн хугацаа нь хамгийн ихдээ гэрээний хугацаатай адилхан болсон ч гэсэн зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлснээр уг алдагдлыг багасгах хүртэл тооцоолдог. Эргэн төлөлтийг шаардах болон ашиглаагүй байгаа шугамын гэрээг цуцлах гэрээгээрх эрх нь гэрээний дагуу шаардах хугацаанд эрсдэлийн алдагдлын дүнд хязгаарлалт тавьдаггүйтэй холбоотой.

#### **(viii) Сангаас хаах**

Банк нь санхүүгийн хөрөнгийн нөхөн төлөгдөх үйл ажиллагаа дуусгавар болсон, дахин нөхөн сэргээх үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь данснаас хасдаг. Данснаас хасах нь үл хүлээн зөвшөөрөх үйл явдлыг илэрхийлнэ. Банк нь гэрээний дагуу төлөгдөх дүнг шаардан авах эрхтэй боловч буцаан төлөгдөх магадлал байхгүй үед шүүхээр шийдвэрлэгдэх үйл ажиллагаа дуусаагүй зарим санхүүгийн хөрөнгүүдийг данснаас хасах боломжтой. Банк дараах нөхцөлүүдийн улмаас эдгээр хөрөнгө нь буцаан төлөгдөх боломжгүй гэж үзнэ: Зээлдэгч төлбөрөө төлж чадахгүй болсон ба Банк шүүхээр ялсан ч тухайн хөрөнгийг нөхөн төлүүлэх боломжгүй эсвэл зээл төлүүлэхтэй холбоотой гарах зардал нь зээл төлүүлснээс орох орлогоос давах тохиолдолд.

#### **(ix) Санхүүгийн хөрөнгийн бүртгэлээс хасах**

Банк санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцсон (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй. Холбогдох тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

#### **(i) Өөрчлөлт**

Банк нь зарим тохиолдолд санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу дахин тохиролцоо тохиолдол гардаг. Банк нь гэрээний мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг дараах зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ; хөрөнгийн эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр гэрээний шинэ зүйл заалт байгаа эсэх, (ялангуяа ашгийн хуваарилалт эсвэл өмчийн өгөөж), хүүгийн түвшний мэдэгдэхүйц өөрчлөлт, нэрлэсэн валютын өөрчлөлт, шинэ барьцаа эсвэл хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөөлөх зээлийн өсөлт, мөн зээлдэгчийн санхүүгийн хүндрэлд ороогүй байх үе дэх зээлийн сунгалт гэх мэт.

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгалыг хүчингүй болгож Банк өмнөх хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бодит үнэ цэнээр нь шинэ хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

## 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

### 4.1 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Дахин тохиролцоо хийсэн өдрийг дараах үеийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр байна гэж үздэг. Мөн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг тодорхойлж харгалзан үздэг. Түүнчлэн Банк шинэ зээл буюу өрийн хэрэглүүр нь үндсэн төлбөр болон зээлийн хүү төлөлтийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж үздэг. Үл хүлээн зөвшөөрөгдсөн анхны хөрөнгийн дансны үнэ болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчидтэй хийсэн капитал хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Дахин тохиролцоо нь холбогдох нөгөө талын санхүүгийн хүндрэлтэй байдал болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй болсон үед хийгдэж байгаа нөхцөлд Банк хөрөнгийн одоогийн шинэчлэгдсэн мөнгөн гүйлгээ болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж гэрээний өөрчлөлтөөс үүдэлтэй мэдэгдэхүйц өөрчлөгдсөн хөрөнгөнд эрсдэл болон өгөөж байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон өгөөж өөрчлөгдөөгүй бол өөрчилсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөлтгүй гэх ба өөрчлөлтөөс үүдэн үл хүлээн зөвшөөрөлт гарахгүй. Банк анхны үр ашигт хүүгийн түвшин (эсвэл худалдан авсан, шинээр гаргасан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшин)-г ашиглан өөрчлөгдсөн гэрээний мөнгөн урсгалыг хорогдуулах замаар нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтийн олз, гарзыг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

### 4.2 Гадаад валютын хөрвүүлэлт

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөөрх хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханшаар бүртгэлийн суурь валютад хөрвүүлснээс үүсэх ханшийн олз, гарзыг тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг (гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз хасах гарз). Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлсийг тайлант жилийн хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй.

Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгддэг мөнгөн бус зүйлсийг (үүнд, өмчөөрх хөрөнгө оруулалт орно) бодит үнэ цэнэ тооцогдсон өдрийн ханшийг ашиглан хөрвүүлнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн, бодит үнэ цэнээр хэмжигдэх мөнгөн бус зүйлсийн гадаад валютын ханшийн зөрүүгээс гарсан өөрчлөлтийг бодит үнэ цэнийн олз, гарзад бүртгэдэг.

Эдгээр санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглагдсан валютын ханшийг доорх хүснэгтэд үзүүлэв:

	2022	2021
Монгол улсын төгрөг / Ам.доллар	3,444.60	2,848.80
Монгол улсын төгрөг / Евро	3,669.02	3,222.99
Монгол улсын төгрөг / Фунт Стерлинг	4,156.60	3,836.19
Монгол улсын төгрөг / Юань	495.40	447.15
Монгол улсын төгрөг / Рубль	48.85	38.34

### 4.3 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд тодорхой хэмжээний мөнгө рүү түргэн хөрвөх боломжтой, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлс хамаарна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд Төв Банкинд (Монголбанкинд) байршуулсан, зайлшгүй байлгах нөөцөөс бусад хадгаламжууд, Монголбанк ба Засгийн газрын үнэт цаас, мөн бусад Банкуудад 3 сараас доош анхны хугацаатай байршуулсан репо, урвуу репо хэлцлүүд, банк хооронд байршуулсан бүх мөнгөн хөрөнгө орно. Анх гурван сараас дээш хугацаагаар бүртгэсэн эх үүсвэрийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэдэг ба энэ нь: (i) гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд эдгээр мөнгөн гүйлгээ нь ЗХҮТ байх ба (ii) ашиг, алдагдалд бодит үнэ цэнийг нь хүлээн зөвшөөрөхгүй үед бүртгэнэ. Зарим улсын батлан даалтын хууль тогтоомж гэх мэт зөвхөн хуулиар баталгаажуулсан онцлог шинжүүд нь хууль тогтоомж өөрчлөгдсөн ч гэсэн уг онцлог шинж чанарыг хэрэглэж болох тул гэрээний нөхцөлд оруулахаас гадна ЗХҮТ-ийн тестэд нөлөөлөхгүй.



## **4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

### **4.3 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (үргэлжлэл)**

Мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан мөнгөн орлого болон төлбөрт Банкны шилжүүлсэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө орох ба үүнд Банкны харилцагч талуудын байршуулсан харилцах дансанд оруулсан болон гаргасан мөнгө, үндсэн зээл болон хүүгийн орлого, зарлага зэргийг багтаасан. Учир нь харилцагчдад олгосон зээл нь харилцагчийн хувьд мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг төлөөлөх учир ийнхүү оруулсан.

### **4.4 Төв банкинд байршуулсан заавал байлгах нөөц**

Монгол Улсын Төв Банкнд байршуулсан заавал байлгах нөөцийн үлдэгдэл гэж Банкны өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжгүй, Төв Банкнд байршуулсан заавал байлгах нөөцийн дансны үлдэгдлийг хэлнэ. Энэхүү заавал байлгах нөөцийн үлдэгдлийг мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй.

### **4.5 Бусад банкуудад байршуулсан хөрөнгө**

Бусад Банкуудад байршуулсан хөрөнгийг Банк харилцагч банк руу арилжааны бус зорилгоор мөнгө шилжүүлснээр хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй, дериватив бус, тодорхой буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлага үүсэх үед хүлээн зөвшөөрнө. Бусад Банкуудад байршуулсан хөрөнгийг дараах тохиолдолд хорогдуулсан өртгөөр бүртгэнэ: (i) гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд эдгээр мөнгөн гүйлгээ нь ЗХҮТ байх ба (ii) ашиг, алдагдалд бодит үнэ цэнийг нь хүлээн зөвшөөрөхгүй үед бүртгэнэ.

### **4.6 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт**

Бизнес загвар болон мөнгөн урсгалын онцлог шинжид үндэслэн, Банк нь өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөр, бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх гэж ангилж бүртгэдэг. Өрийн үнэт цаасыг гэрээнд заасан ЗХҮТ-ийн мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор болон нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулахын тулд ашиг, алдагдалд бодит үнэ цэнийг нь сайн дураар хүлээн зөвшөөрөөгүй үед хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Өрийн үнэт цаасыг гэрээнд заасан мөнгөн урсгалыг цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь ЗХҮТ байх ба бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй бол өрийн үнэт цаасыг бусад орлогоор хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр бүртгэнэ.

Тухайн хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолж ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварыг ашиглан тооцоолсон үнэ цэнийн бууралтын санг тухайн жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дансны үнийн бусад бүх өөрчлөлтүүдийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Өрийн үнэт цаасыг бүртгэлээс хасах үед бусад дэлгэрэнгүй орлогод өмнө хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогоос ашиг, алдагдал руу дахин ангилдаг.

Хорогдуулсан өртөг болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангаагүй тохиолдолд өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтыг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг. Банк нь нягтлан бодох бүртгэлийн олон янзын сууриар хүлээн зөвшөөрөгдсөн буюу хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн хоорондын нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах сонголтыг ашиглаж байгаа тохиолдолд анхны хүлээн зөвшөөрөлтөөр Банкны ААБҮЦ-ээрх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг дахин тодорхойлж болно.

### **4.7 Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт**

Үнэт цаас гаргагчийн хэтийн төлөвт өмчийн тодорхойлолтыг хангасан санхүүгийн хөрөнгө (жишээ нь, мөнгөөр төлөх гэрээний үүргийг агуулаагүй санхүүгийн хэрэглүүр ба гаргагчийн цэвэр

## **4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

### **4.7 Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)**

хөрөнгөнд үлдэх хувь оролцоог нотлох баримт) нь Банкны өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтыг илтгэнэ. Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг бусад дэлгэрэнгүй орлогод анх хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хэмжинэ.

Банкны бодлогод хөрөнгө оруулалтыг зөвхөн өгөөж бий болгохоос бусад стратегийн зорилгоор тэдгээр хөрөнгө оруулалтыг эзэмшдэг бол өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр тодорхойлно гэж заасан байдаг. Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх сонголтын үед, бодит үнэ цэнийн олз ба гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, түүнийг борлуулахтай холбоотой ашиг, алдагдалд дахин ангилж болохгүй. Хэрэв үнэ цэнийн бууралтын гарз ба тэдгээрийн буцаалт байгаа тохиолдолд бодит үнэ цэнийн бусад өөрчлөлтөөс тусад нь хэмжихгүй. Банкны төлбөр хүлээн авах эрх нь ийм хөрөнгө оруулалтын өгөөж гэхээсээ илүү хөрөнгө оруулалтын нөхөн төлбөрийг илэрхийлэхээс бусад тохиолдолд ногдол ашгийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

### **4.8 Үүсмэл санхүүгийн хэрэглүүр**

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд нь ихэвчлэн бодит үнэ цэнээр бүртгэгдсэн форвард ханшийн хэлцэл, валютын своп хэлцэл болон гадаад валютын хүүгийн своп хэлцэл зэрэг гадаад валютын арилжаануудаас бүрдэнэ. Бүх үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь бодит үнэ цэнэ эерэг байхад хөрөнгөөр, бодит үнэ цэнэ сөрөг байх үед өр төлбөрөөр бүртгэгддэг. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тайлант жилийн ашиг, алдагдалд тусгадаг (үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олзноос гарзыг хассан дүнгээр). Банк нь хейджийн бүртгэл хөтөлдөггүй.

### **4.9 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа**

Банк харилцагчаас авах өрийг худалдан авах эсвэл шинээр зээл олгож мөнгө шилжүүлсэн тохиолдолд харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг бүртгэдэг.

Бизнес загвар болон мөнгөн урсгалын шинж чанарт үндэслэн Банк харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг дараах хэмжилтийн ангиллын аль нэгээр нь ангилна: (i) Хорогдуулсан өртгөөр: гэрээнд заасан мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор олгосон зээл бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь ЗХҮТ байх ба сайн дураар бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй болон (ii) бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх: ЗХҮТ-ийн тест болон хорогдуулсан өртөг, бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангаагүй тохиолдолд бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Үнэ цэнийн бууралтын санг ирээдүйд чиглэсэн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварт үндэслэн тодорхойлдог. Тодруулга 38-д хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтэд ашигласан өгөгдөл, таамаглал, тооцооллын аргачлал болон Банк хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварт ирээдүйд чиглэсэн мэдээллийг хэрхэн харуулсан талаар тайлбарыг тусгасан.

### **4.10 Борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилагдсан эргэлтийн бус хөрөнгө**

Эргэлтийн бус хөрөнгө эсвэл борлуулах бүлэг хөрөнгөнд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгүүд багтах ба хэрэв тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор дансны үнэ нь борлуулалтын ажил гүйлгээний үр дүнд нөхөгдөх, эсвэл тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа охин компанийн хяналтыг алдахаар байх үед эдгээр хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд “Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө” гэж ангилна. Дараах нөхцөлүүд хангагдсан үед хөрөнгийг дахин ангилна. Үүнд: (а) хөрөнгө нь одоогийн нөхцөл байдалд нэн даруй борлогдох боломжтой; (б) Банкны удирдлага худалдан авагчийг олох төлөвлөгөөг батлан, үйл ажиллагааны идэвхтэй хөтөлбөрийг эхлүүлсэн; (в) хөрөнгийг зах зээлийн үнэтэй ойролцоо үнээр худалдахаар идэвхтэй ажиллаж буй; (г) хөрөнгийг нэг жилийн хугацаанд худалдан борлуулах магадлалтай; (д) хөрөнгийг худалдах төлөвлөгөөнд өөрчлөлт орох эсвэл төлөвлөгөөг цуцлах магадлал тун бага.

## 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

### 4.10 Борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилагдсан эргэлтийн бус хөрөнгө (үргэлжлэл)

Тайлант хугацааны санхүүгийн байдлын тайланд борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгөөр тусгагдсан эргэлтийн бус хөрөнгө эсвэл борлуулах бүлэг хөрөнгө нь харьцуулсан санхүүгийн байдлын тайланд дахин ангилагдаагүй, мөн дахин толилуулагдаагүй. Борлуулах зорилгоор эзэмшиж буй үндсэн хөрөнгийг элэгдүүлдэггүй. Эргэлтийн бус санхүүгийн хэрэглүүрийг дахин ангилсан нь тэдгээрийн дансны үнэ болон борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль бага дүн хүртэл нь бууруулах үндэслэл болохгүй.

### 4.11 Хөрөнгө, өр төлбөрийг хооронд нь хаах

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэж тайлагнах нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө. Эдгээр хооронд нь хаах эрх нь (а) ирээдүйд болох ямар нэгэн үйл явдлаас хамааралгүй байх, мөн (б) дараах нөхцөл байдалд хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжтой байх ёстой. Үүнд: (i) бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед, (ii) төлбөр төлөгдөхгүй болох үед, (iii) дампуурах эсвэл төлбөрийн чадваргүй болсон үед.

### 4.12 Санхүүгийн өр төлбөр

Дараа үед санхүүгийн өр төлбөрийг дараах нөхцөлөөс бусад тохиолдолд хорогдуулсан өртгөөр ангилна. (i) бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн өр төлбөр: Энэ ангилал нь дериватив, арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (жишээ нь. үнэт цаасны богино позиц), бизнесийн нэгдлийн үед худалдан авагчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй төлбөр болон анхны хүлээн зөвшөөрөлтөөр тодорхойлсон бусад санхүүгийн өр төлбөрүүд болон (ii) санхүүгийн баталгааны гэрээ ба зээлд хамаарах үүрэг багтана.

*Санхүүгийн өр төлбөрийг бүртгэлээс хасах:* Санхүүгийн өр төлбөрийг хүчингүй болсон үед (жишээ нь гэрээнд заасан үүргээс чөлөөлөх, цуцалсан эсвэл хугацаа нь дууссан үед) бүртгэлээс хасна. Банк болон түүний анхны зээлдүүлэгчдийн мэдэгдэхүйц өөр нөхцөл хугацаа бүхий өрийн хэрэглүүр болон одоо буй санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт нь анхны санхүүгийн өр төлбөрийг хүчингүй болгож, шинэ санхүүгийн өр төлбөрийг бий болсонд тооцогдоно. Шинэ нөхцөлөөрх мөнгөн гүйлгээний аливаа төлсөн төлбөр хураамж болон хүлээн авсан төлбөр хураамжийн цэвэр дүнг багтаасан хорогдуулсан өнөөгийн үнэ цэнэ нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх хугацааны мөнгөн урсгалын хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээс хамгийн багадаа 10% зөрүүтэй бол мэдэгдэхүйц өөр нөхцөлтэй гэж үзнэ.

Хэрэв өрийн хэрэглүүрийг солих буюу заалтын өөрчлөлтийг хүчингүй болсон гэж тооцвол гарсан аливаа зардал эсвэл төлбөрийг хүчингүй болгохтой холбоотой олз, гарзны нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрнө. Харин өрийн хэрэглүүрийг солих буюу заалтын өөрчлөлтийг хүчингүй болсон гэж бүртгээгүй бол гарсан аливаа төлбөр, хураамжаар өр төлбөрийн дансны үнийг тохируулах ба өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдсэн хугацааны туршид хорогдуулна.

Дансны өртгийн зөрүүгийн эдийн засгийн шинж чанар нь эзэмшигчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээний шинжтэй болсноос бусад тохиолдолд өрийн хэрэглүүр үл хүлээн зөвшөөрнө гэж үзээгүй өрийн өөрчлөлтийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн аливаа олз, гарзыг хуримтлагдсан өөрчлөлтийн аргыг ашиглан тооцооллын өөрчлөлт гэж бүртгэнэ.

*Бусад банкуудын байршуулсан хөрөнгө* – Бусад банкуудын байршуулсан хөрөнгийг харилцагч банкууд Банк руу мөнгө буюу бусад төрлийн хөрөнгө шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Дериватив бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

*Харилцагчдын харилцах, хадгаламж* - Харилцагчдын харилцах, хадгаламжууд нь хувь хүмүүс, улсын болон хувийн эзэмшлийн аж ахуйн нэгж, байгууллагад төлөх дериватив бус өр төлбөр бөгөөд хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг.

## 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

### 4.12 Санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)

*Бусад зээлийн эх үүсвэр* - Бусад зээлийн эх үүсвэрт Монгол Улсын Засгийн газар болон гадаадын санхүүгийн байгууллагаас авсан зээлүүд багтана. Эдгээр санхүүгийн өр төлбөрүүдийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

*Хоёрдогч өглөг* - Хоёрдогч өглөгийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

*Бусад өр төлбөр* - Бусад өр төлбөрийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан тооцож хорогдуулсан өртгөөр тусгана.

### 4.13 Урвуу РЕПО хэлцэл

Борлуулалт болон буцаан худалдан авах хэлцэл (“репо хэлцэл”)-ийг зээлдэгчийн эргэн төлөлтийг үр дүнтэйгээр хангах баталгаат санхүүгийн гүйлгээ гэж үздэг. Репо хэлцлийн хүрээнд худалдсан үнэт цаасыг бүртгэлээс хасдаггүй. Санхүүгийн байдлын тайлан дахь үнэт цаасны ангиллыг ерөнхийдөө өөрчилдөггүй боловч үнэт цаасаа шилжүүлж буй тал гэрээний дагуу эсвэл тогтсон хэвшлийн дагуу үнэт цаасыг зарах эсвэл барьцаанд өгөх эрхтэй тохиолдолд үнэт цаасыг эргэн худалдан авах авлага гэж ангилна. Холбогдох өглөгийг санхүүгийн байдлын тайланд “репо хэлцлүүд” гэж тусад нь толилуулдаг.

Буцаан худалдах хэлцлийн дагуу худалдан авсан үнэт цаас (“урвуу репо хэлцэл”) нь зээлдэгчээс Банкинд эргэн төлөлтийг үр дүнтэйгээр хангах бөгөөд урвуу репо хэлцэл гэж бүртгэнэ. Борлуулах болон буцаан худалдан авах үнийн зөрүүгээр хүүгийн орлогыг тайлант жилийн орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба урвуу репо хэлцлийн хугацааны турш үр ашигт хүүгийн аргыг ашиглан хуримтлуулан бүртгэдэг. Борлуулах болон буцаан худалдан авах гэрээний дагуу борлуулсан үнэт цаасны ангилалд үндэслэн Банк нь буцаан худалдан авах авлагыг дараах хэмжилтийн ангиллуудын аль нэгэнд ангилдаг: хорогдуулсан өртөг, бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх.

### 4.14 Байшин барилга болон Үндсэн хөрөнгө

Барилгыг дор дурдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг мөн шаардлагатай бол үнэ цэнэ бууралтын гарзыг хассан дүнгээр тусгадаг.

Банкны эзэмшиж буй барилгыг анх өртгөөр нь хэмжиж бүртгэнэ. Үл хөдлөх хөрөнгийн дансны үнэ нь бодит үнээс материаллаг зөрүүтэй эсэхийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлнэ. Дахин үнэлгээнээс нэмэгдсэн дансны үнээр бусад дэлгэрэнгүй орлогыг кредитлэн, өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлнэ. Ижил хөрөнгийн өмнө үүссэн нэмэгдлийг хааж буй дахин үнэлгээний бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөнд өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулна; бусад бүх бууралтыг тухайн жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг борлуулах болон данснаас хасахад гарсан нэмэгдэл эсвэл хөрөнгийг Банк ашиглаж буй тохиолдолд өөрийн хөрөнгөнд бүртгэсэн барилга тоног төхөөрөмжийн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан алдагдал буюу хуримтлагдсан ашигт шууд хаана; сүүлийн тохиолдолд бодит зөрүүгийн хэрэгжсэн өсөлт нь хөрөнгийн дахин үнэлсэн дансны үнээс бодсон элэгдэл болон хөрөнгийн анхны өртгөөс бодсон элэгдлийн зөрүүтэй тэнцэнэ.

Банкны үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээлгээний дүн нь ижил байршилд байдаг, адил төрлийн үл хөдлөх хөрөнгийг үнэлж байсан үнэлгээний туршлагатай, холбогдох мэргэжлийн мэргэшлийг эзэмшсэн, хараат бус үнэлгээчдийн хийлгэсэн үнэлгээнд тулгуурладаг. Банк хөрөнгийн дахин үнэлгээний загварыг үнэлгээндээ 2013 оноос ашиглаж эхэлсэн.

Банкны эзэмшиж буй тоног төхөөрөмжийг үнэ цэнэ бууралтын гарз болон элэгдлийг хассан дүнгээр бүртгэнэ. Бага хэмжээний засварын өртгийг гарсан даруйд нь зардалд бүртгэдэг.

## 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

### 4.14 Байшин барилга болон Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Барилгын томоохон хэсэг эсвэл бүрэлдэхүүн хэсгийг шинэчлэхтэй холбоотой гарсан зардлыг капиталжуулж, сольсон хэсгийг ашиглалтаас хасна.

Түрээсийн сайжруулалт нь Банкнаас түрээсийн зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бизнесийн тодорхой хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн өөрчлөх явдал юм. Банкнаас үл хөдлөх хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах чиглэлээр хийх аливаа сайжруулалтыг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор өөрийн хөрөнгө гэж бүртгэдэг.

НББОУС 16 "Үндсэн хөрөнгө"-ийн дагуу дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс мэдэгдэхүйц ялгаагүй тохиолдолд 3-5 жилийн хугацаанд тухайн хөрөнгийн дахин үнэлэж болно. Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь нөхөгдөх өртгийг тооцдог. Дансны үнийг нөхөгдөх өртөг хүртэл бууруулж, үнэ цэнийн бууралтын гарзыг өөрийн хөрөнгөд өмнө бүртгэгдсэн дахин үнэлгээний нэмэгдлээс давсан дүнгээр тухайн жилийн ашиг, алдагдалд бүртгэнэ. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнг тооцоолоход өөрчлөлт орсон бол өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг шаардлагатай бол буцаан залруулж бүртгэнэ.

Хөрөнгө борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг бүртгэлийн дүнтэй харьцуулж тооцох бөгөөд олз, гарзыг тухайн жилийн ашиг, алдагдалд бүртгэнэ (үйл ажиллагааны бусад орлого, зардлын хэсэгт).

Дуусаагүй барилгыг элэгдүүлдэггүй. Бусад үндсэн хөрөнгүүдийн элэгдлийг тэдгээрийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнг доорх ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь хуваарилж тооцно:

- Барилга – 40 жил
- Тээврийн хэрэгсэл – 10 жил
- Тавилга, эд хогшил – 10 жил
- Тоног төхөөрөмж болон компьютер – 3-10 жил
- Түрээсийн сайжруулалт – Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль багаар

Банкны тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны эцэст хэрэв уг хөрөнгө аль хэдийн ашиглагдаж дууссан бол хөрөнгийн борлуулах үнээс холбогдох тооцоолсон зардлуудыг хасч тооцсон дүнг хөрөнгийн үлдэх өртөг гэдэг. Тайлант хугацаа бүрийн эцэст хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг хянаж үзэх ба шаардлагатай бол залруулдаг.

### 4.15 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлж түрээсийн орлого олох эсвэл урт хугацааны туршид хөрөнгийн үнэ цэнээс өгөөж хүртэхийн тулд эзэмших зорилготой (өөрийн бизнесийн үйл ажиллагаанд ашиглахгүйгээр) эсвэл тус 2 зорилгыг хоёуланг нь хэрэгжүүлэхээр эзэмшиж буй хөрөнгө юм.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анх бодит өртгөөр нь буюу худалдаж авсан үнэ дээр худалдан авахтай холбоотой шууд зардлыг нэмж бүртгэдэг. Дараа нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тухайн тайлант хугацааны эцэст зах зээлийн нөхцөл байдалд үндэслэн бодит үнэ цэнээр хэмждэг. Тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг уг үл хөдлөх хөрөнгийг борлуулснаас олсон үнэ гэж үзнэ. Холбогдох гүйлгээний зардлыг хасахгүй.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотой олз, гарз үүссэн үед нь тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Худалдаж авсны дараах зардлыг зөвхөн тухайн хөрөнгөөс үүдэлтэй Банкны ирээдүйд олох эдийн засгийн өгөөж нь тодорхой болсон болон тухайн зардлыг бодитоор хэмжих боломжтой үед уг хөрөнгийн дансны үнэд нэмж бүртгэнэ. Бусад бүх засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг гарсан үед нь тухайн жилийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

## 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

### 4.15 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (үргэлжлэл)

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгийг борлуулах эсвэл ашиглалтаас бүрмөсөн хасах үед хөрөнгийн борлуулалт болон захиран зарцуулснаас ирээдүйд эдийн засгийн үр ашиггүй бол данснаас хасна.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах, акталснаас үүсэх олз, гарзыг тухайн жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Банкны хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг ижил байршилд байдаг, адил төрлийн үл хөдлөх хөрөнгийг үнэлж байсан туршлагатай хараат бус мэргэжлийн хөрөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэсэн үнэлгээнд тулгуурладаг. Банк хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дахин үнэлгээний загварыг үнэлгээндээ 2013 оноос ашиглаж эхэлсэн.

### 4.16 Биет бус хөрөнгө

Банкны биет бус хөрөнгө нь ашиглах тодорхой хугацаатай бөгөөд үндсэндээ капиталжуулсан компьютерийн программ хангамжийн лицензүүд байна. Худалдан авсан компьютерийн программ хангамжийн лицензүүдийг тэдгээрийг худалдан авах үед үүсэх зардал болон ашиглахад бэлэн болгоход гарсан зардлын үндэслэн капиталжуулан бүртгэдэг. Хэрэв Банкны эзэмшлийн бүх төрлийн программ хангамжийн эдийн засгийн өгөөж нь байж болох зардлаас их байх нь тодорхой бол тухайн программ хангамжийг хөгжүүлсэнтэй холбоотой зардлыг биет бус хөрөнгө гэж бүртгэнэ. Компьютерийн программ хангамжтай холбоотой, засвар үйлчилгээ гэх мэт бусад бүх зардлуудыг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулах ба биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрсэн үед тухайн хөрөнгийн үнэ цэнэ бууралтыг үнэлнэ.

Хорогдуулалтын хугацаа, аргачлалыг хамгийн багадаа жил бүрийн тайлант хугацааны эцэст хянаж үздэг. Биет бус хөрөнгийн тооцоолсон ашиглалтын хугацааг дараах байдлаар тогтоосон:

- Программ хангамжийн лицензүүд – 3-10 жил

### 4.17 Түрээс

**Банк түрээслэгчийн хувьд түрээсийн нягтлан бодох бүртгэл.** Банк нь оффисын байр, АТМ талбай болон агуулахыг түрээслэдэг. Банк ашиглах эрхтэй хөрөнгө болон түүнтэй холбоотой өр төлбөрийг уг түрээсэлж буй хөрөнгийг ашиглах эрх нь бий болсон өдрөөр хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөр бүрийг өр төлбөр ба санхүүгийн зардлын хооронд хуваарилдаг. Санхүүгийн зардлыг түрээсийн хугацааны туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг бөгөөд ингэснээр хугацаа тус бүрийн өр төлбөрийн үлдэгдэл дээр хүүгийн хугацааны турш дахь тогтмол хувийг бий болгоно. Ашиглах эрхтэй хөрөнгийг өртгөөр хүлээн зөвшөөрөх ба хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль багаар нь шулуун шугамын аргыг ашиглан элэгдэл тооцдог.

Түрээсийн өр төлбөрийг өнөөгийн үнэ цэнээр нь анхлан хэмжинэ. Түрээсийн өр төлбөр нь дараах түрээсийн төлбөрийн өнөөгийн цэвэр үнэ цэнийг агуулна:

- тогтмол төлбөрүүд (уг чанар нь тогтмол төлбөрүүд орно), хасах нь аливаа түрээсийн урамшууллын авлага;
- индекс эсвэл хувь хэмжээнд үндэслэсэн түрээсийн хувьсах төлбөрүүд;
- баталгаат үлдэх өртгийн дагуу Банкны төлөхөөр тооцоолж буй дүн;
- худалдан авах сонголтын хэрэгжих үнэ (хэрэв түрээслэгч тухайн сонголтыг хийх нь тодорхой үндэслэлтэй бол); болон
- түрээсийн гэрээг цуцлахтай холбоотой торгуулийн төлбөрүүд (хэрэв түрээсийн нөхцөлд түрээсийг цуцлах сонголтыг хэрэгжүүлэхээр түрээслэгч тусгасан бол).

## **4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

### **4.17 Түрээс (үргэлжлэл)**

Түрээсийн төлбөрүүдийг нуугдмал хүүний түвшнээр хорогдуулах ба хэрвээ тодорхойлох боломжгүй бол түрээслэгчийн зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшинг ашиглана. Энэ нь Банк эдийн засгийн ижил төстэй нөхцөл байдалд ижил үнэ цэнэтэй хөрөнгийг худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг ижил төстэй нөхцөлөөр зээлэх үед төлөх зээлийн хүүгийн түвшинг хэлнэ.

Ашиглах эрхтэй хөрөнгийг дараах өртгөөр хэмжинэ:

- түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилтийн дүн
- түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх өдөр болон түүнээс өмнө төлсөн түрээсийн төлбөрүүд (хүлээн авсан түрээстэй холбоотой аливаа урамшууллыг хассан дүнгээр)
- анхдагч шууд зардал
- нөхөн сэргээгдэх зардал.

Дээр дурдсанаас үл хамааран Банк богино хугацаатай түрээс болон бага үнэ цэнэтэй түрээсийн хөрөнгийн төлбөрийг шулуун шугамын аргаар хуваарилан үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Банк түрээсийн хугацааг тодорхойлохдоо түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх өдрөөс сунгах эсвэл цуцлах өдөр хүртэл өөрчлөгдөхөөр таамаглагдаж байгаа бүх холбогдох баримт болон нөхцөл байдлыг харгалзан үзэж, Банкинд түрээсийн гэрээг сунгах эсвэл цуцлахгүй байх нь өөрт эдийн засгийн ашигтай байх эсэхийг судална. Сунгах болон цуцлах хугацааны сонголтыг зөвхөн тодорхой үндэслэлтэйгээр хэрэгжүүлнэ гэсэн тохиолдолд түрээсийн хугацаанд оруулна.

Түрээслэгчийн хяналтанд байгаа болон тухайн үнэлэлтэнд нөлөө үзүүлэх аливаа чухал нөлөө бүхий үйл явдал эсвэл нөхцөл байдалд ихээхэн өөрчлөлт гарсан тохиолдолд үнэлгээнд хяналт тавьдаг. Банк нь СТОУС 16-ын дагуу КОВИД-19-тэй холбоотой түрээслүүлэгчийн тайлант хугацаанд олгосон түрээсийн хөнгөлөлтийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлсэн. Уг түрээсийн хөнгөлөлтийг олгогдсон хугацаанд түрээсийн өр төлбөр болон хувьсах түрээсийн бууралт гэж бүртгэсэн болно. Банк материаллаг хэмжээний түрээсийн хөнгөлөлт аваагүй.

**Банк түрээслүүлэгчийн хувьд үйл ажиллагааны түрээсийн нягтлан бодох бүртгэл.** Хэрэв хөрөнгийг үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн авлагыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хуваарилан түрээсийн орлогоор бүртгэнэ.

### **4.18 Хувьцаат капитал болон давуу эрхтэй хувьцаа**

Энгийн хувьцаа болон буцаан төлөх, эргэн дуудах нөхцөлгүй давуу эрхтэй хувьцааг эзэмшигчдийн өмч гэж ангилдаг. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг хувьцаа борлуулсны татварыг хассан дүнгээр бууруулж, эзэмшигчдийн өмчид тусгадаг. Хувьцаа борлуулснаас орж ирсэн орлогын бодит үнэ цэнийн хувьцааны нэрлэсэн үнээс илүү гарсан хэсгийг нэмэгдэж төлөгдсөн капитал гэж эзэмшигчдийн өмчид тусгадаг. Ногдол ашгийг зарласны дараагаар хүлээн зөвшөөрдөг.

### **4.19 Халаасны хувьцаа**

Банк эсвэл түүний охин компаниуд Банкны өмчийн хэрэглүүрийг худалдаж авсан тохиолдолд шууд хамааралтай нэмэлт зардлыг оруулж, орлогын албан татварыг хасч, өмчийн хэрэглүүрийг дахин гаргах, худалдах, цуцлах хүртэл банкны эздэд хамаарах өмчөөс хасч тооцно. Ийм хувьцааг дараа нь худалдах эсвэл дахин гаргах тохиолдолд хүлээн авсан аливаа төлбөрийг өөрийн хөрөнгөд бүртгэнэ. Дахин гаргахтай холбоотой гарсан аливаа олз, гарзыг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэнэ.

### **4.20 Нэмж төлөгдсөн капитал**

Нэмж төлөгдсөн капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнээс илүү үнээр оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

## 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

### 4.21 Хувьцаанд суурилсан төлбөр

Банк нь өмчөөр төлөгдөх хувьцаанд суурилсан ажил гүйлгээний хүрээнд ажилчдаас хүлээн авсан үйлчилгээний үнэд хувьцаагаар төлбөр хийдэг.

Өмчөөр төлөгдөх ажилчдаас хүлээн авсан үйлчилгээ. Хувьцаа буюу хувьцааны опцион олгох ажил гүйлгээгээр ажилчдаас хүлээн авсан үйлчилгээг зардлаар хүлээн зөвшөөрнө.

Эрх хэрэгжүүлэх хугацаанд зардлаар гарах нийт дүнг зах зээлийн бус баталгаажуулах нөхцлийн нөлөөллийг оруулалгүйгээр олгох өдрөөр тодорхойлсон опцион эсвэл хувьцааны бодит үнэ цэнийг харгалзан тодорхойлно. Аливаа үйлчилгээний хүртээмж болон зах зээлийн бус гүйцэтгэлийн нөхцлүүд нь хэрэгжих боломжтой опционы тоо эсвэл ажилтан эцсийн дүндээ авах хувьцааны тоотой холбоотой таамаглалд багтдаг. Уг тооцооллыг тайлант өдрөөр шинэчлэн тооцож, зөрүүг ашиг алдагдалд болон харгалзах өөрийн хөрөнгөд залруулдаг. Зах зээлийн гүйцэтгэлийн нөхцөл, тухайлбал, хувьцаа эзэмшигчийн зохих нийт өгөөж эсвэл хувьцааны үнэ зэрэгт хүрч чадаагүйгээс болж хүлээгдэж буй буюу бодит хэрэгжүүлэх дүн нь анхны тооцооллоос зөрүүтэй байвал төлбөрт ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй.

Опционыг хэрэгжүүлснээр гүйлгээтэй холбоотой шууд гарах зардлаар цэвэршүүлсэн орлогыг хувь нийлүүлсэн хөрөнгөд (нэрлэсэн үнээр) болон хувьцааны нэмэгдэж төлөгдсөн капиталд оруулан тооцно. Цуцалсан опционуудыг шууд хэрэгжсэн гэж үзнэ. Үүнтэй холбоотой хорогдуулаагүй зардлыг шууд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

### 4.22 Ногдол ашиг

Ногдол ашгийг зарласан хугацаанд эзэмшигчдийн өмчид бүртгэнэ. Тайлант хугацааны эцсийн өдрөөс хойш, гэхдээ санхүүгийн тайлангуудыг нийтлэхийг зөвшөөрөхөөс өмнө зарлагдсан ногдол ашгийг тайлант хугацааны дараах үйл явдлын тодруулгад оруулан толилуулдаг. Ногдол ашгийн хуваарилалтыг хуримтлагдсан ашгаас олгоно.

### 4.23 Болзошгүй хөрөнгө ба болзошгүй өр төлбөр

Болзошгүй хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөхгүй боловч эдийн засгийн өгөөжийн орох урсгал магадлалтай үед санхүүгийн тайланд нэмж тодруулна.

Төлбөрийг барагдуулахтай холбоотой мөнгөн урсгал гарах магадлалтай бол болзошгүй өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөхгүй боловч нэмж тодруулна.

### 4.24 Зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг

**Зээлд хамаарах үүрэг.** Банк зээл олгох үүрэг хүлээдэг ба эдгээр үүрэг нь материаллаг сөрөг өөрчлөлтөөс хамааран буцалтгүй болон буцаагдах нөхцөлтэй байна. Зээл олгох үүрэг нь анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд хүлээн авсан хураамжийн дүнгээр нотлогддог. Энэ дүнг хүлээсэн үүргийн хүчинтэй байх хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулан бүртгэдэг. Энэ арга нь Банк зээл олгох үүрэг хүлээж уг үүргийнхээ дагуу тодорхой зээлийн хэлцэлд оролцох нь магадлалтай бөгөөд уг зээлээ олгосны дараа богино хугацаанд бусдад борлуулах төлөвлөгөөгүй тохиолдолд үйлчлэхгүй. Энэ тохиолдолд зээлийн үүргийн хураамжийг хойшлуулж, олгосон зээлийн анхны хүлээн зөвшөөрөх дүнд оруулан тооцно.

Тайлант үе бүрийн эцэст үүргүүдийг (i) анх хүлээн зөвшөөрсөн тухайн өдрөөрх хорогдуулаагүй дүнгийн үлдэгдэл болон (ii) зах зээлийн хүүний түвшнээс доогуур хүүтэй зээл олгох үүргээс бусад тохиолдолд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварын дагуу тодорхойлогдсон алдагдлын дүнгийн аль ихээр нь хэмжиж бүртгэнэ. Зээлд хамаарах үүргийн дансны үнэ нь өр төлбөрийг илэрхийлнэ. Зээл болон ашиглаагүй үүргийг багтаасан гэрээний хувьд, Банк нь зээлийн бүрэлдэхүүнээс ашиглаагүй үүргийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тусад нь ялгаж чадахгүй тохиолдолд уг алдагдлыг зээлийн алдагдлын хасагдуулгын хамт хүлээн зөвшөөрнө.



## **4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

### **4.24 Зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг (үргэлжлэл)**

Нийт хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь зээлийн нийт дансны үнээс илүү гарсан тохиолдолд өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө. Тодруулга 38-д хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтэд ашигласан өгөгдөл, таамаглал, тооцооллын аргачлал болон Банк ХБЭА-ын загварт ирээдүйд чиглэсэн мэдээллийг хэрхэн харуулсан талаар тайлбарыг тусгасан.

**Гүйцэтгэлийн баталгаа.** Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талаас нөхөн төлбөр олгодог гэрээ юм.

Гүйцэтгэлийн баталгаа нь банканд хүсэлт гаргагчаас батлан даалт эзэмшигчид төлсөн аливаа төлбөрийг гэрээнд заасны дагуу нөхөн олгох эрхтэй бөгөөд уг эрх нь барьцаа хөрөнгөөр хангагдаж байгаа тохиолдолд болон гэрээнд банк нийт алдагдлыг хариуцахад хүргэж болзошгүй арилжааны шинж чанартай үйл явдал байхгүй тохиолдолд зээлд хамаарах үүрэг гэж үзнэ. Ийм гүйцэтгэлийн баталгааг анх хүлээн зөвшөөрөхдөө хүлээн авсан шимтгэлийн хураамжийн үнэ буюу бодит үнэ цэнээр бүртгэдэг. Энэхүү дүнд шулуун шугамын аргаар гэрээний хугацааны турш хорогдуулалт тооцдог. Тайлант үе бүрийн эцэст гүйцэтгэлийн баталгааны гэрээг дараах дүнгүүдийн хамгийн их дүнгээр хэмжинэ. Үүнд (i) анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн хорогдуулалт хийгээгүй дүн, (ii) хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загварын дагуу тодорхойлогдсон алдагдлын дүнгийн аль ихээр хэмжинэ. Гүйцэтгэлийн баталгаа нь талуудын хооронд ямар нэгэн өрийн хэрэглүүр байхгүй бөгөөд баталгааны төлбөр нь зөвхөн зээлдэгч төлбөрөө төлөөгүй байхаас хамаарахгүй тохиолдолд СТОУС 9-д заасан санхүүгийн баталгааны тодорхойлолтыг хангахгүй. Ийм гүйцэтгэлийн баталгааны хувьд Банк одоогоор СТОУС 17-ын дагуу нөлөөллийг үнэлж байна.

### **4.25 Нөөц**

Өр төлбөр ба зардлын нөөц/сан нь тодорхой бус хугацаатай болон дүн бүхий санхүүгийн бус өр төлбөр бөгөөд Банк өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн эрх зүйн хувьд эсвэл бодит үндэслэлтэй үүрэг хүлээсэн ба энэхүү үүргээ биелүүлэхэд шаардагдах эдийн засгийн өгөөж бүхий эх үүсвэрийг төлөх магадлалтай, мөн уг үүргийн дүнг баталгаатайгаар тооцоолох боломжтой үед эдгээр нөөц/санг хуримтлуулан бүртгэдэг.

2016 оноос эхлэн Банк үйл ажиллагааны эрсдэлдээ зориулан нөөц санг байгуулсан. Энэ нөөц нь бусад нөөц эх үүсвэрийн нэг хэсэг бөгөөд Банкны удирдлагын гаргасан шийдвэрт үндэслэн хуримтлагдсан ашгийн зохих хэсэг болгон байгуулагдсан.

### **4.26 Орлогын албан татвар**

Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст бүхэлд нь эсвэл ерөнхийд нь батлагдсан хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн тайлант хугацааны болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө.

*Тайлант хугацааны орлогын албан татвар* нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдуулах ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн болно. Санхүүгийн тайланг холбогдох татварын албанд тушаахаас өмнө баталж амжаагүй тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилан тооцоолдог. Орлогын албан татвараас бусад татваруудыг удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардалд бүртгэдэг.

*Хойшлогдсон орлогын албан татварыг* тооцохдоо татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэх балансын өглөгийн аргыг ашигладаг ба санхүүгийн тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь болон санхүүгийн тайлан дахь бүртгэлийн дүнгийн хооронд үүсэх түр зөрүүнд үндэслэж тооцдог.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн чөлөөлтийн дагуу татвар ногдуулах ашиг болон бүртгэлийн ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, мөн бизнесийн нэгдлээс бусад ажил гүйлгээнд хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөх үед үүссэн түр зөрүүгийн хувьд хойшлогдсон татвар бүртгэгддэггүй. Хойшлогдсон татварын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст бүхэлдээ буюу үндсэндээ

## 4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

### 4.26 Орлогын албан татвар (үргэлжлэл)

батлагдсан байсан татварын хувь хэмжээгээр тооцож байгаа бөгөөд түр зөрүү гарах хугацаанд буцаах эсвэл татварын алдагдлыг ирээдүйд ашиглагдах үед хэрэглэхээр хүлээгдэж байдаг.

Хасагдах түр зөрүү болон татварын алдагдал шилжүүлснээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг ирээдүйд түр зөрүү буцах магадлалтай үед бүртгэх бөгөөд эдгээр түр зөрүүг ирээдүйд олох татварын ашгаас хасч ашиглаж болохуйц хэмжээгээр л хүлээн зөвшөөрнө. Гадаад валютын арилжааны үед гарах үүсмэл хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөөгүй олз гарз гэж үздэг ба түр зөрүү гэж бүртгэдэг (Тодруулга 3.3.14). Бусад бүх санхүүгийн хөрөнгө болон бусад өр төлбөрийн гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зөрүү нь гадаад валютын ханшийн зөрүүгийн олзоос хасах гарз гэж үздэг ба энэ нь түр зөрүү үүсгэдэггүй.

Банкны татварын тодорхой бус байр суурийг удирдлага тайлант үеийн эцэс бүрд дахин үнэлдэг. Банкны орлогын татварын байр суурийг татварын байгууллага хүлээн зөвшөөрөхгүй байж болохоос үүдэн нэмэлт татвар ногдуулах нь ногдуулахгүй байхаас илүү магадлалтай гэж удирдлага үзсэн тохиолдолд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн тайлангийн эцсийн өдрийн байдлаар бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан хууль тогтоомжийн тайлбар, мөн ижил асуудлыг шүүх байгууллагын шийдвэрлэсэн байдалд үндэслэн үнэлгээ хийгддэг. Торгууль, алданги болон орлогын бус татвартай холбоотой өглөгийн хувьд тайлант хугацааны эцэс дэх өр төлбөрийг барагдуулахад шаардагдах зардлыг удирдлага хамгийн боломжит аргаар тодорхойлсноор хүлээн зөвшөөрнө.

### 4.27 Ажилчдын тэтгэмж ба нийгмийн халамж

#### (i) Богино хугацаат тэтгэмж

Цалин хөлс бусад цалин хөлстэй холбоотой зардлууд нь Банкны ажилтан холбогдох ажил үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд зардлаар хүлээн зөвшөөрөгддөг. Цалинтай ээлжийн амралт зэрэг нөхөн олговортой бусад богино хугацаат хуримтлагдах ажлын чөлөөг ажиллагсад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед, нөхөн олговортой богино хугацаат хуримтлагдахгүй ажлын чөлөөг (жишээ нь, өвчний улмаас чөлөө авах) тухайн үед нь хүлээн зөвшөөрдөг.

#### (ii) Тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу улсын тэтгэврийн болоод нийгэм, эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь ашиг, алдагдалд зардлаар бүртгэдэг. Банк өөрсдийн байгуулсан тэтгэврийн санд шимтгэл төлдөг. Төлсөн шимтгэлийг ажилтны Банкинд ажилласан хугацаанд нь хувь тэнцүүлэн "Тэтгэврийн сангийн зардал" дансанд бүртгэнэ.

### 4.28 Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт

Хүүгийн орлого, зардлыг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд бүх өрийн хэрэглүүр бүрийн хувьд аккруэль суурьт үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэдэг. Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэрэглүүрийн хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгээр тооцож орлого үр дүнгийн тайлангийн "Бусад адилтгах орлого" мөрөнд толилуулсан.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, хэрэглүүрийн нөхцөлүүдийг хэлэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ байгуулахтай холбоотой аливаа хураамжууд орно. Банк нь харилцагчид зээл олгосны дараах богино хугацаанд

## **4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

### **4.28 Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)**

тухайн зээлийг тусгайлсан хэлцэл байгуулах худалдах төлөвлөгөөгүй тохиолдолд тухайн зээлийг зах зээлийн хүүгээр олгохтой холбоотой хураамж, шимтгэлийг үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болгон тооцно. Зээл олгохоор хүлээсэн үүргийг Банк ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаггүй.

Үүссэн болон худалдан авсан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн түвшин нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг (үүнд анхны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал орно) анх бодит үнэ цэнээр (худалдан авах үнээр илэрхийлэгддэг) хүлээн зөвшөөрөхдөө хямдруулах хүү юм. Үүний үр дүнд үр ашигт хүүгийн түвшин нь зээлийн тохируулгатай байдаг.

Дараах нөхцөлөөс бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэд үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хүүгийн орлогыг тооцоолно. (i) зээлийн үнэ цэнийн бууралтанд орсон санхүүгийн хөрөнгүүд (3-р үе шат), хүүгийн орлогыг үр ашигт хүүний түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр тооцож, хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг хассан дүнгээр, (ii) үүссэн болон худалдан авсан үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд анхны зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хорогдуулсан өртгийг тооцох үед.

Хэрэв 3-р үе шатанд ангилсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл дараа нь сайжирч, хөрөнгө нь цаашид зээлийн үнэ цэнийн бууралтгүй болсон мөн энэ сайжирсан байдал нь хөрөнгийг зээлийн үнэ цэнийн бууралттай гэж тогтоосны дараа үүсэх үйл явдалтай бодитойгоор холбоотой байгаа тохиолдолд хөрөнгийг 3-р үе шатнаас гаргаж, хүүгийн орлогыг дансны нийт дүнгээс үр ашигт хүүгийн аргаар тооцож бүртгэнэ. Өмнө нь хөрөнгө 3-р шатанд байсны улмаас ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан нэмэлт хүүгийн орлого нь ангилал сайжирснаар үнэ цэнийн бууралтын буцаалт гэж хүлээн зөвшөөрөгдөнө.

Хураамж, шимтгэлийн орлогыг харилцагч Банкны үйл ажиллагааны үр дүнд бий болсон үр өгөөжийг нэгэн зэрэг хүлээн авч, ашигладаг учраас үйлчилгээг үзүүлсэн үед нь шулуун шугамын аргаар хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Ийм орлогод засвар үйлчилгээний данс, үйлчилгээний хураамжийн данс, захиалгын төлбөрийн дансны хураамжууд, шимтгэл үйлчилгээний багцын төлбөр эсвэл гуравдагч этгээдийн нэрийн өмнөөс үйлчилгээний төлбөрийн шимтгэл хураамжийн орлогууд зэрэг багтана. Хувьсах төлбөр хураамжийг томоохон хэмжээний буцаалт байхгүй гэдгийг өндөр магадлалтайгаар удирдлага тодорхойлсон үед л хүлээн зөвшөөрдөг.

Бусад хураамж, шимтгэлийн орлого нь ихэвчлэн үндсэн ажил гүйлгээ гарсны дараа тодорхой хугацаанд буюу Банк гүйцэтгэлийн үүргээ хангасан үед хүлээн зөвшөөрнө. Хүлээн авсан хураамж, шимтгэл болон авлагын дүн нь гүйцэтгэлийн ялгаатай үүргүүд гэж тодорхойлсон үйлчилгээний хувьд гүйлгээний үнийг илэрхийлнэ. Ийм орлогод харилцагчийн нэрийн өмнөөс гадаад валют худалдах, худалдан авахад зориулсан хураамж, төлбөрийн гүйлгээ хийх үйлчилгээний хураамж, бэлэн мөнгөний төлбөр тооцоо, цуглуулах, зарцуулах хураамж зэрэг багтана.

### **4.29 Өмчлөх бусад хөрөнгө**

Өмчлөх бусад хөрөнгө гэдэг нь хугацаа хэтэрсэн зээлийн үүргийг хангуулахаар хураан авсан санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө (барилга зэрэг үл хөдлөх хөрөнгө, машин тоног төхөөрөмж, бараа материал зэрэг хөдлөх хөрөнгө, үнэт цаас зэрэг санхүүгийн хөрөнгө)-ийг хэлнэ. Хөрөнгийг эзэмших үедээ анхлан өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд санхүүгийн байдлын тайлангийн өмчлөх бусад хөрөнгөнд бүртгэх ба дараа нь тухайн хөрөнгийн шинж чанар, Банкны эдгээр хөрөнгийн өртгийг нөхөх сонирхол зэргээс шалтгаалж холбогдох хөрөнгийн бүлэгт хамаарах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу дахин хэмжиж бүртгэнэ.

Санхүүгийн бус хөрөнгийн хувьд хэрэв Банкны удирдлага нь өмчлөх бусад хөрөнгийг (үл хөдлөх хөрөнгийг) өөрийн бизнесийн үйл ажиллагаанд ашиглах шийдвэрийг гаргасан бол Банк уг хөрөнгийг “Байшин барилга ба үндсэн хөрөнгө” гэж дахин ангилан, Байшин барилга ба үндсэн хөрөнгөтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу бүртгэнэ (Тодруулга 4.14)

## **4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

### **4.29 Өмчлөх бусад хөрөнгө (үргэлжлэл)**

Хэрэв Банк нь хураан авсан барьцаа хөрөнгийг түрээслүүлэн орлого олох болон капиталын өгөөжийг хүртэх зорилгоор эсвэл энэ 2 тохиолдлын хоёулангийнх нь зорилгоор өөрөө ашиглахгүйгээр хадгалж үлдсэн бол Банк нь уг хөрөнгийг “Өмчлөх бусад хөрөнгө”- өөс “Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө” хэсэгт дахин ангилан холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу бүртгэнэ (Тодруулга 4.15).

Хэрэв Банк нь өмчлөх бусад хөрөнгөөр олж авсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдахаар шийдвэр гаргасан тохиолдолд бараа материалтай холбоотой нягтлан бодох бүртгэлийн журмыг баримтлан зөвхөн СТОУС 5–ын шаардлага хангах, худалдах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө гэж ангилснаас бусад тохиолдолд уг хөрөнгийг “Өмчлөх бусад хөрөнгө” гэж санхүүгийн байдлын тайланд тусгана. Худалдан борлуулахаар төлөвлөсөн санхүүгийн бус өмчлөх бусад хөрөнгийн талаар Тодруулга 18-аас харна уу.

Хэрэв өмчлөх бусад хөрөнгө (үнэт цаас гэх мэт санхүүгийн хөрөнгө)-ийг борлуулснаар анхны үнээ нөхөх бол Банк нь СТОУС-ын хэмжилтийн зорилгоор санхүүгийн хөрөнгийн шинж чанар ба бизнесийн загвараас хамааран ангилж, бодит үнэ цэнээр хэмжинэ. Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тайлант хугацаа бүрд тооцоолдог бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хөрөнгийн ангиллаас хамааран бусад дэлгэрэнгүй орлого болон ашиг алдагдалд “Дахин үнэлгээний нөөц” дансанд хүлээн зөвшөөрнө. Тодруулга 18-аас санхүүгийн өмчлөх бусад хөрөнгийн дэлгэрэнгүйг харна уу.

### **4.30 Бараа материал**

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэнэ. Цэвэр боломжит үнэ цэнэ нь бизнесийн хэвийн нөхцөлд барааг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс барааг бий болгох болон худалдахтай холбоотойгоор гарах тооцоолсон зардлыг хассан дүн юм.

### **4.31 Үнэт металл**

Банк үнэт металлын үнийн зөрүүний богино хугацааны хэлбэлзлээс ашиг олох зорилгоор үнэт металлыг хүлээн авснаас хойш богино хугацаанд зарж борлуулдаг практик туршлагатай. Үнэт металлыг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг.

## **5 Шинэ буюу өөрчлөлт орсон стандартуудын тайлбар, хэрэгжилт**

Дараах нэмэлт, өөрчлөлтүүд нь 2022 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон ба Банкны санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй.

*Зориулалтаар нь ашиглахаас өмнөх орлого, алдагдалтай гэрээ – гэрээ гүйцэтгэлийн өртөг - НББОУС 16, НББОУС 37, СТОУС 3-т оруулсан хязгаарлагдах\цар хүрээний нэмэлт өөрчлөлт, СТОУС-д 2018-2020 оны хооронд хийгдсэн жил тутмын сайжруулалт - СТОУС 1, СТОУС 9, СТОУС 16 ба НББОУС 41-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 5 сарын 14-ний өдөр батлагдсан ба 2022 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).*

## **6 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд**

2022 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд заавал мөрдөх стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн ба эдгээрийг Банк хугацаанаас нь өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

- СТОУС 17 “Даатгалын гэрээ” (2017 оны 5 сарын 18-ны өдөр батлагдсан бөгөөд 2023 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).
- СТОУС 17 болон СТОУС 4-т орсон нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 6 сарын 25-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2023 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).
- СТОУС 17 Нэмэлт өөрчлөлт – Даатгагчдын шилжих сонголт – (2021 оны 12 сарын 9-ний өдөр батлагдан гарсан бөгөөд 2023 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).

Банк одоогоор санхүүгийн тайланд үзүүлэх СТОУС 17-н нөлөөллийг судалж байна.

- Нэг гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар – НББОУС 12-т оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (2021 оны 5 сарын 7-ны өдөр батлагдсан ба 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно).
- Өр төлбөрийг урт болон богино хугацаатайгаар нь ангилах, дагаж мөрдөх хугацааг хойшлуулах - НББОУС 1-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 7 сарын 15-ны өдөр батлагдсан ба 2023 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).
- СТОУС 16 “Түрээс”-т орсон нэмэлт өөрчлөлтүүд: Борлуулаад эргүүлэн түрээслэх түрээсийн өр төлбөр (2022 оны 9 сарын 22-ны өдөр батлагдсан ба 2024 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).
- НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг тодорхойлох тухай нэмэлт өөрчлөлт: (2021 оны 2 сарын 12-ний өдөр батлагдсан ба 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно).
- НББОУС 1-д ба СТОУС-ын практик мэдэгдэл 2-д оруулсан нэмэлт өөрчлөлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга (2021 оны 2 сарын 12-ний өдөр батлагдсан ба 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно).
- Өр төлбөрийг урт болон богино хугацаатайгаар нь ангилах – НББОУС 1-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (анх 2020 оны 1 сарын 23-нд батлагдан, 2020 оны 7 сарын 15 болон 2022 оны 10 сарын 31-нд нэмэлт өөрчлөлтүүд орсон ба 2024 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).

Дээр дурдсанаас бусад тохиолдолд шинэ стандартууд болон өөрчлөлтүүд нь Банкны санхүүгийн тайлангуудад томоохон нөлөө үзүүлэхгүй болно.

## 7 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад)

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө	101,014,387	115,856,223
Монголбанкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад)	1,041,389,704	579,098,197
<b>Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө</b>	<b>1,142,404,090</b>	<b>694,954,420</b>

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад) нь барьцаа хөрөнгөөр баталгаажуулаагүй. 2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн эрсдэлийн зэрэглэлд тулгуурлан Монголбанкн дахь харилцах дансны зээлжих чанар нь “Хангалттай” бөгөөд Монголбанк нь Мүүди’с-ийн В3 үнэлгээтэй байсан.

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгөн (заавал байлгах нөөцөөс бусад) хөрөнгийн валют, хүүгийн түвшин болон дуусгавар болох хугацааны шилжилгээг Тодруулга 38-аас харна уу.

Мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан хөрөнгө (Тодруулга 7)	1,142,404,090	694,954,420
Гурван сараас бага хугацаатай Монголбанкны үнэт цаас (Тодруулга 10)	647,154,123	1,563,001,736
Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө (Тодруулга 9)	489,364,658	176,769,732
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	(3,831,939)	-
<b>Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>2,271,582,549</b>	<b>2,434,725,888</b>

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжих зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл нь 2021 оны 12 сарын 31 болон 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар “1-р үе шат”-д байна. Эдгээр үлдэгдлийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь бага хэмжээтэй тул Банк мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд ямар нэгэн эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг хүлээн зөвшөөрөөгүй. Дээрх зээлжих эрсдэлийн сан нь 3-р шатанд ангилагдсан ОХУ-н банкуудад байршуулсан хөрөнгөтэй холбоотой. ХБЗА–ын тооцоололд ашиглагдсан өгөгдөл, таамаглал болон тооцооллын аргачлалыг Тодруулга 38-аас харна уу.

## 8 Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	357,581,959	277,343,522
<b>Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц</b>	<b>357,581,959</b>	<b>277,343,522</b>

Банк нь Төв Банк буюу Монголбанкн дахь харилцах дансандаа Монголбанкнаас тавьдаг шаардлагын дагуу заавал байлгах нөөцийг байршуулдаг. Төв Банкн дахь байршуулдаг заавал байлгах мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь 14 хоногийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн төгрөгийн хувьд 8%-аас багагүй, гадаад валютын хувьд 18%-аас багагүй (2021: төгрөгийн хувьд 6%, гадаад

## **8 Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц (үргэлжлэл)**

валютын хувьд 18%) байдаг. Монголбанкны 2018 оны 3 сарын 29-ний өдрийн тогтоолын дагуу Банк тайлагналын өдрийн байдлаар заавал байлгах нөөцийн 50 хувийг хангадаг.

2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн эрсдэлийн зэрэглэлд тулгуурлан Монголбанкн дахь харилцах дансны зээлжих чанар нь “Хангалттай” байна. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжих зорилгоор заавал байлгах нөөц нь 2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар “1-р үе шат”-д байна.

Эдгээр үлдэгдлийн хүлээгдэж буй зээлийн алдагдал нь бага хэмжээтэй тул Банк ямар нэгэн зээлжих эрсдэлийн санг хүлээн зөвшөөрөөгүй. ХБЗА–ын тооцооллод ашигласан өгөгдөл, таамаглал болон тооцооллын аргачлалыг Тодруулга 38-аас үзнэ үү.

## **9 Бусад банкуудад байршуулсан хөрөнгө**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2021 оны 12 сарын 31</b>
Бусад банкууд дахь харилцах данс		
Гадаад	387,577,033	122,837,341
Дотоод	18,085,531	25,735,787
Богино хугацаатай бусад банкуудад байршуулсан хөрөнгө		
Гадаад	40,384,037	18,208,629
Дотоод	39,809,673	9,987,975
Бусад банкуудад анх 3 сараас их хугацаатай байршуулсан хөрөнгө	1,081,107,105	879,677,778
<b>Нийт бусад банкуудад байршуулсан хөрөнгө</b>	<b>1,566,963,380</b>	<b>1,056,447,510</b>

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар бусад банкуудад байршуулсан 3 сараас их хугацаатай хөрөнгөнд 1 жилээс 5 жилийн хугацаатай харилцах дансууд багтсан.

2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар эрсдэлийн зэрэглэлд үндэслэн хийсэн бусад банкнуудад байршуулсан хөрөнгийн зээлийн чанарын шинжилгээ болон хүлээгдэж буй эрсдэлийн эрсдэлийн алдагдлыг хэмжих зорилгоор бусад банкуудад байршуулсан хөрөнгийг 3 үе шаттайгаар үнэлсэн үнэлгээг дараах хүснэгтэд харуулав. Банкны хэрэглэсэн зээлийн эрсдэлийн зэрэглэлийг үнэлэх системийн тодорхойлолт, хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтийн аргачлал, төлбөрийн чадваргүй болох үеийн болон зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (SICR)-ийн тодорхойлолтыг Тодруулга 38-аас харна уу.

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2021 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын ХБЭА)</b>	<b>2020 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын ХБЭА)</b>
- Маш сайн	1,339,750,190	989,550,544
- Сайн	37,997,524	16,788,646
- Хангалттай	55,955,196	36,098,905
- Тусгай хяналттай	137,076,068	14,240,607
<b>Нийт дансны үнэ</b>	<b>1,570,778,978</b>	<b>1,056,678,702</b>
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	(3,815,598)	(231,192)
<b>Дансны үнэ</b>	<b>1,566,963,380</b>	<b>1,056,447,510</b>

Бусад банкнуудад байршуулсан хөрөнгийн валют, хүүгийн түвшин болон дуусгавар болох хугацааны шинжилгээг Тодруулга 38-аас харна уу.

## 10 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас	1,003,207,697	1,808,800,791
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар зайлшгүй хэмжигдэх өрийн үнэт цаас	222,344,690	165,954,333
Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас	4,698,623	4,684,750
<b>Нийт өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт</b>	<b>1,230,251,009</b>	<b>1,979,439,874</b>

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасны бууралт нь Монголбанкны үнэт цаас борлуулсантай холбоотой.

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын ангилал болон хэмжилтийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас	Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар зайлшгүй хэмжигдэх өрийн үнэт цаас	Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас	Нийт дүн
Монголбанкны үнэт цаас (а)	742,100,282	-	-	742,100,282
МИК бонд – давуу эрхтэй (б)	-	34,374,181	-	34,374,181
МИК бонд – энгийн эрхтэй (б)	-	137,676,182	-	137,676,182
Засгийн Газрын бонд (в)	205,799,112	-	4,759,631	210,558,743
ҮЦСК бонд – давуу эрхтэй (г)	-	35,105,919	-	35,105,919
ҮЦСК бонд – энгийн эрхтэй(г)	-	11,803,902	-	11,803,902
Компанийн бонд (д)	55,308,303	3,384,506	-	58,692,809
<b>2022 оны 12 сарын 31-нээрх нийт өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (бодит үнэ цэнэ ба нийт дансны үнэ)</b>	<b>1,003,207,697</b>	<b>222,344,690</b>	<b>4,759,631</b>	<b>1,230,312,018</b>
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	-	-	(61,009)	(61,009)
<b>2022 оны 12 сарын 31-нээрх нийт өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (дансны үнэ)</b>	<b>1,003,207,697</b>	<b>222,344,690</b>	<b>4,698,623</b>	<b>1,230,251,009</b>



## 10 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын ангилал болон хэмжилтийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас	Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар зайлшгүй хэмжигдэх өрийн үнэт цаас	Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас	Нийт дүн
Монголбанкны үнэт цаас (а)	1,563,001,736	-	-	1,563,001,736
МИК бонд – давуу эрхтэй (б)	-	41,800,489	-	41,800,489
МИК бонд – энгийн эрхтэй (б)	-	121,956,669	-	121,956,669
Засгийн Газрын бонд (в)	186,149,725	-	4,749,941	190,899,666
Компанийн бонд (д)	59,649,330	2,197,175	-	61,846,505
<b>2021 оны 12 сарын 31-нээрх нийт өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (бодит үнэ цэнэ ба нийт дансны үнэ)</b>	<b>1,808,800,791</b>	<b>165,954,333</b>	<b>4,749,941</b>	<b>1,979,505,065</b>
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	-	-	(65,191)	(65,191)
<b>2021 оны 12 сарын 31-нээрх нийт өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (дансны үнэ)</b>	<b>1,808,800,791</b>	<b>165,954,333</b>	<b>4,684,750</b>	<b>1,979,439,874</b>

### (а) Монголбанкны үнэт цаас

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Монголбанкны үнэт цаас нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор эзэмшиж буй “цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмших” бизнес загвартай хөрөнгө оруулалтын үнэт цаас юм.

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 3 сараас бага хугацаатай Монголбанкны үнэт цаас 647,154,123 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 1,563,001,736 мянган төгрөг) байсан бөгөөд мөнгөн гүйлгээний тайланд тусгах зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд бүртгэгдсэн. (Тодруулга 7).

Монголбанкны 205,728,000 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 223,554,000 мянган төгрөг) болон 42,800,000 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 28 хоногийн хугацаатай үнэт цаасыг Монголбангтай хийсэн Репо хэлцэлд (Тодруулга 23) болон Алт 2 хөтөлбөрт (Тодруулга 22) тус тус барьцаалсан.

### (б) МИК бонд

МИК бонд нь арилжааны банкнуудаас харилцагчдад олгосон ипотекийн зээлээр баталгааждаг ба ипотекийн зээлтэй ижил бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасны ангилалд багтдаг. Банк ипотекийн зээлийг худалдах зорилгоор анх хүлээн зөвшөөрсөн. (Тодруулга 3.3.12-оос харна уу). Энэхүү бонд нь Тодруулга 3-т тодруулсны дагуу МИК-ОССК-ийн үнэт цаасжуулах ажил гүйлгээтэй холбоотой ипотекийн зээлээр баталгаажсан “Энгийн” болон “Давуу” эрхтэй үнэт цаас (ОСЗБҮЦ) юм.

Тодруулга 3-т тайлбарласны дагуу зөвхөн давуу эрхтэй үнэт цаасны үндсэн төлбөр бүрэн төлөгдсөн тохиолдолд энгийн эрхтэй үнэт цаасны үндсэн төлбөрийг авах боломжтой ба давуу эрхтэй үнэт цаас эзэмшигчид нь төлбөрийн хувьд давуу эрхтэй. МИК-ОССК-ийн цэвэр хөрөнгө нь дутагдсан тохиолдолд үүнийг давуу болон энгийн үнэт цаас эзэмшигчид хариуцна (төлбөр болон давуу эрхийн хувьтай тэнцүү хэмжээгээр).

## **10 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)**

### **(с) Засгийн Газрын бонд**

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор эзэмшиж буй “цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмших” бизнес загвартай хөрөнгө оруулалтын үнэт цаас юм.

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор эзэмшиж буй “цуглуулах зорилгоор эзэмших” бизнес загвартай хөрөнгө оруулалтын үнэт цаас юм.

Засгийн Газрын 180,152,580 мянган төгрөгийн (2021 оны 12 сарын 31: байхгүй) нэрлэсэн үнэтэй бондыг гадны банкнаас эх үүсвэр татахын тулд барьцаалсан. Тодруулга 22-оос үзнэ үү.

### **(d) ҮЦСК бонд**

ҮЦСК бонд нь арилжааны банкуудаас харилцагчдад олгосон жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлээр баталгаажлаг ба зээлийн ангилалтай ижил бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасны ангилалд багтдаг. Банк жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийг худалдах зорилгоор анх хүлээн зөвшөөрсөн. (Тодруулга 3.3.13-аас харна уу). Энэхүү бонд нь Тодруулга 3-т тодруулсны дагуу ҮЦСК-ийн үнэт цаасжуулах ажил гүйлгээтэй холбоотой хөрөнгөөр баталгаажсан “Энгийн” болон “Давуу” эрхтэй үнэт цаас юм.

Тодруулга 3-т тайлбарласны дагуу зөвхөн давуу эрхтэй үнэт цаасны үндсэн төлбөр бүрэн төлөгдсөн тохиолдолд энгийн эрхтэй үнэт цаасны үндсэн төлбөрийг авах боломжтой ба давуу эрхтэй үнэт цаас эзэмшигчид нь төлбөрийн хувьд давуу эрхтэй. ҮЦСК-ийн цэвэр хөрөнгө нь дутагдсан тохиолдолд үүнийг давуу болон энгийн үнэт цаас эзэмшигчид хариуцна (төлбөр болон давуу эрхийн хувьтай тэнцүү хэмжээгээр).

### **(е) Компанийн бонд**

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх ангилалд зайлшгүй ангилагдсан өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт нь Банк арилжааны ашиг олох зорилгоор эзэмшиж буй “худалдан борлуулах зорилгоор эзэмших” бизнес загвартай үнэт цаас юм. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед Банк компанийн бондыг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрсөн. Энэхүү ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх компанийн бонд нь бодит үнэ цэнээр бүртгэгддэг бөгөөд бодит үнэ цэнэ нь зээлийн эрсдэлтэй холбоотой аливаа бууралтыг тусгадаг ба Банкны зээлийн эрсдэлд өртөх хэмжээг хамгийн сайн илэрхийлдэг бөгөөд барьцаалагдаагүй болно.

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Компанийн бонд нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор эзэмшиж буй “цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмших” бизнес загвартай хөрөнгө оруулалтын үнэт цаас юм. Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Компанийн бонд нь Монгол Улсын Хөрөнгийн биржид бүртгэлтэй бөгөөд Монголын Ипотекийн Корпорациас жилийн 8.85%-ийн хүүтэй гаргасан бонд юм.

38,372,844 мянган төгрөгийн (2021 оны 12 сарын 31: байхгүй) нэрлэсэн үнэтэй, бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх компанийн бондыг репо хэлцэлд барьцаалсан. Тодруулга 23-аас үзнэ үү.

## 10 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Монголбанкны үнэт цаасны дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	2022 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын ХБЭА)	2021 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын ХБЭА)
<b>Монголбанкны үнэт цаас</b>		
- Маш сайн	743,009,418	1,563,953,019
<b>Нийт хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх дансны үнэ</b>	<b>743,009,418</b>	<b>1,563,953,019</b>
Хасах нь : Зээлжих эрсдэлийн сан	(909,136)	(951,283)
<b>Дансны үнэ (бодит үнэ цэнэ)</b>	<b>742,100,282</b>	<b>1,563,001,736</b>

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Засгийн Газрын бондыг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	2022 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын ХБЭА)	2021 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын ХБЭА)
<b>Засгийн Газрын бонд</b>		
- Маш сайн	235,807,611	185,898,487
<b>Нийт хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх дансны үнэ</b>	<b>235,807,611</b>	<b>185,898,487</b>
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	(3,208,263)	(2,675,792)
Хасах нь: Хорогдуулсан өртгөөс бодит үнэ цэнэ рүү бүртгэснээс үүсэх бодит үнэ цэнийн тохируулга	(26,800,236)	2,927,030
<b>Дансны үнэ (бодит үнэ цэнэ)</b>	<b>205,799,112</b>	<b>186,149,725</b>

## 10 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Компанийн бондыг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
	1-р үе шат (12 сарын ХБЭА)	1-р үе шат (12 сарын ХБЭА)
<b>Компанийн бонд</b>		
- Хангалттай	77,283,289	60,510,603
<b>Нийт хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх дансны үнэ</b>	<b>77,283,289</b>	<b>60,510,603</b>
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	(1,033,273)	(861,273)
Хасах нь: Хорогдуулсан өртгөөс бодит үнэ цэнэ рүү бүртгэснээс үүсэх бодит үнэ цэнийн тохируулга	(20,941,714)	-
<b>Дансны үнэ (бодит үнэ цэнэ)</b>	<b>55,308,303</b>	<b>59,649,330</b>

Дээрх хүснэгтэнд ашигласан зээлийн эрсдэлийн зэрэглэлийн тайлбарыг Тодруулга 38-аас харна уу.

## 10 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасны зээлжих эрсдэлийн сан болон нийт хорогдуулсан өртгөөрх дансны үнийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	Зээлжих эрсдэлийн сан 1-р үе шат (12 сарын ХБЭА)	Дансны үнэ 1-р үе шат (12 сарын ХБЭА)
<b>Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Монголбанкны үнэт цаас</b>		
<b>2022 оны 1 сарын 1-нээрх</b>	<b>951,283</b>	<b>1,563,953,019</b>
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөний өөрчлөлт:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	909,136	10,764,975,676
Данснаас хасагдсан	(951,283)	(11,585,919,277)
<b>2022 оны 12 сарын 31-нээрх</b>	<b>909,136</b>	<b>743,009,418</b>
<b>Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Засгийн газрын бонд</b>		
<b>2022 оны 1 сарын 1-нээрх</b>	<b>2,675,792</b>	<b>188,825,517</b>
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөний өөрчлөлт:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	532,471	12,699,418
<b>Нийт дансны үнэ</b>	<b>3,208,263</b>	<b>201,524,935</b>
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>		
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад өөрчлөлт	-	37,209,706
Хорогдуулсан өртгөөс бодит үнэ цэнэ рүү бүртгэснээс үүсэх бодит үнэ цэнийн тохируулга	-	(29,727,266)
<b>2022 оны 12 сарын 31-нээрх</b>	<b>3,208,263</b>	<b>209,007,375</b>
<b>Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Компанийн бонд</b>		
<b>2022 оны 1 сарын 1-нээрх</b>	<b>861,273</b>	<b>60,510,603</b>
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөний өөрчлөлт:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	172,000	3,676,959
<b>Нийт дансны үнэ</b>	<b>1,033,273</b>	<b>64,187,562</b>
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>		
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад өөрчлөлт	-	12,849,960
Хорогдуулсан өртгөөс бодит үнэ цэнэ рүү бүртгэснээс үүсэх бодит үнэ цэнийн тохируулга	-	(20,695,946)
<b>2022 оны 12 сарын 31-нээрх</b>	<b>1,033,273</b>	<b>56,341,576</b>

## 10 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасны зээлжих эрсдэлийн сан болон нийт хорогдуулсан өртгөөрх дансны үнийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	Зээлжих эрсдэлийн сан 1-р үе шат (12 сарын ХБЭА)	Дансны үнэ 1-р үе шат (12 сарын ХБЭА)
<b>Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Монголбанкны үнэт цаас</b>		
<b>2021 оны 1 сарын 1-нээрх</b>	<b>632,582</b>	<b>1,097,569,862</b>
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөний өөрчлөлт:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	951,283	1,563,953,019
Данснаас хасагдсан	(632,582)	(1,097,569,862)
<b>2021 оны 12 сарын 31-нээрх</b>	<b>951,283</b>	<b>1,563,953,019</b>
<b>Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Засгийн газрын бонд</b>		
<b>2021 оны 1 сарын 1-нээрх</b>	<b>2,073,263</b>	<b>147,966,809</b>
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөний өөрчлөлт:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	602,529	40,904,496
<b>Нийт дансны үнэ</b>	<b>2,675,792</b>	<b>188,871,305</b>
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>		
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад өөрчлөлт	-	(45,788)
<b>2021 оны 12 сарын 31-нээрх</b>	<b>2,675,792</b>	<b>188,825,517</b>
<b>Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх Компанийн бонд</b>		
<b>2021 оны 1 сарын 1-нээрх</b>	-	-
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөний өөрчлөлт:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	861,273	60,533,309
<b>Нийт дансны үнэ</b>	<b>861,273</b>	<b>60,533,309</b>
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>		
FX and other movements	-	(22,706)
<b>2021 оны 12 сарын 31-нээрх</b>	<b>861,273</b>	<b>60,510,603</b>

## 10 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

### Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	2022 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын ХБЭА)	2021 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын ХБЭА)
<b>Засгийн Газрын бонд</b>		
- Хангалттай	4,759,632	4,749,941
<b>Нийт хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (нийт дансны үнэ)</b>	<b>4,759,632</b>	<b>4,749,941</b>
<b>Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан</b>	<b>(61,009)</b>	<b>(65,191)</b>
<b>Нийт хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (дансны үнэ)</b>	<b>4,698,623</b>	<b>4,684,750</b>

Дээрх хүснэгтэнд ашигласан зээлийн эрсдэлийн зэрэглэлийн тайлбарыг Тодруулга 38-аас харна уу.

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын зээлжих эрсдэлийн сангийн өөрчлөлтийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	Зээлжих эрсдлийн сан 1-р үе шат (12 сарын ХБЭА)	Дансны үнэ 1-р үе шат (12 сарын ХБЭА)
<b>Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх Засгийн Газрын бонд</b>		
<b>2022 оны 1 сарын 1-нээрх</b>	<b>65,191</b>	<b>4,749,941</b>
<i>Тайлант хугацааны зээлжих эрсдэлийн сангийн нөлөөны өөрчлөлт:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	(4,181)	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	-	9,691
<b>Нийт тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан өөрчлөлт</b>	<b>(4,181)</b>	<b>9,691</b>
<b>2022 оны 12 сарын 31-нээрх</b>	<b>61,009</b>	<b>4,759,632</b>

## 10 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын зээлжих эрсдэлийн сангийн өөрчлөлтийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Зээлжих эрсдэлийн сан 1-р үе шат (12 сарын ХБЭА)</b>	<b>Дансны үнэ 1-р үе шат (12 сарын ХБЭА)</b>
<b>Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдөх Засгийн Газрын бонд</b>		
<b>2021 оны 1 сарын 1-нээрх</b>	<b>62,515</b>	<b>4,741,411</b>
<i>Тайлант хугацааны зээлжих эрсдэлийн сангийн нөлөөны өөрчлөлт:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	2,676	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	-	8,530
<b>Нийт тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан өөрчлөлт</b>	<b>2,676</b>	<b>8,530</b>
<b>2021 оны 12 сарын 31-нээрх</b>	<b>65,191</b>	<b>4,749,941</b>

## 11 Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2021 оны 12 сарын 31</b>
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаас	22,103,523	17,927,851
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаас	409,968	544,864
<b>Нийт өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт</b>	<b>22,513,491</b>	<b>18,472,715</b>

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын ангилал болон хэмжилтийг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаас</b>	<b>Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаас</b>	<b>Нийт дүн</b>
Компанийн хувьцаа	22,103,523	409,968	<b>22,513,491</b>
<b>2022 оны 12 сарын 31-нээрх нийт өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт</b>	<b>22,103,523</b>	<b>409,968</b>	<b>22,513,491</b>



## 11 Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын ангилал болон хэмжилтийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаас	Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаас	Нийт дүн
Компанийн хувьцаа	17,927,851	544,864	18,472,715
<b>2021 оны 12 сарын 31-нээрх нийт өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт</b>	<b>17,927,851</b>	<b>544,864</b>	<b>18,472,715</b>

### (a) Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх компанийн хувьцаануудад арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа үнэт цааснууд болон анх хүлээн зөвшөөрөхдөө бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх сонголтыг хийгээгүй өмчийн бусад үнэт цааснууд багтана.

Компанийн хувьцааны дийлэнх нь Монгол Улсын Хөрөнгийн биржид бүртгэлтэй “АПУ ХК” (“APU JSC”) болон Монголын Ипотекийн Корпорацийн хувьцаануудаас бүрдэнэ. Эдгээр нь 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 20,740,142 мянган төгрөг болон 1,266,411 мянган төгрөг (2021: 15,345,248 мянган төгрөг болон 2,450,864 мянган төгрөг) бүхий бодит үнэ цэнэтэй байсан.

### (b) Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банк бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаасны 409,968 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Энэ ангиллын хөрөнгийг арилжаалж ашиг олох зорилгоор бус стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалт хэлбэрээр хийсэн бөгөөд богино болон дунд хугацаанд энэхүү хөрөнгө оруулалтыг худалдах төлөвлөгөө байхгүй. Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаасны бууралт нь Банк үнэ нь мэдэгдэхүйц буурсан хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаагаарх хөрөнгө оруулалтаа борлуулсантай холбоотой.

## 12 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт дансны үнэ Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	3,459,083,356 (199,150,359)	3,110,945,995 (160,974,133)
<b>Нийт хорогдуулсан өртгөөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны дансны үнэ</b>	<b>3,259,932,997</b>	<b>2,949,971,862</b>
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа /Орон сууцны зээл/	394,529,262	304,232,064
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа / ЖДБ-ийн зээл/	17,260,939	83,823,576
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа /Байгууллагын зээл/	25,910,147	1,147,335
<b>Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа</b>	<b>3,697,633,345</b>	<b>3,339,174,837</b>

## 12 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Банк нь Монголын Ипотекийн Корпорацид худалдах зээлийн багц болон Монголбанкны урт хугацаатай репо санхүүжилтээр олгогдсон ЖДБ-ийн зээлийн багцыг эзэмшдэг ба эдгээр багц нь СТОУС 9-ийн дагуу худалдах зорилгоор эзэмшиж буй бизнес загварт багтсан. Иймд харилцагчдад олгосон уг зээлүүдийг “бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх” ангилалд анх хүлээн зөвшөөрсөн. Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх ангилалтай компанийн зээл нь өмнө нь үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэсэн ангилалтай байсан хэрэглүүрүүд юм. Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх зээл ба урьдчилгааны эрсдэлийг тооцож хэмжилт хийсэн. Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дансны дүн нь Банкны тооцооллоорх хүлээж болзошгүй хамгийн их зээлийн эрсдэл болно.

Хорогдуулсан өртгөөр ангилагдсан харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа дансны нийт үлдэгдэл болон зээлжих эрсдэлийн санг 2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар ангиллаар нь задлан доорх хүснэгтэнд үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31			2021 оны 12 сарын 31		
	Нийт дансны үнэ	Зээлжих эрсдэлийн сан	Дансны үнэ	Нийт дансны үнэ	Зээлжих эрсдэлийн сан	Дансны үнэ
<b>Байгууллагад олгосон зээл</b>						
Бизнесийн зээл	1,163,669,938	(103,906,237)	<b>1,059,763,701</b>	1,220,124,468	(26,680,865)	<b>1,193,443,603</b>
Жижиг дунд бизнесийн зээл	949,395,836	(36,581,312)	<b>912,814,523</b>	825,665,816	(39,873,780)	<b>785,792,036</b>
<b>Хувь хүнд олгосон зээл</b>						
Хэрэглээний зээл	887,392,253	(53,826,353)	<b>833,565,900</b>	722,421,933	(87,273,003)	<b>635,148,930</b>
Орон сууцны зээл	458,625,329	(4,836,457)	<b>453,788,872</b>	342,733,778	(7,146,485)	<b>335,587,293</b>
<b>Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа</b>						
	<b>3,459,083,356</b>	<b>(199,150,359)</b>	<b>3,259,932,997</b>	<b>3,110,945,995</b>	<b>(160,974,133)</b>	<b>2,949,971,862</b>

Хуулийн этгээд болон хувь хүнд олгосон зээлийн ангиллыг доор тайлбарлав:

- Бизнесийн зээл – Том аж ахуйн нэгжид стандарт нөхцөлийн дагуу олгосон зээл;
- Жижиг дунд бизнесийн зээл – Жижиг болон дунд бизнес эрхлэгчдэд олгосон зээл;
- Хэрэглээний зээл;
- Орон сууцны зээл.

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зах зээлийн хүүгээс бага хүүтэй олгогдсон зээлүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс 235,786 мянган төгрөгийн (2021 оны 12 сарын 31: 2,636,090 мянган төгрөг) гарзыг орлого үр дүнгийн тайланд тусгасан.

## 12 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Хорогдуулсан өртгөөр ангилагдсан харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт үлдэгдэл болон зээлжих эрсдэлийн сангийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг доорх хүснэгтэнд үзүүлэв:

	Зээлжих эрсдэлийн сан			Нийт дүн	Нийт дансны үнэ			Нийт дүн
	1-р үе шат (12 сарын ХБЭА)	2-р үе шат (зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	3-р үе шат (үнэ цэнэ буурсан зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)		1-р үе шат (12 сарын хугацаанд зээлээс ХБЭА)	2-р үе шат (зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	3-р үе шат (үнэ цэнэ буурсан зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	
<i>Мянган төгрөгөөр</i>								
<b>Бизнесийн зээл</b>								
<b>2022 оны 1 сарын 1</b>	<b>4,952,809</b>	<b>910,058</b>	<b>20,817,997</b>	<b>26,680,865</b>	<b>887,463,025</b>	<b>194,269,029</b>	<b>138,392,414</b>	<b>1,220,124,468</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан өөрчлөлт:</i>								
<i>Шилжилт:</i>								
-дуусах хугацааны турш (1-р үе шатнаас 2-р үе шат руу)	(9,723,568)	9,647,699	-	<b>(75,869)</b>	(171,813,770)	171,813,770	-	-
- зээлийн үнэ цэнэ буурсан (1 ба 2-р үе шатнаас 3-р үе шат руу)	-	(4,614,545)	76,913,785	<b>72,299,240</b>	-	(103,046,660)	103,046,660	-
- 12 сарын хугацааны ХБЭА (2 ба 3-р үе шатнаас 1-р үе шат руу)	41,800	-	-	<b>41,800</b>	12,730,853	(12,730,853)	-	-
- 3-р үе шатнаас 2-р үе шат руу	-	-	-	-	-	2,739,324	(2,739,324)	-
Шинээр олгосон ба худалдан авсан	10,543,639	-	-	<b>10,543,639</b>	631,981,497	-	-	<b>631,981,497</b>
Данснаас хасагдсан	(3,350,487)	-	(3,591,034)	<b>(6,941,521)</b>	(480,596,160)	(122,948,008)	(80,206,493)	<b>(683,750,661)</b>
Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтийн загварын таамаглалд орсон өөрчлөлт	-	-	(105,037)	<b>(105,037)</b>	-	-	-	-
Хямдруулалт	274,269	-	1,283,204	<b>1,557,473</b>	-	-	-	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	(25,483)	-	2,597,181	<b>2,571,698</b>	(4,667,786)	(117,736)	4,527,675	<b>(257,846)</b>
Бусад өөрчлөлт	83,563	99,459	2,696,872	<b>2,879,894</b>	2,735,740	182,273	751,198	<b>3,669,211</b>
<b>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт</b>	<b>(2,156,268)</b>	<b>5,132,614</b>	<b>79,794,971</b>	<b>82,771,316</b>	<b>(9,629,625)</b>	<b>(64,107,889)</b>	<b>25,379,716</b>	<b>(48,357,799)</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>								
Данснаас хасагдсан	-	-	(5,117,648)	<b>(5,117,648)</b>	-	-	(5,117,648)	<b>(5,117,648)</b>
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад өөрчлөлт	(27,542)	(99,459)	(301,296)	<b>(428,296)</b>	(2,735,740)	(182,273)	(61,070)	<b>(2,979,083)</b>
<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2,769,000</b>	<b>5,943,213</b>	<b>95,194,025</b>	<b>103,906,237</b>	<b>875,097,660</b>	<b>129,978,867</b>	<b>158,593,412</b>	<b>1,163,669,938</b>

## 12 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Хорогдуулсан өртгөөр ангилагдсан харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт үлдэгдэл болон зээлжих эрсдэлийн сангийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг доорх хүснэгтэнд үзүүлэв:

	Зээлжих эрсдэлийн сан			Нийт дүн	Нийт дансны үнэ			Нийт дүн
	1-р үе шат (12 сарын ХБЭА)	2-р үе шат (зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	3-р үе шат (үнэ цэнэ буурсан зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)		1-р үе шат (12 сарын хугацаанд зээлээс ХБЭА)	2-р үе шат (зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	3-р үе шат (үнэ цэнэ буурсан зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	
<i>Мянган төгрөгөөр</i>								
<b>Бизнесийн зээл</b>								
<b>2021 оны 1 сарын 1</b>	5,495,895	768,810	14,803,140	<b>21,067,845</b>	660,249,504	198,154,010	406,313,750	<b>1,264,717,264</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан өөрчлөлт:</i>								
Шилжилт:								
-дуусах хугацааны турш (1-р үе шатнаас 2-р үе шат руу)	(7,800,225)	7,652,535	-	<b>(147,690)</b>	(126,182,477)	126,182,477	-	-
- зээлийн үнэ цэнэ буурсан (1 ба 2-р үе шатнаас 3-р үе шат руу)	-	(6,742,476)	6,603,060	<b>(139,416)</b>	-	(35,166,024)	35,166,024	-
- 12 сарын хугацааны ХБЭА (2 ба 3-р үе шатнаас 1-р үе шат руу)	221,412	(518)	-	<b>220,894</b>	44,197,542	(44,197,542)	-	-
- 3-р үе шатнаас 2-р үе шат руу	-	-	-	-	-	29,737,826	(29,737,826)	-
Шинээр олгосон ба худалдан авсан	11,214,561	-	-	<b>11,214,561</b>	754,858,575	-	-	<b>754,858,575</b>
Данснаас хасагдсан	(4,218,461)	(810,028)	(795,595)	<b>(5,824,084)</b>	(434,809,749)	(80,441,719)	(255,613,518)	<b>(770,864,986)</b>
Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтийн загварын таамаглалд орсон өөрчлөлт	(150,867)	147,691	17,622,200	<b>17,619,024</b>	-	-	-	-
Хямдруулалт	136,090	41,735	207,392	<b>385,217</b>	-	-	-	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	(17,284)	(52,390)	(116,222)	<b>(185,896)</b>	(2,170,795)	(705,527)	(679,465)	<b>(3,555,787)</b>
Бусад өөрчлөлт	(68,245)	(95,301)	(1,049,639)	<b>(1,213,185)</b>	(11,038,897)	(124,198)	21,964	<b>(11,141,131)</b>
<b>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт</b>	<b>(683,019)</b>	<b>141,248</b>	<b>22,471,196</b>	<b>21,929,425</b>	<b>224,854,199</b>	<b>(4,714,707)</b>	<b>(250,842,821)</b>	<b>(30,703,329)</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй өөрчлөлт:</i>								
Данснаас хасагдсан	-	-	(17,482,784)	<b>(17,482,784)</b>	-	-	(17,482,784)	<b>(17,482,784)</b>
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад өөрчлөлт	139,933	-	1,026,446	<b>1,166,379</b>	2,359,322	829,726	404,269	<b>3,593,317</b>
<b>2021 оны 12 сарын 31</b>	<b>4,952,809</b>	<b>910,058</b>	<b>20,817,998</b>	<b>26,680,865</b>	<b>887,463,025</b>	<b>194,269,029</b>	<b>138,392,414</b>	<b>1,220,124,468</b>

**12 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)**

	Зээлжих эрсдэлийн сан				Нийт дансны үнэ			
	1-р үе шат (12 сарын ХБЭА)	2-р үе шат (зээлийн эрсдэл нь мэдэгдэхүй ц өссөн зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	3-р үе шат (үнэ цэнэ буурсан зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	Нийт дүн	1-р үе шат (12 сарын хугацаанд зээлээс ХБЭА)	2-р үе шат (зээлийн эрсдэл нь мэдэгдэхүй ц өссөн зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	3-р үе шат (үнэ цэнэ буурсан зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	Нийт дүн
<i>Мянган төгрөгөөр</i>								
<b>Жижиг дунд бизнесийн зээл</b>								
<b>2022 оны 1 сарын 1</b>	<b>3,190,681</b>	<b>47,759</b>	<b>36,635,340</b>	<b>39,873,780</b>	<b>661,604,004</b>	<b>13,238,715</b>	<b>150,823,097</b>	<b>825,665,816</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан өөрчлөлт:</i>								
<i>Шилжилт:</i>								
- дуусах хугацааны турш (1-р үе шатнаас 2-р үе шат руу)	(2,875,406)	2,760,253	-	(115,152)	(62,754,031)	62,754,031	-	-
- зээлийн үнэ цэнэ буурсан (1 ба 2-р үе шатнаас 3-р үе шат руу)	-	(2,684,964)	3,196,345	511,380	-	(23,231,680)	23,231,680	-
- 12 сарын хугацааны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (2 ба 3-р үе шатнаас 1-р үе шат руу)	4,433	(295,701)	-	(291,268)	5,375,340	(5,375,340)	-	-
- 3-р үе шатнаас 2-р үе шат руу	-	281,450	(281,474)	(24)	-	7,630,594	(7,630,594)	-
Шинээр олгосон ба худалдан авсан	3,479,090	-	-	3,479,090	505,966,217	-	-	505,966,217
Данснаас хасагдсан	(3,006,361)	(16,846)	(9,396,958)	(12,420,166)	(318,561,374)	(13,959,295)	(50,726,731)	(383,247,400)
Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтийн загварын таамаглалд орсон өөрчлөлт	-	-	51,140	51,140	-	-	5,100,090	5,100,090
Хямдруулалт	303,424	-	3,370,313	3,673,737	-	-	-	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	(15,405)	3	570,305	554,903	(570,442)	(120)	(1,213,284)	(1,783,846)
Бусад өөрчлөлт	(11,378)	(3)	1,380,626	1,369,245	79,711	0	(2,214,748)	(2,135,037)
<b>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт</b>	<b>(2,121,604)</b>	<b>44,192</b>	<b>(1,109,702)</b>	<b>(3,187,115)</b>	<b>129,535,421</b>	<b>27,818,191</b>	<b>(33,453,587)</b>	<b>123,900,025</b>
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй нийт өөрчлөлт:</i>								
Данснаас хасагдсан	-	-	(72,881)	(72,881)	-	-	(72,881)	(72,881)
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад өөрчлөлт	(3,755)	(0)	(28,717)	(32,472)	(79,711)	(0)	(17,412)	(97,123)
<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>1,065,322</b>	<b>91,951</b>	<b>35,424,039</b>	<b>36,581,312</b>	<b>791,059,713</b>	<b>41,056,905</b>	<b>117,279,217</b>	<b>949,395,836</b>

**12 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)**

	Зээлжих эрсдэлийн сан				Нийт дансны үнэ			
	1-р үе шат (12 сарын ХБЭА)	2-р үе шат (зээлийн эрсдэл нь мэдэгдэхүй ц өссөн зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	3-р үе шат (үнэ цэнэ буурсан зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	Нийт дүн	1-р үе шат (12 сарын хугацаанд зээлээс ХБЭА)	2-р үе шат (зээлийн эрсдэл нь мэдэгдэхүй ц өссөн зээлүүдийн н дуусах хугацааны турш дахь ХБЭА)	3-р үе шат (үнэ цэнэ буурсан зээлүүдийн дуусах хугацааны турш дахь ХБЭА)	Нийт дүн
<i>Мянган төгрөгөөр</i>								
<b>Жижиг дунд бизнесийн зээл</b>								
<b>2021 оны 1 сарын 1</b>	<b>2,152,696</b>	<b>1,142,603</b>	<b>32,827,277</b>	<b>36,122,576</b>	<b>391,957,308</b>	<b>79,351,278</b>	<b>218,712,921</b>	<b>690,021,507</b>
<i>Тайлант хугацаанд нэмж байгуулсан зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан өөрчлөлт:</i>								
<i>Шилжилт:</i>								
- дуусах хугацааны турш (1-р үе шатнаас 2-р үе шат руу)	(3,285,934)	3,287,076	-	<b>1,142</b>	(49,635,585)	49,635,585	-	-
- зээлийн үнэ цэнэ буурсан (1 ба 2-р үе шатнаас 3-р үе шат руу)	-	(3,583,626)	5,477,972	<b>1,894,346</b>	-	(54,255,301)	54,255,301	-
- 12 сарын хугацааны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (2 ба 3-р үе шатнаас 1-р үе шат руу)	998,633	(1,389,277)	-	<b>(390,644)</b>	44,721,620	(44,721,620)	-	-
- 3-р үе шатнаас 2-р үе шат руу	-	920,838	(941,661)	<b>(20,823)</b>	-	28,767,092	(28,767,092)	-
Шинээр олгосон ба худалдан авсан	5,414,768	-	-	<b>5,414,768</b>	547,116,848	-	-	<b>547,116,848</b>
Данснаас хасагдсан	(1,749,590)	(1,169,200)	(2,457,227)	<b>(5,376,017)</b>	(276,988,379)	(44,654,934)	(68,259,192)	<b>(389,902,505)</b>
Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтийн загварын таамаглалд орсон өөрчлөлт	(131,553)	586	15,093,617	<b>14,962,650</b>	-	-	-	-
Хямдруулалт	96,836	592	2,441,449	<b>2,538,877</b>	-	-	-	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	(10,434)	(111)	2,247,273	<b>2,236,728</b>	(654,487)	(21,279)	2,261,059	<b>1,585,293</b>
Бусад өөрчлөлт	(269,428)	838,278	300,080	<b>868,930</b>	5,129,919	(875,798)	(9,044,669)	<b>(4,790,548)</b>
2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлсэн. Хараат бус үнэлгээний байгууллагууд болох Файн Эстимэйт ХХК болон Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн ойролцоо байршилтай, адил төрлийн хөрөнгийг үнэлж байсан туршлагатай мэргэжлийн хөрөнгийн үнэлгээчдээр үнэлгээг хийлгэсэн. Үнэлгээний суурь нь зах зээлийн үнийн аргачлал (Улаанбаатар хотод байршилтай ижил төрлийн барилга байгууламжийн зах зээлийн үнэ) үнэлгээ хийж буй хөрөнгийн зөрүүг багасгахын тулд өртгийн аргаар зэрэг үнэлүүлсэн.

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар барилга байгууламжийн элэгдлийг хассан өртгийн аргаар бүртгэсэн бол дансны үнэ нь 95,966,159 мянган төгрөг (2021: MNT 95,165,144 мянган төгрөг) байх байсан.

Барилга байгууламжийн дансны үнийн задаргааг дор харуулав:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2021 оны 12 сарын 31</b>
Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан барилгын дахин үнэлэгдсэн дүн	102,710,381	102,159,805
Өөрийн хөрөнгөнд тусгагдсан дахин үнэлгээний нөөц сан	(6,994,662)	(7,245,102)
Хуримтлагдсан ашиг руу шилжсэн дахин үнэлгээний нөөц сан	250,441	250,441
<b>Хуримтлагдсан элэгдлийг хассан барилга байгууламжийн өртөг</b>	<b>95,966,159</b>	<b>95,165,144</b>

Бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан өгөгдөл, тооцооллын аргачлал болон мэдрэмтгий байдлын шинжилгээг Тодруулга 42-оос харна уу.

## **17 Ашиглах эрхтэй хөрөнгө**

Банк нь оффис, АТМ-н талбай, гарааш болон архивын зориулалттай талбайг түрээслэдэг. Түрээсийн гэрээ нь ихэвчлэн 1-10 жилийн тогтмол хугацаатай хийгддэг.

Ашиглах эрхтэй хөрөнгийг төрлөөр нь ангилан дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Барилга</b>	<b>Бусад</b>	<b>Нийт дүн</b>
<b>2021 оны 1 сарын 1-нээрх дансны үнэ</b>	<b>7,074,760</b>	<b>2,807,976</b>	<b>9,882,736</b>
Нэмэгдсэн	8,595,473	-	<b>8,595,473</b>
Данснаас хассан	(192,198)	-	<b>(192,198)</b>
Элэгдлийн зардал	(4,558,618)	(726,245)	<b>(5,284,863)</b>
<b>2021 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ</b>	<b>10,919,417</b>	<b>2,081,731</b>	<b>13,001,148</b>
Нэмэгдсэн	8,090,621	1,193	<b>8,091,813</b>
Данснаас хассан	(234,333)	-	<b>(234,333)</b>
Элэгдлийн зардал	(4,954,003)	(712,003)	<b>(5,666,006)</b>
<b>2022 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ</b>	<b>13,821,702</b>	<b>1,370,920</b>	<b>15,192,622</b>

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар түрээсийн өр төлбөрөөс тооцогдсон хүүгийн зардал 1,481,221 мянган төгрөг (2021: 1,560,592 мянган төгрөг). Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардалд богино хугацаат түрээсийн зардал орсон.

## 17 Ашиглах эрхтэй хөрөнгө (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Богино хугацаатай түрээсийн зардал	29	1,923,903	1,397,273

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар түрээст нийт 9,604,783 мянган төгрөг (2021: 8,117,052 мянган төгрөг)-ийг төлсөн.

Түрээсийн гэрээнд түрээслүүлэгчийн эзэмшдэг түрээсийн хөрөнгийн аюулгүй байдлын ашиг сонирхлоос бусад гэрээгээр хүлээх үүрэг байхгүй болно. Түрээсэлсэн хөрөнгийг зээл авахад барьцаа болгон ашиглаж болохгүй.

## 18 Өмчлөх бусад хөрөнгө

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	6,146,252	59,418,813
Өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн бус хөрөнгө	123,115,315	109,706,448
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	(86,070,246)	(62,172,093)
<b>Нийт өмчлөх бусад хөрөнгө</b>	<b>43,191,321</b>	<b>106,953,168</b>

Өмчлөх бусад хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн өрөнд хураагдсан барьцаа хөрөнгө болох үл хөдлөх хөрөнгийг илэрхийлнэ. Банкны зүгээс эдгээр хөрөнгийг ойрын хугацаанд зарж борлуулах төлөвлөгөөтэй байгаа. Үнэт цаас зэрэг санхүүгийн хөрөнгө хэлбэрээр түр хугацаагаар авсан барьцаа хөрөнгийг СТОУС-ын хэмжилтийн зорилгоор тэдгээрийг өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт гэж ангилж, бодит үнэ цэнээр нь хэмждэг. Эдгээр хөрөнгийг олж авах үедээ борлуулах зардлыг хассан бодит үнээр нь анхлан хүлээн зөвшөөрсөн.

2022 онд Банк нь удирдлагын шийдвэрийн дагуу 16,901,051 мянган төгрөг (2021: 69,461,677 мянган төгрөг)-ийн өмчлөх бусад хөрөнгийг хугацаа хэтэрсэн зээлийн оронд хураан авч, 9,557,812 мянган төгрөгийн өмчлөх бусад хөрөнгийг борлуулах зориулалттай эргэлтийн бусад хөрөнгө рүү ангилсан.

Тухайн жилд 63,422,364 мянган төгрөг (2021: 11,860,012 мянган төгрөг)-ийн хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн ангиллаас өмчлөх бусад хөрөнгө рүү шилжүүлсэн.

Санхүүгийн өмчлөх бусад хөрөнгийн 2022 оны бодит үнэ цэнийн гарз нь 45,272,561 мянган төгрөг (2021: 30,337,628 мянган төгрөг)-байсан. Тодруулга 3.18-с харна уу.

Өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн бус хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулах явцад хураан авсан үндсэн хөрөнгийг илэрхийлнэ. Дээр дурдсан үнэ цэнийн бууралтын сан нь санхүүгийн бус хөрөнгөтэй холбоотой. Өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар Тодруулга 4.29-өөс харна уу.

## **18 Өмчлөх бусад хөрөнгө (үргэлжлэл)**

2022 болон 2021 онд өмчлөх бусад хөрөнгөд хураан авсан санхүүгийн бус барьцаа хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санд гарсан өөрчлөлтийг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2021 оны 12 сарын 31</b>
<b>1 сарын 1-ний өдрөөрх өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан</b>	<b>62,172,093</b>	<b>39,722,685</b>
Тайлант жилд байгуулсан үнэ цэнийн бууралтын сан	51,625,237	17,013,863
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөөс шилжиж ирсэн	-	5,086,192
Бусад хөрөнгөөс шилжиж ирсэн	-	449,572
Тайлант жилд төлөгдөхгүй хэмээн сангаас хаасан	(6,463,242)	(100,219)
Зарагдсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан	(21,263,842)	-
<b>12 сарын 31-нээрх өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан</b>	<b>86,070,246</b>	<b>62,172,093</b>

## **19 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө**

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөд өмнө нь хугацаа хэтэрсэн зээлийн ерөнд хураан авсан өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй байсан үл хөдлөх хөрөнгүүд багтана. Удирдлагын зүгээс ангилал шилжүүлэх бүрд борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг худалдах төлөвлөгөө гаргасан. Банк эдгээр хөрөнгүүдийг борлуулахын тулд худалдан авагчийг идэвхтэй хайж байгаа ба борлуулалтыг 12 сарын дотор хийж дуусгахаар ажиллаж байна. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн талаар Тодруулга 4.10-аас харна уу.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн үндсэн ангиллуудыг дор харуулав:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2021 оны 12 сарын 31</b>
Оффис ба худалдааны зориулалттай талбай	2,155,349	63,735,430
Орон сууц ба байшин	2,727,220	10,349,106
Барилга байгууламж	900,000	-
Бусад	905,006	-
<b>Нийт борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>6,687,575</b>	<b>74,084,536</b>

2022 онд банк 9,784,472 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 14,371,377 мянган төгрөг)-ийн дүнтэй орон сууц, оффис болон худалдааны зориулалттай талбайг худалдан борлуулсан байна. Тухайн жилд 63,422,364 мянган төгрөгийн борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөөс өмчлөх бусад хөрөнгө рүү, 9,557,812 мянган төгрөгийн өмчлөх бусад хөрөнгөөс борлуулах зориулалттай хөрөнгө рүү тус тус шилжүүлсэн.

## **20 Бусад банкуудын байршуулсан хөрөнгө**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2021 оны 12 сарын 31</b>
Бусад банкуудын байршуулсан богино хугацаат хөрөнгө	52,394,763	16,782,536
<b>Нийт бусад банкуудын байршуулсан хөрөнгө</b>	<b>52,394,763</b>	<b>16,782,536</b>

## **20 Бусад банкуудын байршуулсан хөрөнгө (үргэлжлэл)**

Бусад банк, санхүүгийн байгууллагуудын байршуулсан хөрөнгө нь дотоодын болон гадаадын банкуудаас Банкинд гадаад болон дотоодын валютаар хийгдсэн харилцах данс болон хадгаламжуудаас бүрдэнэ. Бусад банкуудын байршуулсан хөрөнгийн томоохон өсөлт нь дотоодын банкны байршуулсан 40,000,000 мянган төгрөгийн овернайт хадгаламжтай холбоотой.

Бусад банкнуудын байршуулсан хөрөнгийн ангилал бүрийн бодит үнэ цэнийн задаргааг тодруулга 42-оос харна уу. Тодруулга 38-д бусад банкуудын байршуулсан хөрөнгийн валют, хүүгийн түвшин болон дуусгавар болох хугацааны шинжилгээг харуулсан.

## **21 Харилцагчийн харилцах, хадгаламж**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2021 оны 12 сарын 31</b>
<b>Хувь хүн</b>	<b>3,048,396,232</b>	<b>3,226,617,157</b>
- Харилцах данс	584,816,587	411,897,832
- Хугацаагүй хадгаламж	417,143,204	536,054,590
- Хугацаатай хадгаламж	2,046,436,441	2,278,664,735
<b>Аж ахуйн нэгж</b>	<b>2,111,440,787</b>	<b>1,886,308,143</b>
- Харилцах данс	1,653,140,375	1,282,428,342
- Хугацаагүй хадгаламж	5,636,882	101,671,072
- Хугацаатай хадгаламж	452,663,530	502,208,729
<b>Төрийн болон хувьцаат компани</b>	<b>522,698,005</b>	<b>269,204,943</b>
- Харилцах данс	481,916,068	59,415,348
- Хугацаагүй хадгаламж	3,046,468	185,260,970
- Хугацаатай хадгаламж	37,735,469	24,528,625
<b>Бусад</b>	<b>60,762,843</b>	<b>81,413,147</b>
- Харилцах данс	38,191,925	49,176,296
- Хугацаагүй хадгаламж	9,416	492,516
- Хугацаатай хадгаламж	22,561,502	31,744,335
<b>Нийт харилцагчийн харилцах, хадгаламж</b>	<b>5,743,297,867</b>	<b>5,463,543,390</b>

Монгол Улсын Иргэний хуулийн дагуу, Банк нь харилцах, хадгаламж эзэмшигчдийн хадгалуулсан мөнгийг шаардсан үед нь эргүүлэн төлөх үүрэг хүлээсэн байдаг. Хэрэв хадгаламж эзэмшигч хугацаатай хадгаламжаа хугацаанаас нь өмнө буцаан татсан тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол Банк хүүг хугацаагүй хадгаламжийн хүүгээр тооцож олгоно.

Одоогийн байдлаар удирдлага харилцагчдын харилцах, хадгаламжийг эдийн засгийн салбарын төвлөрлөөр нь хянадаггүй. Иймээс үүнтэй холбоотой мэдээлэл санхүүгийн тайланд тусгагдаагүй. 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 30 том харилцагчдаас татсан хөрөнгийн нийт дүн 1,379,910,348 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 1,175,753,305 мянган төгрөг) бөгөөд нийт харилцах, хадгаламжийн 24% (2021 оны 12 сарын 31: 22%)-ийг бүрдүүлж байна.

2022 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар буцаах эрхгүй Банкны баталгаа, аккредитивийн барьцаа болгон 40,661,342 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 50,981,406 мянган төгрөг)-ийг харилцах хадгаламжийн дансанд байршуулсан.

Харилцагчийн харилцах, хадгаламжийн хүүгийн түвшний шинжилгээг Тодруулга 38-аас харна уу. Холбоотой талын үлдэгдлийн талаарх дэлгэрэнгүйг Тодруулга 44-өөс харна уу.

## 22 Бусад зээлийн эх үүсвэр

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
<b>(а) Төслийн зээлийн эх үүсвэр</b>		
Төслийн зээлийн эх үүсвэр /Төгрөг/	491,692,237	394,783,842
Төслийн зээлийн эх үүсвэр /Доллар/	222,145	229,457
<b>Нийт төслийн зээлийн эх үүсвэр</b>	<b>491,914,382</b>	<b>395,013,299</b>
<b>(б) Гадаадын банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр</b>		
Гадаадын банкнаас авсан эх үүсвэр /Доллар/	1,404,347,293	1,059,698,703
<b>(в) Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны санхүүжилт</b>		
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны санхүүжилт /Доллар/	4,489,570	48,586,576
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны санхүүжилт /Евро/	12,018,424	6,147,449
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны санхүүжилт /Юань/	3,542,423	-
<b>Нийт гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр</b>	<b>1,424,397,710</b>	<b>1,114,432,728</b>
<b>Нийт дүн</b>	<b>1,916,312,092</b>	<b>1,509,446,027</b>

### (а) Төслийн зээлийн эх үүсвэр

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
<b>Засгийн газрын үнэ тогтворжуулах хөтөлбөр</b>		
Орон сууцжуулах хөтөлбөр	330,298,612	228,790,214
Шатахууны нөөц бүрдүүлэх хөтөлбөр	86,094,425	71,278,311
Алт 2 хөтөлбөр	41,551,434	57,113,160
КФВ банкны төслийн эх үүсвэр	576,307	992,000
Бусад төслийн эх үүсвэр	-	937,500
<b>Монгол Улсын Хөгжлийн банкны төсөл</b>		
Улаан буудайн нөөц бүрдүүлэх хөтөлбөр	-	300,374
<b>Монгол Улсын Засгийн Газар болон ЖАЙКА-н хамтарсан төсөл</b>		
Жижиг, дунд бизнесийг дэмжих төслийн эх үүсвэр	5,779,061	6,020,716
<b>Азийн хөгжлийн банк болон зээлийн батлан даалтын сангийн төсөл</b>		
Жижиг, дунд бизнесийг дэмжих төслийн эх үүсвэр	2,522,545	904,084
<b>Засгийн газрын бусад төсөл</b>		
Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	24,864,743	28,430,319
Бусад төслийн эх үүсвэр	222,145	229,457
Оюутны хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	5,110	17,164
<b>Нийт төслийн зээлийн эх үүсвэр</b>	<b>491,914,382</b>	<b>395,013,299</b>

Тодруулга 3-т тусгасны дагуу эдгээр зээлийн эх үүсвэрийн дийлэнх нь Монгол Улсын Засгийн Газрын эсвэл зээл олгогчийн тодорхойлсон тусгай зориулалттай (хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг зорилтод харилцагчдад олгох) зээлүүд байдаг. Иймээс эдгээр эх үүсвэрийн хүүний хувь нь бага буюу Банкны өөр зээлдэгчдээс энгийн нөхцөлөөр эх үүсвэр татах хүүнээс доогуур байдаг.

## **22 Бусад зээлийн эх үүсвэр (үргэлжлэл)**

### **(а) Төслийн зээлийн эх үүсвэр (үргэлжлэл)**

Иймээс эдгээр эх үүсвэрийн хүүний хувь нь бага буюу Банкны өөр зээлдэгчдээс энгийн нөхцөлөөр эх үүсвэр татах хүүнээс доогуур байдаг. Эдгээр бусад зээлийн эх үүсвэрүүдийн ихэнх нь жилийн 2%-аас 12%-ийн хүүтэй, харин эдгээр эх үүсвэрээс олгож буй зээлүүдийн ихэнх нь жилийн 6%-аас 25.2%-ийн хүүтэй. Удирдлагын зүгээс эдгээр зээлсэн эх үүсвэрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олзгыг хүлээн зөвшөөрөх эсэхийг авч үзсэн ба тусгай зах зээлийн үндсэн шинжийг хангаж байгаа учраас эдгээр эх үүсвэр болох харилцагчид олгосон зээлээс ямар нэгэн анхны хүлээн зөвшөөрөлтийн олз гарз бүртгэгдэхгүй гэж үзсэн.

Удирдлагын гаргасан шийдвэрийг Тодруулга 3-аас харна уу. Томоохон төсөл хөтөлбөрүүдэд Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбарт (эдийн засгийг тэлэх) зориулсан Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтүүд багтана. Эдгээр хөтөлбөрүүдийг дор товчхон дурдвал:

Орон сууцны зээлийг санхүүжүүлэх Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд Банк 2014 оноос хойш жилийн 1%, 3%, 4%-ийн хүүтэй эх үүсвэрийг Монголбанкнаас хүлээн авсан. Энэ хөтөлбөрт тусгай шаардлага хангасан (80 квадрат метрээс бага хэмжээтэй байр, худалдан авах үнийн дүнгийн 30% тэнцэх урьдчилгаа, тухайн Банк болон бусад банкн дахь зээлийн түүх сайн гэх мэт) шинэ болон хуучин олгогдсон зээлүүдийг дахин санхүүжүүлэх боломжтой зээлүүд багтана.

Ийнхүү Банк нь зээлдүүлэгчийн шаардлагыг хангасан зээлдэгч нарт жилийн 5%, 6%, 8%-ийн хөнгөлөлттэй зээлийг олгох боломжтой болсон ба энэхүү хүүний түвшинг Монголбанкнаас тогтоож өгсөн тул олгож буй зээлийн хүүг Банк тодорхойлох эрхгүй. Зээлийн олголт болон 6%-ийн хүүтэй олгосон зээлийн дахин санхүүжилтийг Банкнаас хэлэлцэж батлах ба Банк зээлийн эрсдэлийг хариуцна.

2021 онд Монгол Улсын шатахууны нөөцийг бүрдүүлэх, шатахуун нийлүүлэгч компаниудыг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкнаас санхүүжүүлсэн шинэ хөтөлбөрт хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 12 сарын 28-ны өдөр дуусах хугацаатайгаар жилийн 6-9.5%-ийн хүүтэй санхүүжилт авсан бөгөөд компаниудад жилийн 9-12.5%-ийн хөнгөлөлттэй хүүтэй зээл олгосон. Банк бүх зээлийн олголтыг хэлэлцэж батлах ба зээлийн эрсдэлийг хариуцна.

2020 онд Монгол банкнаас санхүүжүүлж буй “Алт-2” хөтөлбөр нь алт олборлож буй компаниудыг санхүүжүүлэх, Монгол банкны валютын нөөцийг нэмэгдүүлэхэд зориулагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Банк жилийн 6-12%-ийн хүүтэй санхүүжилт авсан. Санхүүжилтын хугацаа 2025 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл байгаа бөгөөд уул уурхайн компаниудад жилийн 9-15%-ийн хүүтэй зээлийг олгосон.

2012 оноос хойш Банк нь аж ахуйн нэгжүүдэд жижиг дунд үйлдвэрлэлийн ажлын байрыг дэмжихэд зориулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих KFW хөтөлбөрт хамрагдсан. Банк нь Монголбанкнаас санхүүжилтийг жилийн 5%-ийн хүүтэй 2025 оны 6 сарын 25-ны өдөр дуусах нөхцөлтэй авсан. Энэхүү гэрээнд Банк зээлийн эрсдэлийг хариуцна.

2011 онд ЖАЙКА-аас жилийн 2%-ийн хүүтэй зээл авсан. Төслийн зорилго нь жижиг дунд бизнесийг болон байгаль орчныг хамгаалах төслийг дэмжих юм. Хөтөлбөрийн дагуу Банк 2032 оны 10 сарын 01-ны өдөр хүртэл жилийн 2%-ийн хүүтэй санхүүжилтийг авсан бөгөөд жижиг дунд бизнес эрхлэгчдэд жилийн 6%-ийн хүүтэй зээлийг олгосон.

2021 онд Банк Азийн хөгжлийн банкнаас жилийн 5%-ийн хүүтэй зээл авсан. Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй Зээлийн батлан даалтын сантай хамтарсан төсөл нь урт хугацаанд жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийг дэмжих зорилготой юм. Банк нь баталгааны хувиас хамаарч 8.88-12.34% -ийн хүүтэй зээл олгох боломжтой. Банк болон Зээлийн батлан даалтын сан нь хамтдаа зээл олголтыг шийдэх ба зээлийн эрсдэлийг тус тусдаа хүлээнэ.

2016 онд Банк Азийн хөгжлийн банкнаас жилийн 4.5%-ийн хүүтэй зээл авсан. 2016 онд Банк Азийн хөгжлийн банкнаас жилийн 4.5%-ийн хүүтэй зээл авсан. Төслийн зорилго нь хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийг дэмжихэд оршино. Хөтөлбөрийг 2029 он хүртэл сунгасан бөгөөд Банк 8%-ийн хүүтэй зээл олгох боломжтой. Банк нь зээлийн олголт, дахин санхүүжилтийг бүхэлд нь хэлэлцэж батлах ба зээлийн эрсдэлийг хариуцна.



## 22 Бусад төслийн эх үүсвэр (үргэлжлэл)

### (а) Төслийн зээлийн эх үүсвэр (үргэлжлэл)

Засгийн газрын байгууллагууд, МонголБанк болон олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээний нөхцөлийг дараах хүснэгтэнд харуулав:

Ангилал	Зээл олгогч	Төслийн нэр	Валют	Олгосон огноо	Дуусах огноо	2022 оны 12 сарын 31-нээрх зээлийн дүн /тухайн мянган валютаар/	2021 оны 12 сарын 31-нээрх зээлийн дүн /мянган төгрөгөөр/
Засгийн газрын үнэ тогтворжуулах	МонголБанк	Орон сууцжуулах хөтөлбөр	Төгрөг	6/14/2013	12/31/2024	330,298,612	330,298,612
	МонголБанк	Шатахууны нөөц бүрдүүлэх хөтөлбөр	Төгрөг	12/31/2021	12/28/2023	86,094,426	86,094,425
	МонголБанк	Алт 2 хөтөлбөр	Төгрөг	7/8/2020	12/31/2025	41,551,434	41,551,434
	МонголБанк	КФВ банкны төслийн эх үүсвэр	Төгрөг	5/16/2013	6/25/2025	576,307	576,307
ЗГ боон ЖАЙКА хамтарсан төсөл	ЖАЙКА	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	Төгрөг	6/12/2009	10/1/2032	5,779,061	5,779,061
АХБ болон ЗБДС хамтарсан төсөл	Азийн хөгжлийн Банк	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	Төгрөг	5/18/2021	12/31/2032	2,522,545	2,522,545
Засгийн Газрын бусад төсөл	Засгийн газар	Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	Төгрөг	12/28/2016	10/25/2029	24,864,743	24,864,743
	Засгийн газар	Бусад төслийн эх үүсвэр	Доллар	4/1/2020	5/1/2027	64	222,145
	Засгийн газар	Оюутны хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	Төгрөг	12/6/2016	12/5/2026	5,110	5,110

## **22 Бусад зээлийн эх үүсвэр (үргэлжлэл)**

### **(b) Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр**

Гадаадын бусад банкнаас авсан эх үүсвэрт гадаадын банк, санхүүгийн байгууллагаас 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 12-100 сар хүртэлх хугацаатай, 5,000-100,000 мянган ам.долларын зээл (2021: 5,000-100,000 мянган ам доллар, 12-97 сарын хугацаатай) авсан зээлүүд багтана.

Эдгээр зээлүүдийн 300,000 мянган ам.доллар нь Банкны тухайн банкин дахь харилцах дансаар баталгаажсан ба 25,000 мянган ам.долларын эх үүсвэр нь бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх засгийн газрын үнэт цаасаар баталгаажсан болно. Тодруулга 10-с харна уу.

2022 онд нэмж хэд хэдэн зээл авсан бөгөөд үүнд 10-48 сарын хугацаатай, 53,250 мянган ам.долларын зээлүүд багтана.

### **(c) Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын худалдааны санхүүжилт**

Банк нь өөрийн харилцагчдын худалдааны зээлийг санхүүжүүлэх зорилгоор гадаадын банк болон санхүүгийн байгууллагуудаас худалдааны зээлийн шугам авсан. 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 121,435,331 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 159,228,691 мянган төгрөг)-ийн зээлийн шугамыг ашиглаж, мөн тэр хэмжээний зээлийг харилцагчдад олгосон. Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд харилцагчдын гүйлгээг санхүүжүүлэх зорилгоор санхүүжилт олгодог. Ийм төрлийн эх үүсвэрийн хугацаа нь 2 хүртэлх жил байдаг бөгөөд харилцагчаас орж ирэх мөнгөн урсгалын хугацаа болон гадаадын банк, санхүүгийн байгууллагад эргэн төлөх мөнгөн урсгалын хугацаа нь ижил байдаг. Харилцагч зээлээ төлж чадахгүй тохиолдолд Банк зээлийн эрсдэлийг хариуцна.

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банк нь гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн зөрчилгүй болно..

Бусад зээлийн эх үүсвэрийн бодит үнэ цэнийг Тодруулга 42-оос харна уу. Мөн валют, хүүгийн түвшин болон дуусгавар болох хугацааны шинжилгээг Тодруулга 38-аас харна уу. Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийн мэдээллийг Тодруулга 40-өөс харна уу.

## **23 РЕПО хэлцэл**

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар дотоодын банк, санхүүгийн байгууллагаас авсан репо хэлцэлд 169,906,728 мянган төгрөг (2021: 221,912,121 мянган төгрөг), жилийн 6-7%-ийн хүүтэй (2021: жилийн 6-6.5% хувийн хүүтэй), 730 болон 1095 хоног (2021: 723-730 хоног) анхны дуусгавар болох хугацаатай репо хэлцлүүд орно. Эдгээр репо хэлцлүүд нь Монголбанкны үнэт цаасаар бүрэн баталгаажсан. Дэлгэрэнгүйг Тодруулга 10-аас харна уу. Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дагуу, Банк нь Засгийн газрын хөтөлбөрт хамрагдан уул уурхайн бус экспортлогчид, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд 10.5%-ийн хүүтэй зээл олгосон ба энэ нь төв банкны репо хэлцлээр санхүүжилт хийгдсэн.

2022 онд банк ам.долларын нөөцөө нэмэгдүүлэх зорилгоор 41,440,916 мянган төгрөгийн репо хэлцэл хийсэн ба эдгээр хэлцлүүд нь тодруулга 10-д тусгасны дагуу бодит үнэ цэнэ нь бсэд дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх компанийн бондоор бүрэн баталгаажсан.

## 24 Бусад өр төлбөр

Бусад өр төлбөрийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
<b>Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад санхүүгийн өр төлбөр:</b>	<b>115,112,290</b>	<b>61,772,998</b>
Гүйлгээний өр төлбөр	100,236,168	43,600,802
Буцаах нөхцөлтэй МИК-д худалдсан зээлтэй холбоотой өр төлбөр	739,444	1,010,996
Дансны өглөг	124,846	284,818
Аккредитив, баталгааны эрсдэлийн сан	1,447,410	938,074
Бусад	12,564,422	15,938,308
<b>Бусад санхүүгийн бус өр төлбөр:</b>	<b>16,193,945</b>	<b>9,061,448</b>
Орлогын албан татвараас бусад татварын өглөг	5,028,759	2,881,161
Ажилтнуудад өгөх өглөг	7,135,889	3,850,364
Бусад	4,029,297	2,329,923
<b>Нийт бусад өр төлбөр</b>	<b>131,306,235</b>	<b>70,834,446</b>

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар гүйлгээний өр төлбөр өссөн нь хилийн хориг суларч, олон улсын гүйлгээ нэмэгдсэнтэй мөн 2021 онтой харьцуулахад оны сүүлийн өдөр амралтын өдөр байсантай холбоотой. Ажилтнуудад өгөх өглөг өссөн нь цалин нэмэгдсэнтэй холбоотой.

Бусад санхүүгийн өр төлбөрийг оны эцсээс хойш арван хоёр сарын дотор барагдуулахаар төлөвлөж байна. Бүх санхүүгийн бус өр төлбөр нь богино хугацааны шинж чанартай байдаг.

## 25 Хувьцаат Капитал

Хувьцааны тоо ширхэгээс бусад дүн нь мянган төгрөгөөр	Нийт гаргасан хувьцаа	Энгийн хувьцаа	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Давуу эрхтэй хувьцаа	Халаасны хувьцаа/давуу эрхтэй хувьцаа	Нийт дүн
<b>2021 оны 1 сарын 1</b>	<b>42,159,537</b>	<b>42,240,037</b>	<b>(80,500)</b>	<b>291,843,805</b>	<b>25,778,900</b>	<b>(9,390,800)</b>	<b>350,391,442</b>
Хувьцааны нэрлэсэн үнийг нэмж төлсөн капиталаас нэмэгдүүлэх	-	126,720,111	(241,500)	(126,478,611)	-	-	-
Хувьцааг хуваах	632,393,055	-	-	-	-	-	-
Бусад	-	-	-	4,120,850	-	-	4,120,850
<b>2021 оны 12 сарын 31</b>	<b>674,552,592</b>	<b>168,960,148</b>	<b>(322,000)</b>	<b>169,486,044</b>	<b>25,778,900</b>	<b>(9,390,800)</b>	<b>354,512,292</b>
<b>2022 оны 1 сарын 1</b>	<b>674,552,592</b>	<b>168,960,148</b>	<b>(322,000)</b>	<b>169,486,044</b>	<b>25,778,900</b>	<b>(9,390,800)</b>	<b>354,512,292</b>
Шинээр гаргасан хувьцаа	134,104,714	33,526,179	-	131,788,974	-	-	165,315,153
Хувьцаа халааслах	-	-	-	-	-	(16,388,100)	(16,388,100)
Эргэлтээс гаргасан хувьцаа	-	(322,000)	322,000	206,102	(25,778,900)	25,778,900	206,102
<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>808,657,306</b>	<b>202,164,327</b>	<b>-</b>	<b>301,481,120</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>503,645,447</b>

Банкны гаргасан хувьцаат капиталын нэрлэсэн үнээр бүртгэсэн дүн нь 202,164,327 мянган төгрөг (2021: MNT 168,638,148 мянган төгрөг). Нэмэгдэж төлөгдсөн капитал нь шинээр гаргасан хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн төлбөр юм. 2022 онд 250 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 134,104,714 ширхэг энгийн хувьцаа гаргасан.

## 25 Хувьцаат капитал (Үргэлжлэл)

### Энгийн хувьцаа:

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэг бүр нь 250 төгрөгийн нэрлэсэн үнэтэй (2021: нэг бүр нь 250 төгрөгийн нэрлэсэн үнэтэй), нийт 808,657,306 ширхэг (2021 оны 12 сарын 31: 674,552,592 ширхэг) энгийн хувьцаанаас бүрдэнэ.

Банкны энгийн хувьцаа бүр нэг саналын эрхтэй ба энгийн хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ.

ТУЗ-ын шийдвэрээр 322,000 мянган төгрөгийн 1,288,000 ширхэг энгийн хувьцааг эргэлтээс гаргасан. Дараах хүснэгтэд 2022 онд шинээр гаргасан хувьцааг харуулав.

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нэрлэсэн үнэ	Нэгж хувьцааны захиалгын үнэ	Огноо
Бодь Интэрнэшнл ХХК	27,661,497	250	1,084.54	4/11/2022
Голомт Файнэншил Групп ХХК	13,980,063	250	1,180.25	6/29/2022
Олон нийт	92,463,154	250	1,285.00	12/8/2022

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу системийн нөлөө бүхий банкууд 2023 оны 6 дугаар сарын 30-ны дотор нээлттэй хувьцаат компани болох ёстой бөгөөд банк өөрийн хувьцааны 10.09 хувьтай тэнцэх 80,402,743 ширхэг хувьцааг 103,317,525 мянган төгрөгөөр олон нийтэд санал болгосон.

Анхдагч зах зээлийн арилжааны үед олон нийтээс ирсэн захиалгын эрэлт их байсан тул Банкны нийт хувьцааны 11.43 хувийг буюу 92,463,154 ширхэг хувьцааг 21,248 хувьцаа эзэмшигчдэд санал болгон анхдагч зах зээлийн арилжааны дүнг 118,815,153 мянган төгрөгийг татан төвлөрүүллээ.

2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх хувьцаа эзэмшигчдийн хувийг дор харуулав:

Хувьцаа эзэмшигч	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
	Хувиар (%)	Хувиар (%)
Голомт Файнэншил Групп ХХК	77.20%	90.47%
Свисс Мо Инвестмент Эй Жи	5.21%	6.25%
Бодь Интернэшнл ХХК	3.42%	-
Голомт Инвестмент Лимитед	2.57%	3.08%
Ажилчдын хувьцаа	-	0.20%
Олон нийт	11.60%	-
<b>Нийт</b>	<b>100%</b>	<b>100%</b>

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн бусад хэсэгт өөрийн хөрөнгөтэй шууд холбоотой гүйлгээний зардлыг тусгасан болно.

### Давуу эрхтэй хувьцаа

2013 оны 12 сарын 19-ний өдөр гаргасан 15,000,000 ам.доллар буюу 25,778,900 мянган төгрөгтэй тэнцэх 25,778,900 ширхэг давуу эрхтэй хувьцааг Ноён Зоригт (Ноён Баясгалангийн бизнес хамтрагч) эзэмшдэг байсан ба 2013 оны 12 сарын 26-ны өдөр давуу эрхтэй хувьцааны гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон. ТУЗ-ийн шийдвэрийн дагуу давуу эрхтэй хувьцаа эзэмшигчид оруулсан хөрөнгө оруулалтаас 6%-ийн ногдол ашгийн орлого авах эрхтэй байсан ба банк татан буугдсан тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигчдээс давуу эрх эдэлнэ.

2022 онд хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр 16,388,100 ширхэг давуу эрхийн хувьцааг нэгж бүрийг 1,870.85 төгрөгөөр буцаан худалдан авсан ба ТУЗ-өөс нийт 25,778,900 ширхэг, 25,778,900 мянган төгрөгийн дүнтэй давуу эрхтэй халаасны хувьцааг эргэлтээс гаргасан.

## 26 Хүүгийн орлого ба зардал

Мянган төгрөгөөр	2022	2021
<b>Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого</b>		
Хорогдуулсан өртгөөр тооцсон харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	443,987,232	405,726,646
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас	88,493,920	90,177,800
Хорогдуулсан өртгөөр тооцсон бусад банкуудад байршуулсан хөрөнгө	22,922,861	21,178,571
Монголбанкинд байршуулсан бэлэн мөнгө	20,131,192	8,343,480
Хорогдуулсан өртгөөр тооцсон өрийн үнэт цаас	608,832	629,364
Хорогдуулсан өртгөөр тооцсон урвуу репо хэлцэл	240,894	430,319
<b>Нийт үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого</b>	<b>576,384,931</b>	<b>526,486,180</b>
<b>Бусад ижил төстэй орлого</b>		
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16,829,606	15,333,163
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх өрийн үнэт цаас	16,694,628	12,958,259
<b>Нийт бусад ижил төстэй орлого</b>	<b>33,524,234</b>	<b>28,291,422</b>
<b>Нийт хүүгийн орлого</b>	<b>609,909,165</b>	<b>554,777,602</b>
<b>Хүүгийн зардал</b>		
Харилцагчдын харилцах, хадгаламж	(149,218,403)	(219,370,453)
Зээлийн бусад эх үүсвэр	(57,326,437)	(43,690,195)
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	(2,259,750)	(1,165,596)
Репо хэлцэл	(14,052,572)	(7,031,713)
<b>Нийт хүүгийн зардал</b>	<b>(222,857,162)</b>	<b>(271,257,957)</b>
<b>Бусад ижил төстэй зардал</b>		
Түрээсийн зардал	(1,481,221)	(1,560,592)
<b>Нийт ижил төстэй зардал</b>	<b>(1,481,221)</b>	<b>(1,560,592)</b>
<b>Нийт хүүгийн болон ижил төстэй зардал</b>	<b>(224,338,383)</b>	<b>(272,818,549)</b>
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>385,570,783</b>	<b>281,959,053</b>

Бэлэн мөнгө болон Төв банкинд байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого болох 9,368,891 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 4,347,316 мянган төгрөг) нь Монголбанкны журмын дагуу бүх банкуудад олгосон Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөцийг 2022 онд хангаж байсантай холбоотой урамшуулал юм.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүүгийн орлогын өсөлт нь бодлогын хүү болон зээлийн олголт нэмэгдсэнтэй холбоотой. Ковидын тухай хуулийн дагуу хугацаагүй хадгаламжийн хүүг зогсоосонтой холбоотой 2022 онд харилцагчдын харилцах, хадгаламжийн хүүгийн зардал буурсан.

Харилцагчдад олгосон үнэ цэнэ буурсан зээлээс хүлээн зөвшөөрсөн хүүгийн орлого 31,811,210 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 34,714,061 мянган төгрөг) байсан.

Удирдлагын зүгээс эдгээр зээлүүд нь бүрэн төлөгдөх ба үнэ цэнэ буурсан зээлүүд нь өндөр үнийн дүн бүхий барьцаа хөрөнгөтэй гэж үзсэн. Мөн СТОУС-ын дагуу буцааж төлөгдөхгүй гэж үзсэн зээлийн хүүний орлогыг 2022 болон 2021 оны ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөөгүй.

## 27 Хураамж, шимтгэлийн орлого ба зардал

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022</b>	<b>2021</b>
<b>Хураамж, шимтгэлийн орлого</b>		
Карттай холбоотой шимтгэл, хураамж	48,568,076	34,959,219
Гуйвуулгын ба бусад үйлчилгээний хураамж	24,130,506	16,350,075
Баталгаа болон бусад баримтны үнэ, шимтгэл, хураамж	6,174,736	7,226,156
Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж	4,952,097	3,558,151
Брокерийн болон бусад үйлчилгээний хураамж	306,563	399,541
<b>Нийт хураамж, шимтгэлийн орлого</b>	<b>84,131,978</b>	<b>62,493,142</b>
<b>Хураамж, шимтгэлийн зардал</b>		
Картын гүйлгээний зардал	(33,549,252)	(16,882,816)
Банкны үйлчилгээний зардал	(4,904,527)	(3,455,651)
Онлайн гүйлгээний зардал	(1,388,439)	(1,024,110)
Брокерийн болон бусад үйлчилгээний зардал	(118,966)	(351,651)
<b>Нийт хураамж, шимтгэлийн зардал</b>	<b>(39,961,185)</b>	<b>(21,714,228)</b>
<b>Хураамж, шимтгэлийн цэвэр орлого</b>	<b>44,170,793</b>	<b>40,778,914</b>

## 28 Бусад үйл ажиллагааны орлого

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022</b>	<b>2021</b>
Сангаас хаасан зээлийн эргэн төлөлт	-	2,387,514
Бусад	1,154,973	1,447,486
<b>Нийт бусад үйл ажиллагааны орлого</b>	<b>1,154,973</b>	<b>3,835,000</b>

2022 оны 12 сарын 31-ний байдлаар сангаас хаасан зээлийн эргэн төлөлтийг зээлжих эрсдэлийн сан руу ангилсан.

## 29 Удирдлага ба үйл ажиллагааны бусад зардал

Мянган төгрөгөөр	Тодр уулга	2022	2021
Ажилчдын зардал		64,373,012	51,099,483
Мэдээлэл, зөвлөх үйлчилгээ болон бусад мэргэжлийн үйлчилгээний зардал		38,996,968	30,546,073
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	16	21,411,473	19,270,582
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал	17	5,666,006	5,284,863
Программ хангамж болон биет бус хөрөнгийн хорогдуулалт	15	6,063,280	3,837,579
Зар сурталчилгаа, маркетингийн үйлчилгээ		6,072,956	3,491,855
Бичиг хэргийн зардал		3,495,573	2,927,494
Харуул хамгаалалтын зардал		2,326,850	2,711,355
Орлогын албан татвараас бусад татварын зардал		2,100,901	2,266,791
Зээлийн төлбөр цуглуулалтын зардал		2,010,466	2,084,904
Харилцаа, холбооны зардал		2,181,413	1,828,331
Богино хугацаат түрээсийн зардал		1,923,903	1,397,273
Оффис цэвэрлэгээний зардал		1,502,596	1,166,351
Ашиглалтын зардал		1,447,049	1,070,331
Сайн дурын болон зайлшгүй даатгалын зардал		1,055,333	1,052,974
Тээврийн зардал		1,904,931	1,263,585
Үзвэр, үйлчилгээний зардал		1,274,122	572,851
Томилолтын зардал		735,637	77,958
Хандив		386,830	31,000
Бусад зардал		10,416,611	5,157,964
<b>Нийт удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал</b>		<b>175,345,911</b>	<b>137,139,597</b>

Мянган төгрөгөөр	2022	2021
<b>Ажилчдын зардал дараахаас бүрдэнэ:</b>		
Цалин хөлс, урамшуулал	55,360,029	44,660,813
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	6,780,120	5,212,296
Хувьцаанд суурилсан төлбөр	847,461	-
Ажилчдын тэтгэмж	658,404	633,897
Тэтгэврийн сан	260,466	282,431
Ажилчдын сургалт	466,532	310,046
<b>Ажилчдын тэтгэмж</b>	<b>64,373,012</b>	<b>51,099,483</b>

Ажилчдын зардлын томоохон өсөлт нь цалин нэмэгдсэнтэй холбоотой. 2022 онд банк ажилтнууддаа өөрийн хувьцааны опционыг эзэмшүүлэхээр санал болгосон.

## 30 Бусад олз/(гарз), цэвэр дүнгээр

Мянган төгрөгөөр	2022	2021
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны олз/(гарз)	(1,608,563)	830,859
Үндсэн хөрөнгө худалдан борлуулсны олз	197,376	82,161
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны гарз	(69,680)	(2,780,939)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө худалдан борлуулсны олз/(гарз)	(188,375)	414,498
<b>Нийт бусад олз/(гарз), цэвэр дүнгээр</b>	<b>(1,669,242)</b>	<b>(1,453,421)</b>

2022 онд Банк нийт 45,818,630 мянган төгрөгийн оффис, худалдаа үйлчилгээний зориулалттай талбай болон орон сууцны борлуулалт хийсэн.

### 31 Орлогын албан татвар

**(a) Орлогын албан татварын зардлын бүрэлдэхүүн / (орлого)**

Тайлант жилийн ашиг, алдагдалд бүртгэсэн орлогын албан татварын зардлыг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2022	2021
Тайлант жилийн орлогын албан татвар	53,291,941	30,465,021
Хойшлогдсон орлогын татвар	24,003,995	(3,830,793)
<b>Тайлант жилийн орлогын албан татварын зардал</b>	<b>77,295,936</b>	<b>26,634,228</b>

**(b) Татварын зардал ба ашиг, алдагдал хоорондын холбогдох татварын хэмжээгээр тооцсон тохируулга**

Банк санхүүгийн тайлагналын зорилгоор орлогод суурилан албан татварыг тооцоолдог бөгөөд орлогын албан татварын зорилгоор татвар ногдохгүй орлого болон татвараас хасагдахгүй зардлын хувьд тохируулга хийх замаар орлогын албан татварын зардлыг тодорхойлдог. Банк нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 6 тэрбум төгрөг (2021: 6 тэрбум төгрөг) хүртэлх татвар ногдох орлогоос 10 хувийн, 6 тэрбум төгрөг (2021: 6 тэрбум төгрөг)-өөс давсан дүнгээс 25 хувь (2021: 25 хувь)-ийн орлогын албан татвар төлдөг.

Мянган төгрөгөөр	2022	2021
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>193,797,984</b>	<b>52,570,894</b>
Хуулиар заасан хувиар тооцсон татварын зардал (2022: 25%; 2021: 25%)	48,449,496	13,142,724
Татварын зорилгоор татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардлын татварын нөлөө:		
- Бага хувиар татвар ногдуулах орлогын нөлөө	(900,000)	(900,000)
- Татвараас чөлөөлөгдөх орлого	(2,393,903)	(2,250,395)
- Олон төрлийн хувь хэмжээгээр татвар ногдуулсны орлого	(500,513)	(351,064)
- Хасагдахгүй зардал	1,469,614	1,524,472
Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгө	31,171,242	15,468,491
<b>Тайлант жилийн орлогын албан татварын зардал</b>	<b>77,295,936</b>	<b>26,634,228</b>

Хүлээн зөвшөөрөгдөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийн дэлгэрэнгүйг Тодруулга 3.3.19-ээс үзнэ үү.

**(c) Түр зөрүүгийн нөлөөгөөр тодорхойлогдсон хойшлогдсон татвар**

СТОУС болон Монгол Улсын татварын хууль тогтоомжийн хоорондын ялгаатай байдал нь санхүүгийн тайлагналын зорилгоорх хөрөнгө, өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурь дүнгийн хооронд гарах түр зөрүүг үүсгэдэг.



### 31 Орлогын албан татвар (үргэлжлэл)

2022 онд 25%-аар татвар ногдуулдаг түр зөрүүний өөрчлөлтөөс үүдэлтэй татварын нөлөөний дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2022 оны 1 сарын 1	Ашиг, алдагдалд бүртгэсэн	Бусад дэлгэрэнгүй орлогод шууд бүртгэсэн	2022 оны 12 сарын 31
<b>Татвараас хасагдах/(татвар ногдох) түр зөрүүгийн татварын нөлөө болон ирээдүйд шилжүүлэх татварын алдагдал:</b>				
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний олз/(гарз) болон борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан	19,317,001	21,872,014	-	41,189,015
Барилга байгууламжийн үнэ цэнийн бууралт	9,658,852	(534,902)	-	9,123,950
Зээл ба урьдчилгаатай холбоотой анхны болон тохируулгын алдагдал	5,434,701	(3,732,235)	-	1,702,466
Урьдчилж төлсөн орлого – зээл олголтын шимтгэл	3,729,800	682,650	-	4,412,450
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	3,691,282	1,085,453	-	4,776,735
Ирээдүйд шилжүүлэх татварын алдагдал	952,354	(952,354)	-	-
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	212,093	(1,021,910)	12,745,304	11,935,487
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн зээлжих эрсдэлийн сан	57,798	896,102	-	953,900
Хорогдуулсан өртөг болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх үнэт цаасны зээлжих эрсдэлийн сан	46,833	1,237,709	-	1,284,542
<b>Хойшлогдсон татварын хөрөнгө</b>	<b>43,100,714</b>	<b>19,532,527</b>	<b>12,745,304</b>	<b>75,378,545</b>
Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгө	-	(31,171,242)	-	(31,171,242)
<b>Нийт хойшлогдсон татварын хөрөнгө</b>	<b>43,100,714</b>	<b>(11,638,715)</b>	<b>12,745,304</b>	<b>44,207,303</b>
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(38,857,755)	(11,886,449)	-	(50,744,204)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа - 90 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй зээлийн хүүгийн орлого	(11,852,602)	2,482,041	-	(9,370,561)
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	(685,726)	(2,781,993)	-	(3,467,719)
Бусад	(1,189,228)	(178,879)	-	(1,368,107)
<b>Нийт хойшлогдсон татварын өр төлбөр</b>	<b>(52,585,311)</b>	<b>(12,365,280)</b>	<b>-</b>	<b>(64,950,591)</b>
<b>Нийт хойшлогдсон татварын цэвэр хөрөнгө/(өр төлбөр)</b>	<b>(9,484,597)</b>	<b>(24,003,995)</b>	<b>12,745,304</b>	<b>(20,743,288)</b>

### 31 Орлогын албан татвар (үргэлжлэл)

2021 онд 25%-аар татвар ногдуулдаг түр зөрүүний өөрчлөлтөөс үүдэлтэй татварын нөлөөний дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2021 оны 1 сарын 1	Ашиг, алдагдалд бүртгэсэн	Бусад дэлгэрэнгүй орлогод шууд бүртгэсэн	2021 оны 12 сарын 31
<b>Татвараас хасагдах/(татвар ногдох) түр зөрүүгийн татварын нөлөө болон ирээдүйд шилжүүлэх татварын алдагдал:</b>				
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний олз/(гарз) болон борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан	<b>13,570,208</b>	5,746,793	-	<b>19,317,001</b>
Барилга байгууламжийн үнэ цэнийн бууралт	<b>10,193,753</b>	(534,902)	-	<b>9,658,851</b>
Зээл ба урьдчилгаатай холбоотой анхны болон тохируулгын алдагдал	<b>4,775,169</b>	659,533	-	<b>5,434,702</b>
Урьдчилж төлсөн орлого – зээл олголтын шимтгэл	<b>2,306,092</b>	1,423,708	-	<b>3,729,800</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	<b>3,724,018</b>	(32,736)	-	<b>3,691,282</b>
Ирээдүйд шилжүүлэх татварын алдагдал	<b>952,354</b>	-	-	<b>952,354</b>
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	<b>4,287,403</b>	(3,116,527)	(958,783)	<b>212,093</b>
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн зээлжих эрсдэлийн сан	<b>61,195</b>	(3,398)	-	<b>57,797</b>
Хорогдуулсан өртөг болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх үнэт цаасны зээлжих эрсдэлийн сан	<b>692,091</b>	(645,258)	-	<b>46,833</b>
<b>Нийт хойшлогдсон татварын хөрөнгө</b>	<b>40,562,283</b>	<b>3,497,213</b>	<b>(958,783)</b>	<b>43,100,713</b>
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	<b>(38,793,904)</b>	(66,624)	-	<b>(38,860,528)</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа - 90 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй зээлийн хүүгийн орлого	<b>(11,822,362)</b>	(30,240)	-	<b>(11,852,602)</b>
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	<b>(1,340,863)</b>	655,136	-	<b>(685,727)</b>
Бусад	<b>(961,761)</b>	(224,692)	-	<b>(1,186,453)</b>
<b>Нийт хойшлогдсон татварын өр төлбөр</b>	<b>(52,918,890)</b>	<b>333,580</b>	-	<b>(52,585,310)</b>
<b>Нийт хойшлогдсон татварын цэвэр хөрөнгө/(өр төлбөр)</b>	<b>(12,356,607)</b>	<b>3,830,793</b>	<b>(958,783)</b>	<b>(9,484,597)</b>

### 32 Өмчийн бүрэлдэхүүн хэсэг бүрд хүлээн зөвшөөрөгдсөн бусад дэлгэрэнгүй орлого

Өмчийн бүрэлдэхүүн хэсэг дэх бусад дэлгэрэнгүй орлогын задаргааг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2022	2021
<b>Бусад дэлгэрэнгүй орлого(алдагдал):</b>		
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд ангилагдах зүйлс:</i>		
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт		
- Тайлант жилийн гарз	(50,471,551)	2,680,637
- Худалдан борлуулснаас ашиг, алдагдалд дахин ангилагдсан олз/(гарз)	48,339	626
Дэлгэрэнгүй орлогын тайланд шууд бүртгэсэн орлогын татвар	12,605,803	(670,316)
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд ангилагдахгүй зүйлс:</i>		
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн олз	(558,251)	1,153,870
Дэлгэрэнгүй орлогын тайланд шууд бүртгэсэн орлогын татвар	139,563	(288,468)
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>(38,236,097)</b>	<b>2,876,349</b>

### 33 Ногдол ашиг

Мянган төгрөгөөр	2022		2021	
	Энгийн хувьцаа	Давуу эрхтэй хувьцаа	Энгийн хувьцаа	Давуу эрхтэй хувьцаа
<b>1 сарын 1-нээрх ногдол ашгийн өглөг</b>				
Тайлант хугацаанд зарласан ногдол ашиг	-	555,404	-	1,709,458
Тайлант хугацаанд төлсөн ногдол ашиг	-	(555,404)	-	(1,709,458)
<b>12 сарын 31-нээрх ногдол ашгийн өглөг</b>	-	-	-	-
<b>Нэгж хувьцааны ногдол ашиг</b>		<b>5.9%</b>		<b>10.4%</b>

### 34 Нэгж хувьцаанд ногдох ашиг

Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашгийг тухайн жилийн хугацаанд гаргасан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хувааж тооцсон (халаасны хувьцаа ороогүй). Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашгийг одоо ажиллаж байгаа ажилчдад олгосон хувьцааны опционоор цэвэршүүлж тооцсон. Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон хорогдуулсан ашгийг харуулав:

Мянган төгрөгөөр /Нэгж хувьцаанд ногдох ашгаас бусад /	2022	2021
<b>Банкны хувьцаа эзэмшигчдийн тайлант хугацааны ашиг(алдагдал)</b>	<b>116,502,048</b>	<b>25,936,666</b>
Хасах: Давуу эрхтэй хувьцааны ногдол ашиг	(555,404)	(1,709,458)
Хасах: Хувьцааны нөхцөлд үндэслэн давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдэд хамаарах тухайн жилийн хуваарилагдаагүй ашиг, алдагдал	-	-
Хасах: Хугацаагүй хоёрдогч өглөгийн хүүгийн төлбөр	-	-
<b>Банкны энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах жилийн ашиг</b>	<b>115,946,644</b>	<b>24,227,208</b>
Гаргасан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо (мянга)	707,839	674,553
Хорогдуулалтын нөлөө:		
Хувьцааны опцион	331	-
<b>Хорогдуулалтын нөлөөнд тохируулсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо (мянган)</b>	<b>708,170</b>	<b>674,553</b>
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	163.80	35.92
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	163.73	35.92

Тодруулга 25-аас энгийн хувьцааны тооны өсөлтийн талаарх мэдээллийг харна уу.

### 35 Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулга

Банкны өр төлбөр болон түүний өөрчлөлтийн хөдөлгөөнийг тайлант хугацааны задаргаагаар үзүүлэв. Мөнгөн гүйлгээний тайланд өрийн зүйлсийг санхүүжилт хэмээн тусгасан:

Мянган төгрөгөөр	Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөр			
	Зээлийн эх үүсвэр	Репо хэлцэл	Түрээсийн өр төлбөр	Нийт дүн
<b>2022 оны 1 сарын 1-нээрх санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөр</b>	<b>1,509,446,027</b>	<b>221,912,121</b>	<b>14,001,667</b>	<b>1,745,359,816</b>
<i>Мөнгөн гүйлгээ</i>				
Орох мөнгөн урсгал	1,201,130,206	424,211,523	-	<b>1,625,341,729</b>
Гарах мөнгөн урсгал	(970,908,033)	(447,033,190)	(5,758,791)	<b>(1,423,700,014)</b>
Төлөгдсөн хүү	(46,270,532)	(5,822,717)	(1,481,221)	<b>(53,574,470)</b>
<i>Мөнгөн бус гүйлгээ</i>				
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх өрийн үнэт цаасны зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт	(63,234,300)	-	-	<b>(63,234,300)</b>
Шинэ түрээс	-	-	7,628,839	<b>7,628,839</b>
Хуримтлагдсан хүү	52,041,071	14,052,572	1,481,221	<b>67,574,864</b>
Гэрээний өөрчлөлтөөс үүссэн залруулга	58,404	-	418,771	<b>477,175</b>
Гадаад валютын ханшийн тохируулга	234,049,250	4,027,335	-	<b>238,076,585</b>
<b>2022 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөр</b>	<b>1,916,312,092</b>	<b>211,347,644</b>	<b>16,290,486</b>	<b>2,143,950,222</b>
Мянган төгрөгөөр	Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөр			
	Зээлийн эх үүсвэр	Репо хэлцэл	Түрээсийн өр төлбөр	Нийт дүн
<b>2021 оны 1 сарын 1-нээрх санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөр</b>	<b>1,202,264,649</b>	<b>20,088,596</b>	<b>10,611,448</b>	<b>1,232,964,693</b>
<i>Мөнгөн гүйлгээ</i>				
Орох мөнгөн урсгал	1,205,497,008	562,558,030	-	<b>1,768,055,038</b>
Гарах мөнгөн урсгал	(854,325,119)	(367,560,485)	(5,205,254)	<b>(1,227,090,858)</b>
Төлөгдсөн хүү	(56,683,035)	(205,732)	(1,560,592)	<b>(58,449,359)</b>
<i>Мөнгөн бус гүйлгээ</i>				
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх өрийн үнэт цаасны зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт	(25,926,400)	-	-	<b>(25,926,400)</b>
Шинэ түрээс	-	-	8,595,473	<b>8,595,473</b>
Хуримтлагдсан хүү	40,116,421	7,031,712	1,560,592	<b>48,708,726</b>
Гэрээний өөрчлөлтөөс үүссэн залруулга	(64,756)	-	-	<b>(64,756)</b>
Гадаад валютын ханшийн тохируулга	(1,432,742)	-	-	<b>(1,432,742)</b>
<b>2021 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөр</b>	<b>1,509,446,027</b>	<b>221,912,121</b>	<b>14,001,667</b>	<b>1,745,359,815</b>

### **36 Сегментийн шинжилгээ**

Үйл ажиллагааны сегментүүд нь бизнесийн үйл ажиллагааны явцад орлого олж, зардал гаргадаг бүрэлдэхүүн хэсгээс бүрдэх бөгөөд үйл ажиллагааны үр дүнг үйл ажиллагааны ахлах шийдвэр гаргагч (CODM) тогтмол хянадаг, санхүүгийн мэдээллийг сегмент бүрээр бэлтгэх боломжтой байдаг. CODM нь нөөцийг хуваарилж, аж ахуйн нэгжийн гүйцэтгэлийг үнэлдэг хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүс юм. CODM -ийн чиг үүргийг Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл хэрэгжүүлдэг.

**(а) Тайлагнах сегмент бүрээс орлого олж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний тодорхойлолт**

Банк нь дараах үндсэн дөрвөн сегмент дээр үйл ажиллагаагаа явуулдаг::

**Иргэд** – хувь хүмүүст зориулсан харилцах данс, хадгаламж зэрэг банкны үйлчилгээг багтаасан. Иргэдийн зээлийн дийлэнх нь хэрэглээний зээл болон ипотекийн зээл байна. Ипотекийн зээл – орон сууцны зээлийн санхүүжилтийг хамарна;

**ЖДБ** – жижиг болон дунд бизнесийн аж ахуй нэгжүүдэд зориулсан харилцах данс, хадгаламж, овердрафт, зээл, бусад зээлийн хэрэгсэл, гадаад валютын болон бусад бүтээгдэхүүнийг багтаана;

**Байгууллага** – дотоод болон гадаад валютаарх харилцах, хадгаламж, овердрафт, зээл болон бусад зээлийн хэрэгсэл зэрэг банкны үйлчилгээ орно;

**Бусад** – банкны хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа багтсан – Зээлээр болон богино хугацаат байршуулалт, компани, засгийн газрын өрийн үнэт цаас зэрэг түргэн хөрвөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийсэн санхүүжилт болон төвлөрсөн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа юм. Тайлагнах сегментэд хуваарилагдаагүй орлого, зардлыг тодорхой нэг сегментэд бус харин Банкны ерөнхий гүйцэтгэлийг бүрдүүлдэг гэж үздэг тул бусад сегментэд толилуулдаг.

**(b) Удирдлагын тайлагнах сегментийг тодорхойлох хүчин зүйлүүд**

Банкны сегментүүд нь өөр өөр үйлчлүүлэгчдэд чиглэсэн стратегит бизнесийн нэгжүүд юм. Бизнесийн нэгж бүр маркетингийн өөр стратеги, үйлчилгээний түвшинг шаарддаг тул тэдгээрийг тусад нь удирддаг.

**(c) Үйл ажиллагааны сегментийн ашиг, алдагдал, хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт**

CODM нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн мэдээллийг хянадаг. CODM нь татвар өмнөх ашигт үндэслэн сегмент бүрийн гүйцэтгэлийг үнэлдэг.

**36 Сегментийн шинжилгээ (үргэлжлэл)**

2022 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн тайлагнах сегментийн мэдээллийг дор үзүүлэв:

<b>2022 оны 12 сарын 31</b>					
<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Байгууллага</b>	<b>ЖДҮ</b>	<b>Иргэд</b>	<b>Бусад</b>	<b>Нийт дүн</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	1,085,673,848	930,075,462	1,681,884,035	-	<b>3,697,633,345</b>
Харилцагчийн харилцах, хадгаламж	1,581,658,356	1,146,662,149	3,014,977,362	-	<b>5,743,297,867</b>
Өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	277,652,992	-	-	952,598,017	<b>1,230,251,009</b>
Өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	22,103,523	337,321	--	72,647	<b>22,513,491</b>
<hr/>					
<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Байгууллага</b>	<b>ЖДҮ</b>	<b>Иргэд</b>	<b>Бусад</b>	<b>Нийт дүн</b>
Хүүгийн орлого	129,239,932	117,194,698	199,020,671	164,453,864	<b>609,909,165</b>
Хүүгийн зардал	(21,730,573)	(13,999,865)	(125,094,622)	(63,513,322)	<b>(224,338,382)</b>
Дотоод үнэлгээний эх үүсвэрийн хүүгийн орлого/зардал	(46,016,951)	(35,714,448)	45,213,876	36,517,524	-
<hr/>					
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>61,492,408</b>	<b>67,480,385</b>	<b>119,139,924</b>	<b>137,458,066</b>	<b>385,570,783</b>
Зээлжих эрсдэлийн сан	(72,990,625)	3,187,115	23,834,022	-	<b>(45,969,488)</b>
<hr/>					
<b>Цэвэр хүүгийн орлого/(сөрөг хүүгийн ахуйц ашиг) сангийн дараах</b>	<b>(11,498,217)</b>	<b>70,667,500</b>	<b>142,973,947</b>	<b>137,458,066</b>	<b>339,601,295</b>
Хураамж, шимтгэлийн орлого	12,770,871	31,761,145	39,062,984	536,978	<b>84,131,978</b>
Хураамж, шимтгэлийн зардал	-	(1,367,330)	(28,614,936)	(9,978,919)	<b>(39,961,185)</b>
Бусад хүүгийн бус цэвэр орлого/зардал	9,677,959	8,366,996	18,096,308	(50,769,456)	<b>(14,628,194)</b>
Удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал	(26,691,610)	(31,945,253)	(105,125,670)	(11,583,377)	<b>(175,345,911)</b>
<hr/>					
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>(15,740,997)</b>	<b>77,483,057</b>	<b>66,392,633</b>	<b>65,663,290</b>	<b>193,797,984</b>

**36 Сегментийн шинжилгээ (үргэлжлэл)**

Дотоодын хураамж ба шилжүүлгийн үнийн тохируулга нь бизнесийн сегмент бүрийн гүйцэтгэлд тусгагдсан болно. Бүтээгдэхүүн үйлчилгээ тус бүрт эсвэл ижил төстэй бүтээгдэхүүн үйлчилгээний бүлэг тус бүрийн гадаад харилцагчдаас орж ирсэн орлогын талаар илүү тодорхой мэдээлэл байхгүй ба тус мэдээллийг хөгжүүлэх зардал өндөр байдаг. Иймээс Банк үндсэн дөрвөн сегментэд үндэслэн үйл ажиллагааны сегментийг харуулсан.

2021 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн тайлагнах сегментийн мэдээллийг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2021 оны 12 сарын 31</b>				
	<b>Байгууллага</b>	<b>ЖДҮ</b>	<b>Иргэд</b>	<b>Бусад</b>	<b>Нийт дүн</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	1,194,590,938	869,615,612	1,274,968,287	-	<b>3,339,174,837</b>
Харилцагчийн харилцах, хадгаламж	1,231,819,362	1,058,668,533	3,173,055,495	-	<b>5,463,543,390</b>
Өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	225,603,662	-	-	1,753,836,211	<b>1,979,439,874</b>
Өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	18,013,329	395,571	-	63,815	<b>18,472,715</b>
<hr/>					
<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2021 оны 12 сарын 31</b>				
	<b>Байгууллага</b>	<b>ЖДҮ</b>	<b>Иргэд</b>	<b>Бусад</b>	<b>Нийт дүн</b>
Хүүгийн орлого	149,137,192	96,996,356	171,085,606	137,558,448	<b>554,777,602</b>
Хүүгийн зардал	(30,765,153)	(25,808,419)	(170,256,134)	(45,988,843)	<b>(272,818,549)</b>
Дотоод үнэлгээний эх үүсвэрийн хүүгийн орлого/зардал	(48,178,912)	(28,982,050)	159,928,377	(82,767,415)	-
<hr/>					
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>70,193,127</b>	<b>42,205,887</b>	<b>160,757,849</b>	<b>8,802,190</b>	<b>281,959,053</b>
Зээлжих эрсдэлийн сан	(21,929,426)	(14,137,657)	296,629	-	<b>(35,770,454)</b>
<hr/>					
<b>Цэвэр хүүгийн орлого/(сөрөг хүүгийн ахуйц ашиг) сангийн дараах</b>	<b>48,263,701</b>	<b>28,068,230</b>	<b>161,054,478</b>	<b>8,802,190</b>	<b>246,188,599</b>
Хураамж, шимтгэлийн орлого	9,171,450	25,056,921	3,026,576	25,238,195	<b>62,493,142</b>
Хураамж, шимтгэлийн зардал	-	(869,083)	(2,645,828)	(18,199,317)	<b>(21,714,228)</b>
Бусад хүүгийн бус цэвэр орлого/зардал	6,018,725	6,667,440	3,218,376	(113,161,563)	<b>(97,257,022)</b>
Удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал	(7,659,413)	(20,458,133)	(41,958,486)	(67,063,565)	<b>(137,139,597)</b>
<hr/>					
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>55,794,463</b>	<b>38,465,375</b>	<b>122,695,116</b>	<b>(164,384,060)</b>	<b>52,570,894</b>

### 37 Хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө ашиглахыг шаардахгүй, мөнгөн гүйлгээний тайланд ороогүй хөрөнгө оруулалтын ажил гүйлгээг дараах байдлаар харуулав:

Мянган төгрөгөөр	2022	2021
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн бус гүйлгээ</b>		
Зээлээр хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	(1,080,300)	(5,772,210)
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн бус гүйлгээ</b>	<b>(1,080,300)</b>	<b>(5,772,210)</b>

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө ашиглахыг шаардахгүй, мөнгөн гүйлгээний тайланд ороогүй санхүүгийн ажил гүйлгээг дараах байдлаар харуулав:

Мянган төгрөгөөр	2022	2021
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ</b>		
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх өрийн үнэт цаасны зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт	63,234,300	25,926,400
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ</b>	<b>63,234,300</b>	<b>25,926,400</b>

### 38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Банкны эрсдэлийн удирдлага нь санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, комплаенсийн эрсдэл, нөгөө талын буюу гуравдагч талын эрсдэл, хуулийн эрсдэл, нэр хүндийн эрсдэл, технологийн эрсдэл болон бусад цаг үеийн шинж чанартай тулгарах эрсдэлүүдийг хамардаг. Санхүүгийн эрсдэлд зах зээлийн эрсдэл (гадаад валютын ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл болон бусад зах зээлийн үнээс хамаарсан эрсдэл), зээлийн эрсдэл болон төлбөрийн чадварын эрсдэл багтдаг. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дэмжигдэж батлагдсан банкны “Эрсдэлийн аппетитын тогтолцоо болон Эрсдэлийн аппетитын тунхаглал”-ын хүрээнд эрсдэл өгөөжийн тэнцвэрт байдлыг хадгалах явдал юм.

Эрсдэлийн аппетитын тогтолцоо болон Эрсдэлийн аппетитын тунхаглал” нь банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хил хязгаарыг тодорхойлдог ба энэхүү хил хязгаарын хүрээнд банк бизнесийн зорилгодоо хүрэх, стратегиа хэрэгжүүлэхээр ажилладаг. Энэ нь банкны үйл ажиллагаанд тулгарах эрсдэлүүдийн хамгийн ерөнхий хязгаарлалтуудыг тодорхойлж өгдөг ба тодорхой эрсдэлүүд дээр баримтлах нарийвчилсан лимит хязгаарлалтууд холбогдох бодлого, журмын хүрээнд ерөнхий хязгаарлалтуудтай нийцтэй байдлаар тогтоогдоно. Эрсдэлийн аппетитын тогтолцоо болон тунхаглалын баримт бичгийг жил бүр банкны стратеги төлөвлөгөө, төсөвтэй уялдуулж дүгнэн, шаардлагатай тохиолдолд шинэчлэнэ. Банкинд шаардлагатай өөрийн хөрөнгө, стратеги төлөвлөгөөг эрсдэлийн түвшинтэй уялдуулж ажилладаг.

Эрсдэлийн засаглалын үүрэг хариуцлага болон нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үндсэн зорилгуудын нэг юм. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд эрсдэлийн засаглалын үндсэн бүрдүүлэгчид болох эрсдэлийн соёл, эрсдэлийн аппетитын хязгаар, эдгээрийн эрсдэл даах чадвар болон банкны нэгдсэн хяналт, баланстай үүсгэх уялдаа холбоог нэн тэргүүнд чухалчилдаг. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь “Гурван давхар хамгаалалтын шугам” бүхий эрсдэлийн засаглалын бүтцийг банкинд хэрэгжүүлдэг. Ашгийн төлөө ажиллаж буй бизнесийн нэгжүүд нэгдүгээр хамгаалалтын шугам, Эрсдэлийн удирдлагын хороо ба Эрсдэлийн удирдлагын газрын захирал хоёрдугаар хамгаалалтын шугамыг үүсгэж, Дотоод аудитын газар гуравдугаар хамгаалалтын шугам болно.



**38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон эрсдэлийн удирдлагын бодлого, хязгаарлалтын дагуу гүйцэтгэх түвшиний удирдлагууд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилладаг. Дотоод аудитын газар болон Эрсдэлийн удирдлагын газар нь бизнесийн нэгжүүд болон бусад нэгжийн ажилчид хяналтын үүргүүдээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хараат бус хяналт тавихаас гадна ТУЗ-ийн Эрсдэлийн хороо, Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад харьяалагдах Удирдлагын хороо болон Гүйцэтгэх захиралд шууд тайлагнадаг.

Эрсдэлийн удирдлагын хяналт, шалгалт нь банкны холбогдох хорооноос баталсан эрсдэлийн лимит хязгаарлалтуудад суурилан хийгддэг. Эдгээр лимит хязгаарлалтууд нь банкны бизнесийн стратеги, зах зээлийн нөхцөл байдал болон бизнесийн үйл ажиллагаандаа хүлээн зөвшөөрөн ажиллаж байгаа эрсдэлийн түвшинд уялдаатай тогтсон байдаг. Хүү, гадаад валютын ханш болон бусад зах зээлийн үнийн хэлбэлзлээс шалтгаалан үүсэх эрсдэлийг бууруулах зорилгоор стресс тест шинжилгээг хийж, банкны нэгдсэн эрсдэлийн удирдлагын нэг хэсэг болгосон.

**Зээлийн эрсдэл:** Банк нь зээлийн эрсдэлд өртдөг бөгөөд энэ нь санхүүгийн хэрэглүүрт нэг тал хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс нөгөө тал санхүүгийн алдагдал үүрэх эрсдэл юм.

Банк оролцогч талуудтай зээлийн болон бусад ажил гүйлгээний үр дүнд зээлийн эрсдэлд өртөж, санхүүгийн хөрөнгө ба балансын гадуурх зээлтэй холбоотой үүрэг амлалтыг бий болгодог. Банкны зээлийн эрсдэлд хамгийн их өртөх хэсэг нь санхүүгийн байдлын тайлан дахь санхүүгийн хөрөнгийн дансны үнээр тусгагдсан байдаг. Гаргасан санхүүгийн баталгаа, зээлийн шугам, экспорт импортын аккредитивийн үүрэг амлалтын хувьд зээлийн эрсдэлийн хамгийн их өртөх хэсэг нь нийт үүргийн дүн юм.

**Зээлийн эрсдэлийн удирдлага.** Зээлийн эрсдэл нь Банкны бизнесийн хамгийн том эрсдэл юм. Тиймээс удирдлага нь зээлийн эрсдэлийг хариуцлагатайгаар удирддаг.

Эрсдэлийн удирдлагын зорилгоор зээлийн эрсдэлийн тооцоолол нь нарийн төвөгтэй бөгөөд эрсдэл нь зах зээлийн нөхцөл байдал, хүлээгдэж буй мөнгөн урсгал, цаг хугацаа зэргээс хамааран өөр өөр байдаг. Зээлийн багцад зориулсан эрсдэлийн үнэлгээ нь дефолт болох магадлал, алдагдлын харьцаа болон холбоотой талуудын хоорондын дефолт болох уялдааг тооцоолох шаардлагатай байдаг.

**Хязгаарууд.** Банк нь нэг зээлдэгч, холбоотой талууд, эдийн засгийн төвлөрөлүүдэд хүлээн зөвшөөрсөн эрсдэлийн хэмжээг тогтоох замаар зээлийн эрсдэлийн түвшинг тогтоодог. Бүтээгдэхүүн болон эдийн засгийн салбарын зээлийн эрсдэлийн түвшний хязгаарлалтыг удирдлагын зүгээс байнга баталж байдаг. Эрсдэлийг жил тутам эргэн хянадаг ба шаардлагатай тохиолдолд илүү ойрхон давтамжтайгаар хянадаг.

Харилцааны менежерүүд харилцагчаас ирсэн зээлийн өргөдлийг судалж, зээлийн дүнд батлуулахаар холбогдох зээлийн хороонд шилжүүлдэг. Зээлийн эрсдэлийг удирдах болон бууруулах зорилгоор барьцаа хөрөнгө, компанийн болон хувийн батлан даалт авдаг. Зээлийн эрсдэлд өртөх магадлалыг хянахын тулд харилцагчийн бизнесийн болон санхүүгийн гүйцэтгэлд чиглэсэн бүтцийн дүн шинжилгээнд үндэслэсэн тайланг зээлийн газрын мэргэжилтнүүд тогтмол гаргадаг. Зээлийн найдвартай байдлыг алдагдуулсан харилцагчдын зээлийг Зээлийн Хороогоор тайлагнадаг.

Зээлийн эрсдэлийн ангилал	Холбогдох дотоод үнэлгээ	Гадаадын олон улсын үнэлгээний агентлагуудын зохих үнэлгээ (Стандарт энд Пүүр`с)	Холбогдох PD интервал
Маш сайн	0	AAA to BB+	0,16% - 0,81%
Сайн	1	BB to B+	0,82% - 3,63%
Хангалттай	2	B, B-	3,64% - 7,25%
Тусгай хяналттай	3	CCC+ to CC-	7,26% - 99,9%
Дефолт	4	C, D-I, D-II	100%

### **38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын аргачлал.** ХБЭА нь ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлын өнөөгийн үнэ цэнэ (өөрөөр хэлбэл: зээлийн үргэлжлэх хугацаанд зээл дефолт болоход жигнэсэн дундаж алдагдал юм). ХБЭА нь нэг хүчин зүйлээс шууд хамааралтай бус хэд хэдэн боломжит хувилбаруудаас хамаарч тооцоологддог. Банкны ХБЭА-ын тооцоолол дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: Дефолт болох магадлал ("PD"), Дефолт болох үеийн үлдэгдэл ("EAD"), Алдагдал хүлээх магадлал ("LGD") болон хорогдуулалтын хувь ("DR").

PD нь өгөгдсөн хугацааны туршид дефолт болох магадлалын тооцоолол юм. LGD нь зээл дефолт болсон тохиолдолд түүнээс хүлээж болзошгүй алдагдлын тооцоолол юм. LGD нь гэрээний дагуух төлөх ёстой мөнгөн дүн болон зээлдүүлэгч тухайн зээлээс төлүүлж чадах мөнгөн дүн хоёрын зөрүү юм. Харилцагчаас төлүүлж чадах мөнгөн дүнд барьцаа хөрөнгө орно. LGD нь ихэвчлэн EAD –д эзлэх хувиар илэрхийлэгддэг. Хүлээгдэж буй алдагдлыг тайлант хугацааны эцэст өнөөгийн үнэ цэнээр хорогдуулна. Хорогдуулалтын хувь нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшин ("EIR") юм.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцооллыг зээлийн дуусах хугацаа хүртэлхээр загварчилсан. Дуусах хугацаа нь өрийн хэрэглүүрийн гэрээний үлдсэн хугацаа ба гэрээнээсээ өмнө төлөгдөх магадлалыг тохируулдаг. Зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааны гэрээний хувьд тухайн аж ахуйн нэгж зээлийн хугацааг сунгах гэрээний үүрэгтэй гэрээт хугацаа юм. Дуусах хугацааг гэрээний дагуу хүлээгдэж буй үлдэгдэл хугацаагаар тодорхойлдог бол хувь хүнд олгосон зээлийн картын хувьд дуусах хугацаа нь гэрээний дагуу картын хугацаа бөгөөд энэ нь хамгийн ихдээ 2 хүртэлх жилтэй тэнцүү байна.

Банк санхүүгийн хэрэглүүрийн дуусах хугацааны турш дахь ХБЭА-ын загвар боловсруулсан ба энэ нь зээлийн дуусах хугацааны турш болзошгүй бүх дефолт тохиолдлоос үүсэх алдагдал юм. 12 сарын ХБЭА нь зээлийн дуусах хүртэлх хугацааны ХБЭА-ын нэг хэсэг нь бөгөөд тайлант хугацаанаас хойших 12 сарын хугацаанд үүсэж болзошгүй алдагдал юм. Хэрэв зээлийн дуусах хугацаа нь 12 сараас бага байвал хүлээж болзошгүй зээлийн алдагдлыг дуусах хугацаа хүртэл тооцоолно.

Санхүүгийн тайланд толилуулсан ХБЭА-ын тооцоолол нь дотоодын зохицуулагч байгууллагад зориулсан урт хугацааны өгөгдлийг ашиглах бус сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан. Тооцоолол нь ирээдүйн таамаглалыг агуулсан буюу зээлийн эрсдэлд нөлөөлдөг гол макро хувьсагчуудын ирээдүйд болох таамаглал тусгагдсан.

Худалдан авсан болон үнэ цэнийн бууралт ("POCI")-тай санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЭА-ын загвар дараахаас бусад тохиолдолд ялгаатай биш: (а) нийт дансны үнэ болон хөнгөлөлтийн хувь нь хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед нөхөгдөх боломжтой байсан мөнгөн гүйлгээнд суурилдаг, гэрээгээрх мөнгөн гүйлгээнд үндэслэгддэггүй, болон (б) ХБЭА нь хугацааны туршид дахь ХБЭА байна. Худалдан авсан болон үнэ цэнийн бууралт ("POCI")-тай санхүүгийн хөрөнгө нь өнгөрсөн бизнесийн нэгдэлд авсан үнэ цэнийн бууралттай зээл зэрэг анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгө юм.

Банк дефолт болох магадлалыг тооцоолохдоо доор дурдсан нөхцөлүүдийн аль нэгийг эсвэл хэд хэдэн нөхцөлийг зэрэг хангасан зээлийг дефолт болсон гэж үздэг. Үүнд:

- Зээл төлөгдөхгүй байх: Доорх нөхцөлүүд илэрсэн тохиолдолд зээлийн төлөгдөхгүй байх магадлал ихэсдэг:
  - а. зээлдэгч эсвэл үнэт цаас гаргагч санхүүгийн хүндрэлд орсон;
  - б. гэрээний нөхцөл зөрчигдсэн буюу хүүгийн болон үндсэн зээлийн эргэн төлөлт хугацаа хэтэрсэн;
  - в. зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй холбоотой эдийн засаг, эрх зүйн шалтгаанаар зээлдэгч зээлдүүлэгчид концесс олгох;
  - г. зээлдэгч дампуурлаа зарлах буюу санхүүгийн дахин зохион байгуулалт хийх магадлалтай байх;
  - д. санхүүгийн хүндрэлээс болж идэвхтэй зах зээлгүй болох; эсвэл
- Зээлдэгч нь 90 хоногоос дээш хугацаагаар гэрээний төлбөрийг төлөөгүй байх

### 38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Тодруулгын зорилгоор, Банкны дефолтын тодорхойлолт болон зээлийн үнэ цэнэ бууралтын тодорхойлолт хооронд ямар нэгэн зөрүүгүй бөгөөд дээр дурдсан дефолт тодорхойлолт нь Банкны санхүүгийн бүх хөрөнгөнд мөрдөгдөнө.

Санхүүгийн хөрөнгө нь 6 сарын дараалан дефолт тодорхойлолтонд заасан нөхцөлүүдийг хангаагүй тохиолдолд дефолтоос гарч болно. 6 сар гэдэг нь санхүүгийн хөрөнгө дефолтоос гарсан хөрөнгө буцаж дефолт болсон хугацааны тооцоолол дээр үндэслэн гарсан болно.

Зээл анх олгогдсоноос хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн (SICR) эсэх үнэлгээ нь зээл нэг бүрчлэн хийгддэг. Банкны зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэх нөхцөлүүд нь тохиромжтой байдлыг тогтмол хугацаатай хянаж байдаг. Зээл анх олгогдсоноос хойш эрсдэл илэрхий өссөн эсэх шалгууруудын нэг болох хугацаа хэтэрсэн хоног нь 30–аас дээш байх нөхцөл өөрчлөгдөөгүй болно. Тодруулга 3-аас дэлгэрэнгүйг үзнэ үү.

Банк нь нэг эсвэл түүнээс их тоон болон чанарын шалгуур үзүүлэлтүүдийг хангасан тохиолдолд хөрөнгийг зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (SICR)-тэй гэж үздэг.

Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцоолол нь харилцагчийн зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өссөн эсэхэд тулгуурладаг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцооллын загвар нь 3 үе шаттай байдаг. Санхүүгийн хэрэглүүр нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үед ямар нэг үнэ цэнийн бууралтгүй байдаг ба түүний зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ихх хэмжээгээр нэмэгдээгүй бөгөөд 12 сарын ХБЭА (1-р үе шат)-д үндэслэн эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг тооцдог.

Хэрвээ зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн нь тогтоогдсон тохиолдолд үе шат 2–т орж, дуусах хугацаа хүртэлх ХБЭА-д үндэслэн эрсдэлийн алдагдлыг тооцоолно. Үе шат 2–т орсон зээлүүд нь үнэ цэнэ буураагүй зээлүүд болно. Санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнэ буурсан тохиолдолд үе шат 3–т хуваарилагдаж, дуусах хугацаа хүртэлх алдагдлыг тооцоолдог. Үе шат 3–т орсон зээлүүдийн хүүгийн орлогыг зээлийн эрсдэлийн сангаас цэвэршүүлсэн дүнд тооцоолдог.

Хэрвээ зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг үнэлдэг шалгуурууд нь тухайн зээлд дахин илрээгүй бол үе шат 1 рүү шилжинэ. Банк чанарын үзүүлэлтээр үе шат 2–руу шилжсэн зээлүүдийг тогтмол хянадаг.

Үнэ цэнэ буурсан зээл олгосон ба худалдан авсан зээлүүдийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь үргэлж дуусах хугацаа хүртэлхээр тооцоологддог. Иймд Банк эдгээр зээлийн хувьд зөвхөн дуусах хугацаа хүртэлх ХБЭА-ын зөрүүг бүртгэдэг.

ECL-ын тооцоолол нь хоёр үнэлгээний аргаас бүрддэг. Үүнд: (i) тусгай үнэлгээ; (ii) багцын үнэлгээ: зээлийн багцын нэг ижил төрлийн сегментүүдийн хувьд ХБЭА-ын тооцоололд ижил зээлийн эрсдэлийн параметр (жишээ нь, PD, LGD) -ийг хэрэглэнэ; мөн (iii) гадаад үнэлгээнд үндэслэсэн үнэлгээ. Банк дараах төрлийн зээлүүдийг тусгай үнэлгээний аргаар үнэлдэг. Үүнд: өндөр дүнтэй, нөлөө бүхий зээлүүд буюу харилцагчийн нийт зээлийн үлдэгдэл нь 1,000,000 мянган төгрөгөөс дээш бөгөөд үе шат 2 ба 3–т орсон зээлүүдийг тусгай үнэлгээний аргаар үнэлдэг. Банк дараах төрлийн зээлүүдэд багцын үнэлгээ хийдэг. Үүнд: (1) харилцагчийн нийт зээлийн үлдэгдэл нь 1,000,000 мянган төгрөгөөс дээш бөгөөд үе шат 1–т орсон зээлүүд; (ii) иргэдийн хэрэглээний зээл болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгосон зээлүүд орно. Энэхүү арга нь зээлийн багцыг хугацаа хэтэрсэн хоног, зээлийн түүхэн алдагдал болон бусад мэдээллүүдэд үндэслэн харилцагч бүрийн мэдээллийг харгалзан сегментэд хуваарилдаг. Банк нь хорогдуулсан өртгөөр болон бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдсэн өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт болон бусад банкнуудад байршуулсан хөрөнгүүдийн үнэлгээ хийхдээ гуравдагч байгууллагын үнэлгээг ашигладаг.

Тусгай үнэлгээний аргаарх ХБЭА-ын тооцоолол нь боломжит хувилбаруудыг үнэлэх бөгөөд хувилбар бүрийн магадлалыг харгалзан алдагдлыг тооцоолдог. Банк тусгай үнэлгээний аргаар үнэлэгдэж байгаа зээл бүр дээр багадаа 2 боломжит хувилбар гаргадаг ба аль нэг хувилбарын тохиолдох магадлал бага ч гэсэн зээлийн алдагдал тооцоологддог. Тусгай үнэлгээний зээлүүд нь Банкны зээлийн газрын туршлагатай мэргэжилтнүүдээр үнэлэгддэг. Үнэлгээ ба бодит алдагдал хоорондын зөрүүг бага байлгах үүднээс үнэлгээг тогтмол хянаж байдаг.

Багцын үнэлгээний аргаар багцын алдагдлын санг тооцоолохдоо зээл бүрийг үе шат бүрт хуваарилдаг.

### 38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Банк зээлийн эрсдэлийн нийтлэг шинж чанарт үндэслэн тодорхойлогдсон сегментүүдээр эрсдэлээ шинжилдэг. Банк зээлүүдийг ижил төрлийн эрсдэлийн шинж чанартайгаар нь ялган бүлэглэж тооцоолдог. Ижил төрлийн эрсдэлийн шинж чанартай зээл гэдэг нь харилцагчийн ангилал (байгууллагын харилцагч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хэрэглээний болон орон сууцны зээл), зээлийн валют болон бүтээгдэхүүний төрөл юм. Бүлэг болгон өөр өөр дефолт болох магадлал, алдагдал хүлээх магадлал зэрэг эрсдэлийн параметруудтай байна. Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс зээлүүдийг бүлэглэх нь зохистой байгаа эсэхийг тогтмол хянаж байдаг.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь EAD, PD, LGD зэрэг эрсдэлийн параметруудийн үржвэр бөгөөд тухайн санхүүгийн хөрөнгийн үр ашигт хүүгээр дискаунт хийж өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдэнэ. Эрсдэлийн параметр (EAD, PD, LGD)–ыг ирэх нэг жилийн таамаглалын тооцооллыг зээл нэг бүрийн эсвэл багцалсан зээлүүдийн хувьд гаргаж тооцоолдог. Эдгээр гурван бүрэлдэхүүн параметруудийг үржүүлэх ба зээл хугацаанаасаа өмнө төлөгдөх эсвэл дефолт болох эсэх гэсэн тохируулгуудыг хийж өгдөг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь зээл бүрийн ирээдүйн алдагдлыг тооцоолол ба тайлант огноо руу дискаунт хийсэн алдагдлуудын нийлбэр юм. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцоололд ашиглагдаж буй дискаунт хүү нь үр ашигт хүү эсвэл ойролцоо тооцоолсон хүү байна.

**Зээлийн эрсдэлийн параметруудийг тооцоолох үндсэн зарчмууд.** EAD-ууд нь хүлээгдэж буй төлбөрийн хуваарьт тулгуурлан тодорхойлогддог бөгөөд энэ нь бүтээгдэхүүний төрлөөс хамаарна. EAD нь зээлдэгчийн хүлээсэн үүргийнхээ дагуу ирэх 12 сар эсвэл дуусах хугацааны туршид төлөх ёстой зээлийн эргэн төлөлтөнд тулгуурладаг. Үүнийг мөн зээлдэгчийн төлөхөөр хүлээгдэж буй илүү төлбөрт тохируулдаг. Зээлдэгч нь зээлийн хуваарьт зааснаас өмнө зээлээ урьдчилан төлөх магадлалтай дүнгээр зээлийн эргэн төлөлтийн хуваарьт тохируулга хийдэг. Эргэн төлөлт, дахин санхүүжилтийн таамаглалыг мөн тооцоололд оруулдаг. Эргэлтийн бүтээгдэхүүнүүдийн хувьд EAD нь одоогийн үлдэгдлийг авч, зээлийн хөрвүүлэлтийн коэффициент ашиглан үлдсэн хугацаан дахь хүлээгдэж буй зээл олголтыг нэмж тооцоолдог. Эдгээр таамаглалууд нь бүтээгдэхүүний төрөл, одоогийн зээлийн эрхийг хэрэглээ болон зээлдэгчийн онцлог зан төлөвөөс хамаарч ялгаатай байж болно.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тооцоход хоёр төрлийн дефолт болох магадлал (PD)–г ашигладаг ба эдгээр нь 12 сар ба дуусах хугацааны турш дахь PD юм. 12 сарын PD–ийн үнэлгээг нь хамгийн сүүлийн үеийн өгөгдөл дээр суурилсан. Дуусах хугацааны турш дахь PD нь санхүүгийн хэрэглүүрийн үлдсэн хугацааны туршид дефолт болох магадлал ба энэ нь санхүүгийн хэрэглүүрийн 12 сар болгоны дефолт болох магадлалын нийлбэр байна.

Банк шилжих хөдөлгөөнт матрицийн статистик аргагүйг ашиглан дуусах хугацааны турш дефолт болох магадлалыг харилцагчийн ангилал болон хугацаа хэтэрсэн хоногт тулгуурлан тооцоолдог. Тухайлбал, шилжих хөдөлгөөний матрицад суурилсан 12 сарын PD-ийг экстраполяци хийж, түүхэн дефолт өгөгдөлд суурилсан дуусах хугацааны туршийн PD муруйг сайжруулах гэх мэт.

Алдагдал хүлээх магадлал нь Банкны дефолт болсон зээлүүдээс хүлээж болзошгүй алдагдлыг илэрхийлнэ. LGD нь бүтээгдэхүүний төрөл, дефолт болсон хугацаанаас хамаарна. 12 сар ба дуусах хугацааны туршийн алдагдал хүлээх магадлал нь зээл дефолт болсны дараа хүлээгдэж буй эргэн төлөлтөнд нөлөөлөх хүчин зүйлсийг авч үздэг. Алдагдал хүлээх магадлалыг гурван боломжит аргад хувааж болно:

- Зээлийн барьцааны онцлог шинжид үндэслэсэн хэмжилт;
- Багцын түвшинд эргэн төлөлтийн статистикт үндэслэсэн хэмжилт; эсвэл
- Өөр өөр хүчин зүйлс, хувилбаруудаас шалтгаалсан тусгайлан үнэлсэн хэмжилт.

Банк алдагдал хүлээх магадлалыг барьцаа хөрөнгийн шинж чанараас хамааруулан тооцоолдог. Жишээ нь, барьцаа хөрөнгийн үнэлгээ, барьцаа хөрөнгө хямдруулж зарсан түүхэн өгөгдөл, үл хөдлөх хөрөнгийн төрөл, мөнгөн хөрөнгө, бусад хөрвөх баталгаа гэх зэрэг олон шинж чанараас хамаардаг. Алдагдал хүлээх магадлалыг хамгийн сүүлийн үеийн эргэн төлөлтийн статистикт суурилан байгууллагын зээлүүд болон хэрэглээний бүх зээлүүдэд багцын түвшинд тооцоолдог. Хямдруулалтын дараах барьцаа хөрөнгийн үнэлгээ нь алдагдал хүлээх магадлалын тооцоололд ордог. Хэрвээ хямдруулалтын дараах барьцаа хөрөнгийн үнэлгээ нь дефолт болох үеийн зээлийн үлдэгдэл (EAD)–ээс бага байвал Банк үлдэгдэл болон хямдруулалтын дараах барьцаа хөрөнгийн үнэлгээ хоёрын зөрүүнээс алдагдал хүлээдэг. (1- эргэн төлөлтийн хувь)

### 38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

**Санхүүгийн баталгаа болон зээлийн үүрэгт тооцох ХБЭА-ын хэмжилт.** Эдгээр хэрэглүүрийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт нь дээр дурдсантай ижил тооцоологдох боловч дефолт болох үеийн зээлийн үлдэгдэл (EAD)–ийн тооцооллын хувьд ялгаатай байна. EAD нь зээл хөрвүүлэлтийн коэффициент ("CCF") болон үүргийн дүн ("ExOff")–ээс хамаарна. Зээл хөрвүүлэлтийн коэффициент нь олгогдоогүй зээлийн үүрэг, зээлийн карт, санхүүгийн баталгааны түүхэн статистик тооцоололд тулгуурладаг.

**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөцийн үлдэгдэлд тооцох ХБЭА-ын хэмжилт.** Эдгээр хөрөнгөнд ХБЭА-ын тооцоолол нь бусад банкуудад байршуулсан хөрөнгөтэй адилхан аргачлалаар хийгдэнэ. Гэвч бэлэн мөнгө болон заавал байлгах нөөц нь 14 хоногийн богино хугацаатай тул ач холбогдол багатай.

**Бусад банкуудад байршуулсан хөрөнгөнд тооцох ХБЭА-ын хэмжилт.** Бусад банкуудад байршуулсан хөрөнгөнд тооцох ХБЭА нь бусад активаас (зээл, үнэт цаас гэх мэт) ялгаатай. Харилцах данс нь богино хугацаатай тул хүлээгдэж буй алдагдал материаллаг бус байна. Урт хугацааны байршуулалтад Банк боломжит хамгийн өндөр зээлжих зэрэглэлтэй буюу дефолт болох магадлал багатай банкиг сонгодог. Банкны хувьд бусад банкуудад байршуулсан хөрөнгийн 70-80 хувь нь дунджаар хөрөнгө оруулалтын зэрэглэлтэй банкуудад байршдаг.

Банк нь бусад банкуудад байршуулсан хөрөнгийг зээлжих зэрэглэлээр таван ангилалд хуваадаг. Дараах хүснэгтэнд ангилал бүрийн зээлжих зэрэглэлийг харуулав.

Ангилал	Зээлийн зэрэглэл
Маш сайн	Ааа – А3
Сайн	Ваа1 – Ва3
Хангалттай	В1 – В3
Тусгай хяналттай	Саа1 – СА, үнэлгээгүй
Дефолт	С

Банк дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглаж бусад банкинд байршуулсан хөрөнгийн SICR (Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт) нөхцөл байдал үүссэн эсэхийн тодорхойлно. Үүнд:

- 30 өдрийн хугацаа хэтэрсэн хоног;
- Зээлжих зэрэглэл нь сүүлийн жилд хоёр ба түүнээс дээш зэрэглэлээр буурсан эсвэл
- хөрөнгө оруулалтаас доогуур зэрэглэлтэй болсон тохиолдол;
- Дефолт төлөв;

Үе шатлалыг тогтоох арга нь хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтийн ерөнхий аргачлалын дагуу хийгддэг:

Анх олгох үед болон түүнээс хойш зээлийн эрсдэл нь муудаагүй, үнэ цэнэ буураагүй санхүүгийн хэрэглүүрт 12 сарын хугацааны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тооцоолох ба эдгээр хөрөнгүүд нь үе шат 1–т шилжүүлнэ. Хэрвээ зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн нь тогтоогдсон тохиолдолд үе шат 2–т шилжүүлж, дуусах хугацаа хүртэлх ХБЭА-ыг үндэслэн эрсдэлийн алдагдлыг тооцоолно. Үе шат 2–т орсон зээлүүд нь үнэ цэнэ буураагүй зээлүүд болно. Санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ буурсан тохиолдолд үе шат 3–т хуваарилагдаж, дуусах хугацаа хүртэлх ХБЭА-ыг үндэслэн эрсдэлийн алдагдлыг тооцоолно.

Банкны туршлагад суурилбал Банк нь бусад банкуудын дефолт эсвэл дампуурлын улмаас алдагдал хүлээж байгаагүй. Гэсэн хэдий ч, ирээдүйд дефолт болох боломжтойг мөн үгүйсгэхгүй. Гэвч Банкны дотоод өгөгдөл ийм магадлалыг тооцоолоход хангалтгүй учир бусад банкуудад байршуулсан хөрөнгөнд тооцох PD, LGD, EAD-д дараах ялгаа гардаг.

Бусад банкуудад байршуулсан хөрөнгөнд ХБЭА-ыг тооцох шалгуур үзүүлэлт нь зээлд зориулсан ерөнхий аргатай харьцуулахад нэг үзүүлэлтээс бусдаар ижил байдаг. Энэ нь дефолтын тодорхойлолтод "С" ба түүнээс дооших зэрэглэл хамрах ба энэ нь агентлагуудын тодорхойлсны дагуу "дефолтод орсон" хэмээх тодорхойлолт юм.

Банк Мүүди`с-ийн тайлан дахь зээлжих зэрэглэлээр ангилсан байгууллагын зээлийн дефолт болох магадлалыг ашиглаж 12 сарын PD-г тодорхойлдог. Мөн илүү нарийвчлалтайгаар ХБЭА-ыг тооцоолохын тулд 12 сарын PD-г 1 өдөр болгон шилжүүлдэг.

### 38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Хуримтлагдсан зээлдэгчээр жиллэсэн олон улсын дундаж дефолт болох магадлал зээлжих зэрэглэлээр, 1983-2021<sup>1</sup>

Зээлжих зэрэглэл	1 жилийн байдал	Зээлжих зэрэглэл	1 жилийн байдал
Aaa	0.000%	Ba1	0.393%
Aa1	0.000%	Ba2	0.632%
Aa2	0.000%	Ba3	1.190%
Aa3	0.041%	B1	1.777%
A1	0.059%	B2	2.748%
A2	0.042%	B3	4.236%
A3	0.051%	Caa1	3.953%
Baa1	0.099%	Caa2	7.552%
Baa2	0.134%	Caa3	17.326%
Baa3	0.212%	Ca-C	30.038%

Дефолт болох үеийн үлдэгдэл (EAD)-ийн хувьд Банк тухайн тооцоолол хийх үеийн дансны үлдэгдлийг авч тооцдог.

Алдагдал хүлээх магадлал (LGD)-ын хувьд энэ магадлалын түүхэн өгөгдөл хангалттай бус байна. Тиймээс Банк Мүүди́с-ийн тайлан дахь байгууллагын зээлийн эргэн төлөгдөх түвшинг ашиглаж LGD-г тооцдог.

**Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтад тооцох ХБЭА-ын хэмжилт (Засгийн газрын үнэт цаас, Төв банкны үнэт цаас болон Компанийн бонд).** Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтад тооцох ХБЭА нь дээр дурдсантай ижил алхамаар хийгддэг бөгөөд энэ нь бусад банкнуудад байршуулсан хөрөнгөтэй ижил дефолтын тодорхойлолт болон SICR-ийн шалгуур үзүүлэлттэй байна гэсэн үг юм. Гэвч өгөгдлийн хангалттай бус байдлаас үүдэн PD, LGD-г ялгаатай аргачлалаар тооцох шаардлагатай бөгөөд өрийн үнэт цаасны хувьд PD, LGD-г хэмжихэд доорх зөрүү гарч байна.

Банк нь өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг хугацаа хэтрэлтээр нь таван ангилалд хуваадаг. Дараах хүснэгтэнд ангилал бүрийн хугацаа хэтрэлтийг харуулав.

Ангилал	Хугацаа хэтэрсэн хоног
Маш сайн	0
Сайн	1 – 30
Хангалттай	31 – 60
Тусгай хяналттай	61 – 90
Дефолт	>90

Банк өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтад бусад банкнуудад байршуулсан хөрөнгөтэй ижил SICR-н шалгуур үзүүлэлтийг ашигладаг:

- 30 хоногийн хугацаа хэтэрсэн;
- Зээлжих зэрэглэл нь сүүлийн жилд хоёр ба түүнээс дээш зэрэглэлээр буурсан эсвэл хөрөнгө оруулалтаас доогуур зэрэглэлтэй болсон тохиолдол;
- Дефолт төлөв;

Үе шатлалын тогтоох арга нь ерөнхий хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэмжих аргачлалын дагуу явагдана:

Анх олгох үед болон түүнээс хойш зээлийн эрсдэл нь муудаагүй, үнэ цэнэ буураагүй санхүүгийн хэрэглүүр дээр 12 сарын хугацааны ХБЭА-ыг тооцоолох буюу эдгээр хөрөнгүүд нь үе шат 1–т орно. Хэрвээ зээлийн эрсдэл илэрхий өссөн нь тогтоогдсон тохиолдолд үе шат 2–т шилжүүлж, дуусах хугацаа хүртэлх ХБЭА-ыг үндэслэн эрсдэлийн алдагдлыг тооцоолно. Үе шат 2–т орсон зээлүүд нь үнэ цэнэ буураагүй зээлүүд болно. Санхүүгийн хэрэглүүр нь үнэ цэнэ буурсан тохиолдолд үе шат 3–т шилжүүлж, дуусах хугацаа хүртэлх ХБЭА-ыг үндэслэн эрсдэлийн алдагдлыг тооцоолно.

Үүнээс гадна, дефолтын тодорхойлолтод "С" ба түүнээс дооших зэрэглэл хамрах ба энэ нь агентлагуудын тодорхойлсны дагуу "дефолтод орсон" хэмээх тодорхойлолт юм.

<sup>1</sup> Эх сурвалж: Жилийн дефолт судалгаа: Компанийн дефолтын болон эргэн төлөлтийн хэмжээ, 1920-2021.

**38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

Дефолт болох магадлал (PD)-д өрийн үнэт цаасны ихэнхийг нь Эрх бүхий байгууллагуудаас гаргасан байдаг тул Банк Мүүди`с-ийн тайлан<sup>2</sup> дахь Эрх бүхий байгууллагын нэг жилийн дефолт болох магадлалыг авч ашигладаг. Үүнийг мөн бусад банкнуудад байршуулсан хөрөнгөтэй адил 1 өдөр болгон шилжүүлдэг.

Хуримтлагдсан үнэт цаас олгогчоор жинлэсэн улсын дефолт болох магадлал, 1983-2021<sup>2</sup>

Зээлжих зэрэглэл	1 жил
Ааа	0.000%
Аа	0.000%
А	0.000%
Ваа	0.000%
Ва	0.442%
В	2.431%
Саа-С	12.352%

Дотоод, гадаад эх сурвалжийн өгөгдлийн дутагдалтай байдлаас шалтгаалан Банк нь компанийн болон санхүүгийн бус бизнесийн салбарын өрийн үнэт цаасны хувьд байгууллагын сегментийн зээлийн багцын түүхэн PD-г ашигладаг.

Алдагдал хүлээх магадлал (LGD)-г тооцохын тулд Банк нь ЗГ-ын секторын LGD-г хэмжихдээ “Давуу эрхтэй бондын эргэн төлөлтийн Мүүди`с-ийн өгөгдөл (1983-2020)”-ийн эргэн төлөгдөх түвшинг ашигладаг. Мөн өгөгдлийн асуудлаас шалтгаалан Банк нь байгууллагын сегментийн зээлийн багцын түүхэн LGD-г компанийн болон санхүүгийн бус бизнесийн салбарын өрийн үнэт цаасанд ашигладаг.

**Урвуу репо хэлцэлд тооцох ХБЭА-ын хэмжилт.** Урвуу репо хэлцлийн ХБЭА-ын хэмжилт нь өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалттай адил аргачлалтай. Энэ тохиолдол нь Монголбанкны үнэт цаасаар бүрэн барьцаалсан буюу дефолтоос бүрэн эргэн төлөгдөх тул урвуу репо хэлцлийн ХБЭА нь материаллаг бус юм.

**ХБЭА-ын тооцоололд орсон ирээдүйн мэдээлэл.** Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцоолол нь үнэлгээний хуудас ашигладаг бөгөөд үнэлгээний хуудаст орсон мэдээлэл нь ирээдүйд чиглэсэн мэдээлэл байдаг. Банк зээлийн эрсдэл болон хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалтай уялдаа хамааралтай эдийн засгийн хувьсагчуудыг сонгон авч тооцоололд оруулдаг.

Дээр дурдсан СТОУС 9-ийн шаардлага нь санхүүгийн бүх байгууллагуудыг нарийн төвөгтэй тооцооллын загвартай байхыг шаардаагүй. Өгөгдлийн чанар болон түүхэн өгөгдлөөс хамааран банк ирээдүйн таамаглалыг аль нэг эрсдэлийн параметрт оруулахгүйгээр нийт алдагдлын үр дүнд оруулахаар шийдвэрлэсэн. Банк түүхэн дефолт өгөгдөл болон макро эдийн засгийн хувьсагч хоорондын хамаарлын шинжилгээ хийсэн бөгөөд эдгээр нь хоорондоо тийм ч их уялдаа хамааралтай байгаагүй.

Банкны хэрэгжүүлэхээр сонгосон арга зам нь үнэлгээний хуудас юм. Энэхүү арга нь хэд хэдэн макро хувьсагчуудыг сонгон авч ирээдүйн мэдээллийг үнэлгээнд оруулдаг. Хувьсагчуудын талаарх өгөгдлийг Монголбанк, Блүүмбэрг, Трэйдинг Экономикс зэрэг нэр хүндтэй эх сурвалжуудаас авч ашигладаг.

Дээрх эх сурвалжуудаас олж авсан мэдээллүүдийг ашиглан Банк ирээдүйн чиг хандлагын талаар шинжилгээ хийх бөгөөд ирээдүйн таамаглал нь эерэг, сөрөг, тогтвортой чиг хандлагыг илэрхийлж байгаа эсэхийг түүхэн мэдээллийг ирээдүйн таамаглалтай харьцуулж тодорхойлдог. Ирээдүйн чиг хандлага (эерэг, сөрөг, тогтвортой) бүр дараах үржүүлэгчүүдтэй:

- Эерэг – 0.6
- Тогтвортой – 1.1
- Сөрөг – 1.6

<sup>2</sup> Эх сурвалж: Улсын дефолт болон Эргэн төлөгдөх түвшин, 1983-2021.

### 38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Үржүүлэгчид нь эдийн засгийн түүхэн мэдээлэлд тулгуурладаг бөгөөд энэ нь эдийн засаг хэвийн үед буюу эдийн засгийн хямрал эсвэл огцом өсөлтийг оруулахгүйгээр тогтвортой өсөлттэй байх үед санхүүгийн байгууллагуудын алдагдал 30%-аар багасдаг бол сөрөг үед алдагдал 60%-аар ихэсдэг. Иймд эерэг үеийн үржүүлэгч нь 0.6 (1-30%), эдийн засгийн зогсонги үед үржүүлэгч нь 1.6 (1+60%) байна. Энэ хоёр үржүүлэгчийн дундаж нь 1.1 бөгөөд энд эдийн засгийн тогтвортой үеийн үржүүлэгчийг ашигласан.

Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг шинжээчийн дүгнэлтийг ашиглан жинлэх бөгөөд үзүүлэлт бүрийг ирээдүйн чиг хандлагад үндэслэн холбогдох үржүүлэгчээр үржүүлнэ. Банк нь Монгол улсын эдийн засгийн ерөнхий нөхцөл, бизнесийн орчинд тулгуурлан шинжээчийн дүгнэлтийг ашиглан суурь хувилбар, дээд хувилбар, доод хувилбар гаргах ба 3 хувилбарыг тохиолдох магадлалаар нь жинлэдэг. Банк цар тахлын дараах байдлыг тусгайлан авч үзсэн хувилбаруудын шинжилгээ хийж, улсын жинлэсэн таамаглалуудад чухал томоохон үйл явдлуудыг оруулсан.

Өрийн бичиг, бусад банкнуудад байршуулсан хөрөнгө зэрэг зээлээс бусад хөрөнгүүдэд Мүүди`с-ийн үнэлгээний тайлан болон дефолт мэдээллүүдийг ашиглаж ирээдүйг таамагладаг. Тайлан болон мэдээлэл нь харилцагчийн ирээдүйд дефолт болох магадлал, үнэлгээ нь өсөх эсвэл буурах гаргагчийн багц, үнэлгээний ангилал, макро эдийн засгийн ирээдүйд чиглэсэн таамаглалууд, гаргагчийн тусгайлсан мэдээллийн нөхцөлүүд зэрэг үнэлгээнүүдийг тохиолдох магадлалыг агуулдаг.

Банк нь эрсдэлийн тооцоолол болон бодит алдагдал хоёрын хоорондын зөрүүг бага байлгах үүднээс тооцооллын загвар болон таамаглалыг тогтмол хугацаанд эргэн хянадаг. Загвар болон тооцоолол нь зөв эсэх хяналтыг жилд нэгээс багагүй удаа хийдэг.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцооллын загварын эргэн хяналтын үр дүнг Банкны удирдлагуудад хүргүүлдэг бөгөөд хэлэлцүүлгээс гарсан үр дүнд үндэслэн загвар болон тооцоололд шаардлагатай шинэчлэлтүүдийг хийдэг.

**Зах зээлийн эрсдэл.** Банк нь зах зээлийн эрсдэлд өртөх боломжтой хөрөнгүүдийг эзэмшдэг. Зах зээлийн эрсдэлд (а) валютын ханш, (б) хүүний түвшин, (в) өмчийн үнэт цаас, (г) бараа болон (д) бусад санхүүгийн хэрэглүүр (үүнд дериватив орсон) гэх зэрэг эрсдэлүүд ордог бөгөөд эдгээр нь банкны хөрөнгийн нээлттэй позиц болон тухайн хөрөнгөнд нөлөөлөх нийт болон ганцаарчилсан зах зээлийн хөдөлгөөнөөс үүсдэг. Банкны удирдлага зах зээлийн эрсдэлийн гол хэмжигдэхүүнүүдийн хязгаарыг тогтоож, түүнийг өдөр бүр хянах байдлаар зах зээлийн эрсдэлийг удирддаг. Гэсэн хэдий ч, энэ нь зах зээлийн томоохон ач холбогдол бүхий үйл явдлуудын үед хязгаарлалтаас гадуурх алдагдлаас сэргийлэх боломжгүй юм. Иймээс Банк жил бүр хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө шинэчилдэг.

Банк санхүүгийн зах зээлд явуулах үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг дундаж хэмжээнд хүлээн зөвшөөрөх ба энэ нь холбогдох бодлого, журмуудад тусгагддаг. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны эрсдэлийн удирдлагын стратегийг жил бүр тодорхойлж, зах зээлийн эрсдэлийн лимит хязгаарлалтуудыг санхүүгийн хэрэглүүр бүрийн хувьд тогтоодог. Банкны Актив, пассивын удирдлагын хороо нь хүү, гадаад валютын ханшийн эрсдэлд хяналт тавьж, үнэлгээ дүгнэлт өгөх замаар Эрсдэлийн удирдлагын хорооноос баталсан эрсдэлийн лимит, хязгаарлалтуудын биелэлтийг хянадаг ба банкны үйл ажиллагаа болон санхүүгийн нөхцөл байдалд ирээдүйд учрах магадлалтай нөхцөл байдлууд хэрхэн нөлөөлөхийг мөн тодорхойлдог.

Нөөцийн удирдлагын газрын захирал нь банкны активын бүтцийг хянах, хөрөнгө оруулалтын хэрэглүүрүүд болон түүний ангиллыг Эрсдэлийн удирдлагын хороо, Төлөөлөн удирдах зөвлөл болон Актив пассивын удирдлагын хорооноос баталсан бодлого журамд заасны дагуу, зөвшөөрөгдсөн лимит хязгаарлалтын хүрээнд ашиглах замаар зах зээлийн эрсдэлийг өдөр тутамд удирддаг. Эрсдэлийн удирдлагын газар нь зах зээлийн эрсдэлийн удирдлагыг бодлого, хяналтын түвшинд удирдаж Гүйцэтгэх захирал болон Актив пассивын удирдлагын хороонд шууд тайлагнаж ажилладаг.



### 38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

**Гадаад валютын ханшийн эрсдэл.** Зах зээл дээрх гадаад валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан банкны эзэмшиж буй гадаад валютын актив, пассивын үнэ цэнэ өөрчлөгдөж, банкны ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хэмжээнд нөлөөлж байвал гадаад валютын ханшийн эрсдэл гэнэ. Банкны санхүүгийн байдал болон мөнгөн гүйлгээ нь гадаад валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан эрсдэлд өртөмтгий байдаг. Аливаа валютын хувьд ханшийн эрсдэлээс хамгаалаагүй нээлттэй позиц нь банкны гадаад валютын ханшийн эрсдэлийг ихэсгэж байдаг. Гадаад валютын ханшийн эрсдэлийн тухайд удирдлага нь валютын өртөлтийн түвшинг хязгаарлаж, өдрийн болон шөнийн аль алинд нь нийт дүнгээр нь тогтоодог.

Төлөөлөн удирдах зөвлөл нь гадаад валютын ханшийн эрсдэлийн аппетитыг тодорхойлж, нийт валютын хувьд нээлттэй позицын дээд хэмжээ болон гадаад валютын багцын “Хамгийн их эрсдэл”-ийн лимитийг тогтоодог. Банкны Актив пассивын удирдлагын хороо нь ТУЗ-өөс баталсан гадаад валютын ханшийн эрсдэлийн аппетиттай нийцтэй байдлаар валютын арилжааны лимитүүдийг салбар тус бүрийн хувьд тогтоодог.

Банк гадаад валютын нээлттэй позицоос үүсэх ханшийн эрсдэлийг “Хамгийн их эрсдэл”-ийн аргыг ашиглан тооцоолж ажилладаг. Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан, тодорхой хугацааны турш үүсэж болзошгүй хамгийн их эрсдэлийг өгөгдсөн итгэх магадлалын түвшинд вариаци-ковариаци, түүхэн үүсгэвэр болон Монте-карло симуляци гэсэн гурван төрлийн аргачлалыг ашиглан тооцдог.

Хамгийн их эрсдэлийн үнэлгээг нэг болон арван өдрийн хугацааны интервалуудын хувьд тооцож, үнэлгээний үр дүнг бодит эрсдэлтэй харьцуулан өдөр тутамд буцаан шалгаж, баталгаажуулж ажилладаг. Монголбанкны дүрэм, журмын дагуу банк хамгийн их эрсдэлийн үнэлгээг 10 өдрөөр, 99 хувийн итгэх магадлалын түвшинд тооцоолж байна. Хамгийн их эрсдэлийн аргачлалаас гадна зах зээлийн онцгой нөхцөл байдалд үүсэж болзошгүй хүлээгдээгүй эрсдэлийг илрүүлэх зорилгоор стресс тестийг тогтмол хийж гүйцэтгэдэг.

Гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдахдаа банк дараах стратегиудыг баримталдаг. Үүнд:

- Гадаад валютын актив, пассивын зөрүүг тохируулах;
- Гадаад валютын своп, форвард хэлцэлүүд зэрэг санхүүгийн үүсмэл хэрэглүүрүүдийг ашиглан хеджинг хийх;
- Ахиуц болон нийлмэл “Хамгийн их эрсдэл”-ийг ашиглан гадаад валютын багцад диверсификаци хийх;

Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан валютын зээлүүд чанаргүйдэх шууд бус эрсдэл нь зээлдэгчийн орлогын эх үүсвэр ямар валютаар илэрхийлэгдэхээс шалтгаалдаг. Зээл олгогдсон валют нь харилцагчийн орлогын эх үүсвэрийн валютаас ялгаатай байх тохиолдолд зах зээл дээрх валютын ханшийн хэлбэлзэл зээлдэгчийн зээлээ эргэн төлөх чадварт сөргөөр нөлөөлж, улмаар зээл чанаргүйдэхэд хүргэх магадлалтай. Зээлийн багцад эзлэх гадаад валютын ханшийн эрсдэлтэй зээлийн хувь хэмжээ нь тодорхой эрсдэлийн лимиттэй ба уг лимитийг зах зээлийн нөхцөл байдал болон банкны бизнес төлөвлөгөөнөөс хамаарч тогтмол шинэчилдэг.

### 38 Санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

2022 оны 12 сарын 31-ний өдрийн Банкны гадаад валютын ханшийн эрсдэлийг доорх хүснэгтээр харуулав. Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг мөнгөн тэмдэгтээр ангилж дансны үнээр нь хүснэгтэд оруулсан болно.

Мянган төгрөгөөр	Төгрөг	Ам.доллар	Евро	Бусад	Нийт дүн
<b>Санхүүгийн мөнгөн хөрөнгө</b>					
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	798,739,886	143,544,872	63,356,714	136,762,618	<b>1,142,404,090</b>
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөц	110,266,796	247,315,162	-	-	<b>357,581,959</b>
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	1,954,809	1,475,505,273	9,542,401	79,960,896	<b>1,566,963,380</b>
Өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	917,160,109	313,090,900	-	-	<b>1,230,251,009</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	3,451,538,853	227,028,816	18,562,835	502,841	<b>3,697,633,345</b>
Бусад санхүүгийн хөрөнгө	26,367,271	1,197,605	91,116	121,073	<b>27,777,065</b>
<b>Нийт санхүүгийн мөнгөн хөрөнгө</b>	<b>5,306,027,725</b>	<b>2,407,682,628</b>	<b>91,553,066</b>	<b>217,347,428</b>	<b>8,022,610,847</b>
<b>Санхүүгийн мөнгөн өр төлбөр</b>					
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	40,411,791	9,693,059	1,444,341	845,572	<b>52,394,763</b>
Харилцагчийн харилцах, хадгаламж	3,422,863,051	2,038,233,479	79,220,034	202,981,303	<b>5,743,297,867</b>
- Харилцах	1,578,690,458	985,660,916	47,332,381	146,381,199	<b>2,758,064,954</b>
- Хугацаагүй хадгаламж	210,674,967	173,810,898	13,338,848	28,011,258	<b>425,835,971</b>
- Хугацаатай хадгаламж	1,633,497,626	878,761,665	18,548,804	28,588,847	<b>2,559,396,942</b>
Зээлийн бусад эх үүсвэр	480,966,640	1,419,768,033	12,034,996	3,542,423	<b>1,916,312,092</b>
Репө хэлцэл	169,906,728	41,440,916	-	-	<b>211,347,644</b>
Бусад санхүүгийн өр төлбөр	92,502,571	19,654,679	608,318	2,346,723	<b>115,112,290</b>
<b>Нийт санхүүгийн мөнгөн өр төлбөр</b>	<b>4,206,650,781</b>	<b>3,528,790,166</b>	<b>93,307,689</b>	<b>209,716,021</b>	<b>8,038,464,657</b>
<b>Хасах: Үүсмэл санхүүгийн хэрэглүүр</b>	<b>1,850,331,536</b>	<b>(1,396,926,319)</b>	<b>(1,504,298)</b>	<b>(15,754,810)</b>	<b>436,146,109</b>
<b>Балансын цэвэр позиц</b>	<b>(750,954,593)</b>	<b>275,818,781</b>	<b>(250,325)</b>	<b>23,386,217</b>	<b>(451,999,919)</b>

### 38 Санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

2021 оны 12 сарын 31-ний өдрийн Банкны гадаад валютын ханшийн эрсдэлийг доорх хүснэгтээр харуулав. Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг мөнгөн тэмдэгтээр ангилж дансны үнээр нь хүснэгтэд оруулсан болно.

Мянган төгрөгөөр	Төгрөг	Ам.доллар	Евро	Бусад	Нийт дүн
<b>Санхүүгийн мөнгөн хөрөнгө</b>					
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	398,658,886	112,343,712	72,387,693	111,564,129	<b>694,954,420</b>
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөц	103,049,223	174,294,299	-	-	<b>277,343,522</b>
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	277,780	1,025,893,867	5,419,997	24,855,866	<b>1,056,447,510</b>
Өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө	1,730,103,753	249,336,121	-	-	<b>1,979,439,874</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	3,051,668,849	281,385,043	5,497,209	623,736	<b>3,339,174,837</b>
Бусад санхүүгийн хөрөнгө	13,858,937	878,296	32,621	16,193	<b>14,786,047</b>
<b>Нийт санхүүгийн мөнгөн хөрөнгө</b>	<b>5,297,617,428</b>	<b>1,844,131,338</b>	<b>83,337,520</b>	<b>137,059,924</b>	<b>7,362,146,210</b>
<b>Санхүүгийн мөнгөн өр төлбөр</b>					
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	4,345,002	2,860,080	6,735,488	2,841,966	<b>16,782,536</b>
Харилцагчийн харилцах, хадгаламж	3,625,506,653	1,635,067,951	69,814,277	133,154,509	<b>5,463,543,390</b>
- Харилцах	1,070,156,813	632,062,524	37,735,464	62,963,017	<b>1,802,917,818</b>
- Хугацаагүй хадгаламж	493,188,691	271,708,081	14,878,943	43,703,433	<b>823,479,148</b>
- Хугацаатай хадгаламж	2,062,161,149	731,297,346	17,199,870	26,488,059	<b>2,837,146,424</b>
Зээлийн бусад эх үүсвэр	376,409,825	1,126,808,275	6,227,927	-	<b>1,509,446,027</b>
Репо хэлцэл	221,912,121	-	-	-	<b>221,912,121</b>
Бусад санхүүгийн өр төлбөр	56,128,093	2,812,000	771,387	2,061,518	<b>61,772,998</b>
<b>Нийт санхүүгийн мөнгөн өр төлбөр</b>	<b>4,284,301,694</b>	<b>2,767,548,306</b>	<b>83,549,079</b>	<b>138,057,993</b>	<b>7,273,457,072</b>
<b>Хасах: Үүсмэл санхүүгийн хэрэглүүр</b>	<b>1,306,097,206</b>	<b>(1,091,250,102)</b>	<b>(9,991,269)</b>	<b>4,061,224</b>	<b>208,917,059</b>
<b>Балансын цэвэр позиц</b>	<b>(292,781,472)</b>	<b>167,833,132</b>	<b>9,779,710</b>	<b>(5,059,290)</b>	<b>(120,227,920)</b>

Бусад бүх хувьсах хүчин зүйлс тогтмол үед Банкны бүртгэлийн валюттай холбоотой тайлант хугацааны эцсийн ханшийн харьцангуй боломжит өөрчлөлтийн Банкны ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөнд үзүүлэх мэдрэмтгий байдлыг доорх хүснэгтэнд тусгав:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Ам.доллар 15%-аар чангарахад (2021: 15%-аар чангарахад)	41,372,817	25,174,970
Ам.доллар 15%-аар сулрахад (2021: 15%-аар сулрахад)	(41,372,817)	(25,174,970)
Евро 15%-аар чангарахад (2021: 15%-аар чангарахад)	(37,549)	1,466,957
Евро 15%-аар сулрахад (2021: 15%-аар сулрахад)	37,549	(1,466,957)
Бусад валют 15%-аар чангарахад (2021: 15%-аар чангарахад)	3,507,933	(758,894)
Бусад валют 15%-аар сулрахад (2021: 15%-аар сулрахад)	(3,507,933)	758,894

### 38 Санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

**Хүүний түвшний эрсдэл.** Банкны санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээ нь зах зээлийн хүүний түвшний хэлбэлзлийн нөлөөнд өртдөг. Ийм хэлбэлзлийн үр дүнд хүүгийн ахиуц ашгийн хэмжээ нэмэгдэх магадлалтай боловч гэнэтийн өөрчлөлт үүсэх тохиолдолд алдагдал буурах эсвэл эсрэгээрээ нэмэгдэх ч боломжтой. Банкны хүүний эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь хүүний түвшний эрсдэлийн нөлөөллийг хязгаарлаж, хүүний түвшний эрсдэлийг удирдах замаар хүүгийн цэвэр орлого цаашлаад ашигт байдлыг нэмэгдүүлэх юм.

Банк хүүгийн эрсдэлд өртөж болзошгүй үндсэн шалтгаан нь татсан эх үүсвэрээс өөр ялгаатай дүн ба хугацаагаар, тогтмол хүүтэйгээр зээл олгох үйл ажиллагаатай холбоотой. Практик дээр богино хугацаанд хүү тогтмол байдаг. Мөн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг бодитой тусгахын тулд хөрөнгө болон өр төлбөрийн гэрээгээр тохиролцсон тогтмол хүүг дахин тохиролцох, өөрчлөх шаардлага үүсдэг. Банк боломжит хүүгийн эрсдэлийг тооцон хяналт тавьж, хүүгийн эрсдэлийг удирдах, бууруулахын тулд лимит тогтоох замаар хүүгийн эрсдэлийг удирддаг. Зөрүүгийн анализ (удирдлагын дүнтэй таарахгүй байх), хугацааны анализ (жинлэсэн дундаж дуусгавар болох хугацааны анализ) ба хүүгийн орлогын симуляци зэрэг аргыг хүүгийн эрсдэлийн түвшнийг тодорхойлоход ашигладаг. Үүнээс гадна банк нь хүүгийн зөрүүний менежмент, хүүгийн эрсдэлийн хэджинг, тогтоогдсон лимитийг дагаж мөрдөх замаар эрсдэлийг удирдаж бууруулдаг. Хүүгийн лимитийн процесс нь дараах зүйлсийг багтаадаг, үүнд (i) алдагдлын дээд лимит, (ii) хүүгийн зөрүүний лимит (iii) эх үүсвэрийг байршуулах хүүгийн хамгийн бага түвшин.

Банкны Актив Пассивын Удирдлагын Хороо хүүгийн түвшний зөрүүний өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэмжээнд лимит тогтоодог ба тогтмол хяналт тавьдаг. Хэджинг хийх боломжтой хэрэглүүр байхгүй тохиолдолд Банк нь өөрийн хүүгийн позицийг зөрүүгүй байлгахыг эрмэлздэг.

Бусад бүх хувьсагчийг тогтмол байна гэж үзвэл 2022 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар хүүгийн түвшин 10%-аар их/(бага) (2021: 10%-аар их/бага) байсан тохиолдолд тухайн жилийн ашиг алдагдал, өөрийн хөрөнгө нь 45,199,992 мянган төгрөг (2021: 12,022,792 мянган төгрөг)-өөр их/(бага) байх байсан. Үүний үндсэн шалтгаан нь 2022 оны өндөр түвшний хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү ба хүүгийн хувь хэмжээний өөрчлөлт байсан юм.

Тайлант хугацааны эцэс дэх Банкны хүүгийн түвшний эрсдэлийн дүн нь тухайн жилийн эрсдэлийн дүнгийн илэрхийлэл болохгүй. 2022 оны дундаж үлдэгдлийн хувьд бусад бүх хувьсагчийг тогтмол байна гэж үзвэл хүүгийн түвшин 10%-аар их/(бага) байсан тохиолдолд 2022 оны санхүүгийн үр дүн 28,611,392 мянган төгрөгөөр их/(бага) (2021: 18,318,333 мянган төгрөгөөр их (бага)) байх байсан.

**38 Санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

Доорх хүснэгтэнд Банкны хүүгийн түвшний эрсдэлийн өртөх байдлыг хураангуйлан үзүүлэв. Энэхүү хүснэгтэнд банкны хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийн нийлбэр дүнг хүүнд өөрчлөлт орох хугацаа эсвэл дуусгавар болох хугацааны аль өмнөх хугацаагаар нь ангилан үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Хугацаагүй болон 1- ээс бага сар</b>	<b>1 – 6 сар</b>	<b>6 – 12 сар</b>	<b>1 – 5 жил</b>	<b>5-аас дээш жил</b>	<b>Нийт дүн</b>
<b>2022 оны 12 сарын 31</b>						
Нийт санхүүгийн хөрөнгө	2,919,044,942	387,143,468	1,233,198,802	2,736,831,511	1,205,051,725	<b>8,481,270,447</b>
Нийт санхүүгийн өр төлбөр	834,574,091	993,344,526	2,688,319,305	1,793,902,650	1,728,324,084	<b>8,038,464,657</b>
<b>2022 оны 12 сарын 31-наарх хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү</b>						
	<b>2,084,470,851</b>	<b>(606,201,059)</b>	<b>(1,455,120,503)</b>	<b>942,928,861</b>	<b>(523,272,360)</b>	<b>442,805,790</b>
<b>2021 оны 12 сарын 31</b>						
Нийт санхүүгийн хөрөнгө	3,048,499,566	327,436,262	278,677,822	3,034,273,141	882,176,478	<b>7,571,063,269</b>
Нийт санхүүгийн өр төлбөр	3,247,133,163	1,331,391,289	1,329,493,839	1,329,854,205	35,584,576	<b>7,273,457,072</b>
<b>2021 оны 12 сарын 31-наарх хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү</b>						
	<b>(198,633,597)</b>	<b>(1,003,955,027)</b>	<b>(1,050,816,017)</b>	<b>1,704,418,936</b>	<b>846,591,902</b>	<b>297,606,197</b>

### 38 Санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

Банк нь өөрийн санхүүгийн хэрэглүүрийн хүүгийн түвшинд тогтмол хяналт тавьдаг. Доорх хүснэгтэнд эрх бүхий албан ажилтнуудын хянасан тайлангуудад үндэслэн холбогдох тайлант хугацааны хүүгийн түвшнийг хураангуйлан үзүүлэв. Үнэт цаасны хувьд хүүгийн хувь нь тайлант хугацааны зах зээлийн үнэлгээнд үндэслэн гаргасан дуусгавар болох хугацаа хүртэлх өгөөжийн хувийг хэлнэ:

Хувиар	2022 оны 12 сарын 31				2021 оны 12 сарын 31			
	Төгрөг	Ам.дол	Евро	Бусад	Төгрөг	Ам.дол	Евро	Бусад
<b>Хөрөнгө</b>								
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөц	5.5%	0.0%	0.0%	0.0%	2.50%	-	-	-
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	0.0%	1.2%	0.0%	0.0%	-	1.40%	-	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	13.2%	7.9%	8.6%	7.2%	12.30%	7.90%	6.20%	6.40%
Өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	12.1%	6.5%	0.0%	0.0%	6.30%	6.20%	-	-
<b>Өр төлбөр</b>								
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	10.9%	0.0%	0.0%	0.0%	3.90%	-	2.50%	-
Харилцагчийн харилцах, хадгаламж								
- Харилцах данс	0.0%	0.0%	0.0%	0.0%	-	-	-	-
- Хугацаагүй хадгаламж	0.0%	0.0%	0.0%	0.0%	1.40%	0.50%	0.30%	0.10%
- Хугацаатай хадгаламж	9.8%	2.5%	1.3%	1.7%	7.30%	2.20%	1.30%	1.60%
РЕПО хэлцэл	6.1%	8.0%	0.0%	0.0%	6.10%	-	-	-
Зээлийн бусад эх үүсвэр	7.6%	2.7%	5.6%	3.9%	6.90%	2.20%	2.10%	-

Дээрх хүснэгтийн “-” тэмдэг нь Банкинд холбогдох валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө эсвэл өр төлбөр байхгүйг илтгэнэ.

**Бусад үнийн эрсдэл.** Банк нь хувьцааны үнийн эрсдэлд өртөх магадлалыг хязгаарладаг. Өөрийн хөрөнгийн бүтээгдэхүүнд хийгдэх арилжааг Банкны нөөцийн удирдлага хянаж, зөвшөөрдөг. Бусад бүх хувьсагчийг тогтмол гэж үзэхэд 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хэрэв тухайн үеийн өөрийн хөрөнгийн үнэ 15%, (2021: 15%)-аар их (бага) байсан тохиолдолд жилийн ашиг болон өөрийн хөрөнгө нь 3,315,528 мянган төгрөг (2021: 2,689,178 мянган төгрөг)-өөр их (бага) байх байсан.

Банк зээлдэгчдэд зээлийн эргэн төлөлтийг урьдчилан төлөх эрх олгосон орон сууцны зээл гэх мэт тогтмол, хувьсах хүүтэй зээлийг олгодог учир урьдчилсан төлөлтийн эрсдэлд өртдөг. Банкны тайлант үеийн ашиг, алдагдал ба жилийн эцсийн өөрийн хөрөнгийн дүнд урьдчилсан төлөлтийн өөрчлөлт нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй. Учир нь эдгээр зээл хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг ба урьдчилсан төлөлтийн нөлөө нь зээл ба урьдчилгааны хорогдуулсан өртөгтэй ижил эсвэл ойролцоо дүнгээр тооцогддог. (2021: материаллаг нөлөө байхгүй).

**Бүс нутгийн төвлөрлийн эрсдэл.** Банкны бараг бүх санхүүгийн хөрөнгө буюу зээлтэй холбоотой үүрэг бүхий хөрөнгүүд 2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсад байршсан тул Банк бүс нутгийн төвлөрлийн эрсдэлд өртөх магадлалгүй байна. 2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банкны санхүүгийн өр төлбөрийн ихэнх нь Монгол улстай хамааралтай байсан. Банкны бүс нутгийн төвлөрлийн эрсдэлийг харилцагчдын болон салбарын төрөлжүүлэлтээр бууруулж байгаа гэж удирдлага үзэж байгаа болно.

### 38 Санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

**Бусад төвлөрлийн эрсдэл.** Хэд хэдэн гэрээлэгч талууд нь ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаанд оролцдог эсвэл нэг газарзүйн байршилд үйл ажиллагаа явуулдаг эсвэл эдийн засаг, улс төр ба бусад нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх чадварт нь ижил төстэй нөлөө үзүүлэх бизнесийн ижил төстэй шинж чанартай үед төвлөрөл үүсдэг.

Төвлөрлийн түвшин нь аль нэг салбар эсвэл газарзүйн байршлын нөхцөл байдалд нөлөө үзүүлэгч хүчин зүйлүүд нь Банкны үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлж болохыг хэмждэг.

Хэт өндөр төвлөрлийн эрсдэлээс зайлсхийхийн тулд диверсификаци өндөртэй хөрөнгийн багцтай байх талаар нарийн, тодорхой бодлого журмыг Банкнаас тодорхойлж өгсөн байдаг. Зээлийн эрсдэлийн төвлөрлийг тодорхойлж, тохирох эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Монголбанкнаас дараах лимитийг тогтоож өгдөг. i. Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй; ii. Банкнаас холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас тус тус хэтэрч болохгүй;

Олгогдсон зээлийн эрсдэлийн тайлангуудаар дамжуулан удирдлагын зүгээс эрсдэлд хяналт тавьдаг ба эрсдэлийн төвлөрлийг мэдээлдэг. Салбарын төвлөрлийн эрсдэл зэрэг төвлөрлийн эрсдэлийн талаарх мэдээллийг Тодруулга 12-т тусгасан.

**Төлбөрийн чадварын эрсдэл.** Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг нь байгууллагын хувьд санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд нь хүндрэл гарах үед үүсэх эрсдэлийг хэлдэг. Хоногийн хугацаатай хадгаламж, харилцах данс, хугацаа нь дуусгавар болж буй хадгаламжууд, зээлийн ашиглалт, баталгаа батлан даалт болон бэлэн мөнгөөр тооцоо хийдэг санхүүгийн үүсмэл хэрэглүүрүүдтэй холбоотойгоор бэлэн мөнгөний гарах урсгалын хэрэгцээ Банкны хувьд өдөр бүр гарч байдаг. Хугацаа нь дуусгавар болж буй эх үүсвэрийн тодорхой хувь нь гадагшлахгүй, хугацаа нь сунгагдах магадлал маш өндөр болохыг туршлагаас тогтоосон тул мөнгөний гарч болзошгүй гадагшаа урсгалын нийт дүнд хүрэлцэхүйц бэлэн мөнгөний нөөцийг Банкинд байнга хадгалдаггүй.

Банкны төлбөрийн чадварын эрсдэлийн удирдлага нь төлбөрийн чадварын эрсдэлийг хугацаагаар нь ангилан нэгтгэдэг бөгөөд хэвийн болон стресстэй нөхцөл байдалд богино ба дунд хугацааны төлбөрийн үүргээ биелүүлэх чадвартай байхаар хөрвөх чадварыг удирддаг. Төлбөрийн чадварын удирдлагыг банкны дотоод шаардлага болон таамаглалд үндэслэн бүх газар нэгж болон салбаруудаар дамжуулан Нөөцийн удирдлагын газраас бодит цаг хугацаанд авч хэрэгжүүлдэг. Томоохон хэмжээний зээл бүртэй холбоотой шийдвэр, түүний төлбөрийн чадварт үзүүлэх нөлөөг Нөөцийн удирдлагын газрын захиралтай хэлэлцэж зөвлөлддөг. ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо нь зохицуулагч байгууллагуудын тавьсан шаардлага болон олон улсын стандартын дагуу төлбөрийн чадварын эрсдэлийн удирдлагын стандартыг тогтоосноор банкны төлбөрийн чадварын эрсдэлийн удирдлагын иж бүрэн тогтолцоог бүрдүүлдэг. Төлбөрийн чадварын эрсдэлийн иж бүрэн үнэлгээний нэг хэсэг болгож Актив пассивын удирдлагын хороо нь дараах хүчин зүйлсийн үзүүлэх нийт нөлөөг тооцоолж, хяналт тавьдаг, үүнд: (i) богино ба дунд хугацааны бэлэн мөнгөний менежмент; (ii) санхүүгийн чадавх сайтай тайлан тэнцэл, баланстай байх; (iii) гадаад валютын төлбөрийн чадварын менежмент; (iv) санхүүжилтийн эх үүсвэрийн диверсификаци өндөр байх; (v) хөрвөх чадварын стресс тест тогтмол хийх; ба (vi) төлбөрийн чадварын эрсдэл учирсан тохиолдолд хэрэгжүүлэх үр дүнтэй төлөвлөгөөтэй байх.

**38 Санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

Банк Монголбанкны шаардлагыг хангахын тулд төлбөрийн чадварын харьцааг өдөр бүр тооцоолдог. Тайлант хугацааны төлбөрийн чадварын харьцаа дараах байдалтай байна:

	<b>2022</b>	<b>2021</b>
	<b>36.29%</b>	<b>41.30%</b>
Тайлант жилийн дундаж	36.40%	39.24%
Хамгийн их	41.30%	44.85%
Хамгийн бага	32.41%	34.75%

Банк төлбөрийн чадварын стресс тест хийдэг. Гэнэтийн болон хүчтэй стрессийн үйл явдлыг тодорхойлох, эдийн засгийн цочролын дараа ч хангалттай хөрвөх чадварыг хангах зорилгоор, Эрсдэлийн аппетитийн тунхаглалд төлбөрийн чадварын үзүүлэлтэд нэмэх төлбөрийн чадварын үзүүлэлтүүдийг мөн тодорхой эрсдэлийн босгыг тогтоох эрсдэлийн хязгаарыг тодорхойлдог.

Доорх хүснэгтэнд 2022 оны 12 сарын 31 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хөрөнгө ба өр төлбөрийн дүнг гэрээгээр дуусгавар болоход үлдсэн хугацаагаар нь ангилан үзүүлэв.

Эргэн төлөгдөх хугацааны хүснэгтэнд тайлагнагдсан өр төлбөрийн дүн нь гэрээний дагуу хямдруулаагүй мөнгөн гүйлгээ юм, үүнд санхүүгийн нийт түрээсийн үүрэг (ирээдүйн санхүүгийн төлбөрийг хасахаас өмнө), нийт зээл олгохоор хүлээсэн үүрэг, санхүүгийн баталгаа зэргийг хэлнэ. Ийм хямдруулаагүй мөнгөн гүйлгээ нь санхүүгийн байдлын тайлан дахь дүнгээс ялгаатай байдаг, учир нь санхүүгийн байдлын тайлангийн дүн нь дискаунтчилсан мөнгөн гүйлгээнд үндэслэсэн. Санхүүгийн дериватив нь дуусгавар болох өдрөөс өмнө позицыг хаахаар төлөвлөөгүй тохиолдолд гэрээний дагуу хүлээгдэж буй мөнгөн урсгалд үндэслэх ба хэрэв урьдчилж хаахаар төлөвлөсөн бол деривативууд нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнд суурилж тооцоологдоно. Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээний зорилгоор нуугдмал деривативыг холимог (нийлмэл) санхүүгийн хэрэглүүрээс салгахгүй.



### 38 Санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар гэрээгээр хүлээсэн үүргийн хорогдуулаагүй дүнд суурилсан санхүүгийн хэрэглүүрүүдийн дуусгавар болох хугацааны шинжилгээ нь дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Хугацаагүй болон 1-ээс бага сар	1 – 6 сар	6 – 12 сар	1 – 5 жил	5-аас дээш жил	Нийт дүн
<b>Хөрөнгө</b>						
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	1,142,404,090	-	-	-	-	<b>1,142,404,090</b>
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөц	357,581,959	-	-	-	-	<b>357,581,959</b>
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	496,301,297	17,666,653	367,619,425	705,577,121	-	<b>1,587,164,496</b>
Өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	649,928,095	69,197,301	51,345,446	290,582,375	561,187,488	<b>1,622,240,705</b>
Өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	22,513,491	-	-	-	-	<b>22,513,491</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	262,512,703	474,848,723	855,769,304	1,942,840,163	1,523,701,208	<b>5,059,672,102</b>
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	8,374,137	111,840	124,460,563	303,199,569	-	<b>436,146,109</b>
- орох урсгал	37,432,781	21,706,244	235,225,696	382,752,526	-	<b>677,117,246</b>
- гарах урсгал	(29,058,644)	(21,594,404)	(110,765,133)	(79,552,957)	-	<b>(240,971,137)</b>
Бусад санхүүгийн хөрөнгө	26,033,454	160,839	1,553,352	29,419	-	<b>27,777,065</b>
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>2,965,649,225</b>	<b>561,985,356</b>	<b>1,400,748,092</b>	<b>3,242,228,648</b>	<b>2,084,888,696</b>	<b>10,255,500,017</b>
<b>Өр төлбөр</b>						
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	52,394,763	-	-	-	-	<b>52,394,763</b>
Харилцагчийн харилцах, хадгаламж	579,131,098	891,899,646	2,075,749,166	586,396,648	1,695,157,736	<b>5,828,334,294</b>
- Харилцах	412,668,916	154,132,550	407,713,198	315,114,164	1,468,436,127	<b>2,758,064,955</b>
- Хугацаагүй хадгаламж	63,714,695	23,797,548	62,949,549	48,652,569	226,721,609	<b>425,835,971</b>
- Хугацаатай хадгаламж	102,747,487	713,969,548	1,605,086,419	222,629,915	-	<b>2,644,433,369</b>
Зээлийн бусад эх үүсвэр	91,422,666	13,384,359	598,298,221	1,308,603,844	44,317,685	<b>2,056,026,775</b>
РЕПО хэлцэл	-	97,661,680	101,772,659	20,331,109	-	<b>219,765,448</b>
Бусад санхүүгийн өр төлбөр	111,977,417	1,490,164	1,576,278	68,430	-	<b>115,112,290</b>
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>834,925,944</b>	<b>1,004,435,850</b>	<b>2,777,396,325</b>	<b>1,915,400,031</b>	<b>1,739,475,421</b>	<b>8,271,633,570</b>
<b>Зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг</b>	<b>254,480,934</b>	<b>156,064,537</b>	<b>142,626,109</b>	<b>364,132,953</b>	<b>34,151,519</b>	<b>951,456,052</b>
Батлан даалт, аккредитив	235,738,535	92,130,009	75,165,080	236,909,716	26,651,519	<b>666,594,859</b>
Зээлийн шугам	18,742,399	63,934,528	67,461,029	127,223,237	7,500,000	<b>284,861,192</b>
<b>Цэвэр зөрүү</b>	<b>1,876,242,348</b>	<b>(598,515,030)</b>	<b>(1,519,274,342)</b>	<b>962,695,664</b>	<b>311,261,756</b>	<b>1,032,410,396</b>
<b>Хуримтлагдсан цэвэр зөрүү</b>	<b>1,876,242,348</b>	<b>1,277,727,318</b>	<b>(241,547,024)</b>	<b>721,148,640</b>	<b>1,032,410,396</b>	

### 38 Санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар гэрээгээр хүлээсэн үүргийн хорогдуулаагүй дүнд суурилсан санхүүгийн хэрэглүүрүүдийн дуусгавар болох хугацааны шинжилгээ нь дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Хугацаагүй болон 1-ээс бага сар	1 – 6 сар	6 – 12 сар	1 – 5 жил	5-аас дээш жил	Нийт дүн
<b>Хөрөнгө</b>						
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	694,954,420	-	-	-	-	<b>694,954,420</b>
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөц	277,343,522	-	-	-	-	<b>277,343,522</b>
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	184,047,153	14,300,325	-	888,345,713	-	<b>1,086,693,191</b>
Өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	1,566,822,339	-	-	296,829,963	444,243,786	<b>2,307,896,088</b>
Өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	18,472,715	-	-	-	-	<b>18,472,715</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	455,799,235	456,893,494	419,523,402	2,090,693,824	1,099,786,578	<b>4,522,696,533</b>
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	(104,167)	(7,431,353)	(6,424,684)	222,877,263	-	<b>208,917,059</b>
Бусад санхүүгийн хөрөнгө	12,812,854	179,622	1,793,121	450	-	<b>14,786,047</b>
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>3,210,148,071</b>	<b>463,942,088</b>	<b>414,891,839</b>	<b>3,498,747,213</b>	<b>1,544,030,364</b>	<b>9,131,759,575</b>
<b>Өр төлбөр</b>						
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	16,828,232	-	-	-	-	<b>16,828,232</b>
Харилцагчийн харилцах, хадгаламж	3,053,982,078	1,319,718,370	964,045,347	111,425,056	-	<b>5,449,170,851</b>
- Харилцах	1,802,917,818	-	-	-	-	<b>1,802,917,818</b>
- Хугацаагүй хадгаламж	741,301,580	93,239	1,826	-	-	<b>741,396,645</b>
- Хугацаатай хадгаламж	509,762,679	1,319,625,131	964,043,521	111,425,056	-	<b>2,904,856,387</b>
Зээлийн бусад эх үүсвэр	27,223,376	31,801,846	412,928,340	1,086,119,303	45,253,664	<b>1,603,326,529</b>
РЕПО хэлцэл	-	-	19,999,557	194,997,543	-	<b>214,997,100</b>
Бусад санхүүгийн өр төлбөр	61,205,602	243,358	323,572	465	-	<b>61,772,997</b>
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>3,159,239,287</b>	<b>1,351,763,574</b>	<b>1,397,296,816</b>	<b>1,392,542,397</b>	<b>45,253,664</b>	<b>7,346,095,708</b>
<b>Зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг</b>	<b>284,471,852</b>	<b>97,635,825</b>	<b>159,544,321</b>	<b>237,546,499</b>	<b>49,061,877</b>	<b>828,260,374</b>
Батлан даалт, аккредетив	240,619,656	56,879,461	92,607,512	167,515,830	49,061,877	<b>606,684,336</b>
Зээлийн шугам	43,852,196	40,756,364	66,936,809	70,030,669	-	<b>221,576,038</b>
<b>Цэвэр зөрүү</b>	<b>(233,563,068)</b>	<b>(985,457,311)</b>	<b>(1,141,949,298)</b>	<b>1,868,658,347</b>	<b>1,449,714,824</b>	<b>957,403,494</b>
<b>Хуримтлагдсан цэвэр зөрүү</b>	<b>(233,563,068)</b>	<b>(1,219,020,379)</b>	<b>(2,360,969,677)</b>	<b>(492,311,330)</b>	<b>957,403,494</b>	

### 38 Санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

Банк нь дээр үзүүлсэн өр төлбөрийн гэрээгээр дуусах хугацааны хорогдуулаагүй дүнгийн хугацааны шинжилгээг хөрвөх чадварыг удирдахдаа ашигладаггүй. Үүний оронд Банк нь хүлээгдэж буй дуусгавар болох хугацаа болон хүлээгдэж буй бэлэн мөнгөний хэрэгцээний зөрүүнд хяналт тавьдаг. 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн хэрэглүүрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг доор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Хугацаагүй болон 1-ээс бага сар	1 – 6 сар	6 – 12 сар	1 – 5 жил	5-аас дээш жил	Нийт дүн
<b>Хөрөнгө</b>						
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	1,142,404,090	-	-	-	-	<b>1,142,404,090</b>
Монголбанкинд байршуулсан,заавал байлгах нөөц	357,581,959	-	-	-	-	<b>357,581,959</b>
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	496,299,115	17,514,992	361,694,333	691,454,940	-	<b>1,566,963,380</b>
Өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	647,154,123	65,886,629	47,296,496	249,126,417	220,787,343	<b>1,230,251,009</b>
Өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	22,513,491	-	-	-	-	<b>22,513,491</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	218,684,574	303,469,167	698,194,057	1,493,021,165	984,264,381	<b>3,697,633,345</b>
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	8,374,137	111,840	124,460,563	303,199,569	-	<b>436,146,109</b>
- орох урсгал	37,432,781	21,706,244	235,225,696	382,752,526	-	<b>677,117,246</b>
- гарах урсгал	(29,058,644)	(21,594,404)	(110,765,133)	(79,552,957)	-	<b>(240,971,137)</b>
Бусад санхүүгийн хөрөнгө	26,033,454	160,839	1,553,352	29,419	-	<b>27,777,065</b>
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>2,919,044,942</b>	<b>387,143,468</b>	<b>1,233,198,802</b>	<b>2,736,831,511</b>	<b>1,205,051,725</b>	<b>8,481,270,447</b>
<b>Өр төлбөр</b>						
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	52,394,763	-	-	-	-	<b>52,394,763</b>
Харилцагчийн харилцах, хадгаламж	579,131,098	891,899,646	2,075,749,166	586,396,648	1,695,157,736	<b>5,828,334,294</b>
- Харилцах	412,668,916	154,132,550	407,713,198	315,114,164	1,468,436,127	<b>2,758,064,954</b>
- Хугацаагүй хадгаламж	63,714,695	23,797,548	62,949,549	48,652,569	226,721,609	<b>425,835,971</b>
- Хугацаатай хадгаламж	102,346,026	705,040,107	1,540,570,978	211,439,831	-	<b>2,559,396,942</b>
Зээлийн бусад эх үүсвэр	91,472,274	13,138,570	577,718,827	1,200,816,073	33,166,348	<b>1,916,312,092</b>
РЕПО хэлцэл	-	95,745,587	97,790,474	17,811,583	-	<b>211,347,644</b>
Бусад санхүүгийн өр төлбөр	111,977,417	1,490,164	1,576,278	68,430	-	<b>115,112,290</b>
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>834,574,091</b>	<b>993,344,526</b>	<b>2,688,319,305</b>	<b>1,793,902,650</b>	<b>1,728,324,084</b>	<b>8,038,464,657</b>
<b>Цэвэр зөрүү</b>	<b>2,084,470,851</b>	<b>(606,201,059)</b>	<b>(1,455,120,503)</b>	<b>942,928,861</b>	<b>(523,272,360)</b>	<b>442,805,790</b>
<b>Хуримтлагдсан цэвэр зөрүү</b>	<b>2,084,470,851</b>	<b>1,478,269,792</b>	<b>23,149,289</b>	<b>966,078,150</b>	<b>442,805,790</b>	

**38 Санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

Банк нь дээр үзүүлсэн өр төлбөрийн гэрээгээр дуусах хугацааны хорогдуулаагүй дүнгийн хугацааны шинжилгээг хөрвөх чадварыг удирдахдаа ашигладаггүй. Үүний оронд Банк нь хүлээгдэж буй дуусгавар болох хугацаа болон хүлээгдэж буй бэлэн мөнгөний хэрэгцээний зөрүүнд хяналт тавьдаг. 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн хэрэглүүрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг доор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Хугацаагүй болон 1-ээс бага сар</b>	<b>1 – 6 сар</b>	<b>6 – 12 сар</b>	<b>1 – 5 жил</b>	<b>5-аас дээш жил</b>	<b>Нийт дүн</b>
<b>Хөрөнгө</b>						
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	694,954,420	-	-	-	-	<b>694,954,420</b>
Монголбанкинд байршуулсан,заавал байлгах нөөц	277,343,522	-	-	-	-	<b>277,343,522</b>
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	184,031,323	14,299,749	-	858,116,438	-	<b>1,056,447,510</b>
Өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	1,563,001,736	-	-	247,159,957	169,278,181	<b>1,979,439,874</b>
Өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	18,472,715	-	-	-	-	<b>18,472,715</b>
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	316,459,876	320,388,245	283,309,386	1,706,119,033	712,898,297	<b>3,339,174,837</b>
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	(104,167)	(7,431,353)	(6,424,685)	222,877,264	-	<b>208,917,059</b>
Бусад санхүүгийн хөрөнгө	12,812,855	179,621	1,793,121	450	-	<b>14,786,047</b>
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>3,066,972,280</b>	<b>327,436,262</b>	<b>278,677,822</b>	<b>3,034,273,142</b>	<b>882,176,478</b>	<b>7,589,535,984</b>
<b>Өр төлбөр</b>						
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	16,782,536	-	-	-	-	<b>16,782,536</b>
Харилцагчийн харилцах, хадгаламж						
- Харилцах	1,802,917,818	-	-	-	-	<b>1,802,917,818</b>
- Хугацаагүй хадгаламж	823,385,220	92,223	1,705	-	-	<b>823,479,148</b>
- Хугацаатай хадгаламж	515,667,293	1,299,414,762	920,529,069	101,535,300	-	<b>2,837,146,424</b>
Зээлийн бусад эх үүсвэр	27,174,694	31,640,946	387,250,923	1,027,794,890	35,584,575	<b>1,509,446,027</b>
РЕПО хэлцэл	-	-	21,388,569	200,523,552	-	<b>221,912,121</b>
Бусад санхүүгийн өр төлбөр	61,205,602	243,358	323,572	466	-	<b>61,772,998</b>
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>3,247,133,162</b>	<b>1,331,391,289</b>	<b>1,329,493,838</b>	<b>1,329,854,208</b>	<b>35,584,575</b>	<b>7,273,457,072</b>
<b>Цэвэр зөрүү</b>	<b>(180,160,882)</b>	<b>(1,003,955,027)</b>	<b>(1,050,816,016)</b>	<b>1,704,418,936</b>	<b>846,591,903</b>	<b>316,078,913</b>
<b>Хуримтлагдсан цэвэр зөрүү</b>	<b>(180,160,882)</b>	<b>(1,184,115,909)</b>	<b>(2,234,931,925)</b>	<b>(530,512,990)</b>	<b>316,078,913</b>	

### 38 Санхүүгийн эрслийн удирдлага (үргэлжлэл)

Борлуулах зорилготой нийт хөрөнгийн багц нь удирдлагаас гаргасан багцын хөрвөх чадварын үнэлгээний дагуу “Хугацаагүй болон 1 сараас бага” хугацааны интервалд орсон.

Банкны үйл ажиллагааг амжилттай удирдах суурь зарчим нь хөрөнгө ба өр төлбөрийн дуусгавар болох хугацаа ба хүүгийн тэнцвэртэй байдал ба/эсвэл хяналттай тэнцвэргүй байдал юм. Банкнуудын хувьд гүйлгээ тодорхойгүй хугацаагаар, олон төрлөөр хийгддэг тул хугацаа ба хүүгийн ямар ч зөрүүгүй байна гэдэг ихэнхдээ маш ховор тохиолдол байдаг. Зөрүүтэй позиц нь үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой боловч алдагдал хүлээх эрсдэлийг мөн ихэсгэх магадлалтай. Банкны хөрвөх чадвар болон хүү ба валютын ханшинд өртөж болзошгүй эрсдэлийг үнэлэхэд хөрөнгө ба өр төлбөрийн дуусгавар болох хугацаа, хэт өндөр биш өртгөөр эх үүсвэрийг орлуулах чадвар нь чухал хүчин зүйлүүд болдог.

Харилцагчдын ихэнх данс нь харилцах данс байдаг хэдий ч хадгаламж эзэмшигчдийн тоо ба төрөл, диверсификацийн түвшин ба Банкны туршлага нь эдгээр данснууд Банкны хувьд урт хугацааны тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр болдог гэж удирдлагын зүгээс үзэж байна.

Баталгаа ба аккредитивын хувьд төлбөрийн чадварын шаардлага нь холбогдох төлбөрийн үүргээс хамаагүй бага байдаг. Учир нь ихэнх тохиолдолд гуравдагч тал нь гэрээнд тусгагдсан эх үүсвэрээ эргүүлэн татахгүй гэж Банкны зүгээс үздэг. Гэрээгээр хүлээсэн санхүүжилт олгох үүргийн нийт хэмжээ нь ирээдүйд шаардагдах бэлэн мөнгөний дүнг заавал илтгэдэггүй. Учир нь эдгээр санхүүжилт олгох үүргүүдийн зарим хэсэг нь олгогдохгүйгээр дуусгавар болдог эсвэл цуцлагддаг.

**Зах зээлийн жишиг хүүгийн шинэчлэлийн нөлөө.** Банк хоорондын зах зээлийн жишиг хүүг (‘IBOR’) шинэчлэх нь зохицуулагчдын нэн тэргүүний зорилт болоод байгаа ба ихэнх IBOR хүүг 2021 оны 12 сарын 31-ний өдрөөс нийтэд мэдээлэхээ зогсоосон бөгөөд зарим ам.долларын LIBOR хүү нь 2023 оны 6 сарын 30-ны өдөр гэхэд нийтлэгдэхээ болино.

Доорх хүснэгтэд 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар жишиг хүү рүү шилжих үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг харууллаа. Жишиг хүү рүү хараахан шилжээгүй байгаа LIBOR-г хүүг зогсоосон өдөөс хойш хугацаа нь дуусч байгаа санхүүгийн хэрэгслийн эрсдэлийг хүснэгтэд үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Ам.долла рын LI- BOR	Евро LIBOR	Нийт дүн
<b>Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр</b>			
Бусад зээлийн эх үүсвэр	92,926,157	5,786,545	<b>98,712,702</b>
<b>Нийт үүсмэл бус санхүүгийн өр төлбөр</b>	<b>92,926,157</b>	<b>5,786,545</b>	<b>98,712,702</b>

Хуучин IBOR-д суурилсан санхүүгийн хэрэглүүрүүдийн тоо хэмжээ багасч байгаа тул Банк дээрх санхүүгийн хэрэглүүрүүдийн хөрвөх чадвар буурах эрсдэлд өртөх магадлалтай.

Энэхүү шилжилт нь банкны дотоод систем, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага болон үнэлгээний загвар болоод холбоотой татвар болон бүртгэлийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулсан. Банк өөрчлөлтийн үйл явцтай холбоотой зах зээлд үүсэж буй нөхцөл байдлыг хянаж тэдгээрийн банкны хөрөнгө, өр төлбөрт тодорхойлогдоогүй нөхцөл байдал эсвэл шилжилтээс үүдэлтэй аливаа эрсдэл үүсэх нөлөөллийн түвшин хянаж ажилласан.

Банк нь олон улсын санхүүгийн байгууллагууд гэх мэт өөрийн харилцагчид болон бусад байгууллагуудтай хамтран IBOR-д суурилсан санхүүгийн хэрэглүүрийг жишиг хүү рүү шилжүүлэх ажлыг хийж байна.

Нэмж дурдахад жишиг хүүгийн шинэчлэлийн хүрээнд өнгөрсөн санхүүгийн жилийн хугацаанд дараах ач холбогдол бүхий арга хэмжээг авч ажилласан:

- Бүх санхүүгийн үүсмэл хэрэгслийн түвшинд хүүг LIBOR буюу 2021 оны 12-р сарын 21-нд татгалзах мэдэгдлийн дагуу амжилттай шилжүүлж;
- Шилжилттэй холбоотой бүх своп хэлцлийн бодит үнэ цэнийг үнэлгээг жишиг хүүгийн аргаар үнэлж ажилласан.

### 39 Капиталын удирдлага

Банк нь өөрийн хөрөнгийг удирдахдаа дараах зорилгуудыг баримталдаг. Үүнд: Монголбанкнаас тавьсан өөрийн хөрөнгийн шаардлагуудыг чанд мөрдөх, харилцагчийн харилцах хадгаламжийн даатгалын системийн дурдсан шаардлагууд, Банкны үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхэд чиглүүлэх мөн Монголбанкны шаардлагын дагуу нийт өөрийн хөрөнгө болон нийт активыг эрсдэлийн шинж чанараар тохируулсан дүнд суурилсан эрсдэлээр жинлэсэн хөрөнгийн харьцааг хамгийн багадаа 13% (2021: 12%) байлгах шалгуурыг ханган ажиллах явдал юм. Монголбанкны журмын дагуу системийн нөлөө бүхий банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаанд 1 хувийн банкны эрсдэл даах чадварыг хамгаалах зориулалт бүхий нөөц интервал нэмэгдсэн. Монголбанкнаас тавьдаг өөрийн хөрөнгийн харьцааны шаардлага хангасан эсэхийг өдөр бүрийн бодит мэдээлэл болон сар бүр өөрсдийн хийсэн тооцооллод үндэслэн Банкны ерөнхий нягтлан бодогч болон Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар хянуулдаг.

Банк нь Банкны ирээдүйн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зах зээлд болоод хөрөнгө оруулагчид, зээлдэгчдийн итгэлийг хадгалан ажиллахын тулд өөрийн хөрөнгийн шаардлагатай түвшинг ханган ажиллах сонирхолтой байна. Монголбанкны тодорхойлсон өөрийн хөрөнгийн шаардлагын дагуу эрсдэлээр жинлэсэн хөрөнгийн харьцаа нь (өөрийн хөрөнгийн харьцаа) заасан хамгийн бага түвшнээс дээгүүр байх ёстой.

Доорх хүснэгт нь Банкны СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн санхүүгийн тайланд үндэслэсэн, Монгол Улсын хууль (Монголбанкны шаардлагын) тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн Банкны өөрийн хөрөнгийн бүтцийг харуулав:

	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1-р зэрэглэлийн хүрэлцээний үзүүлэлт	17.91%	15.04%
Эрсдэлээр жинлэсэн активын харьцаа	17.91%	15.43%
<b>1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө</b>		
Энгийн хувьцаа	202,164,327	168,960,148
Нэмж төлөгдсөн капитал	301,481,120	169,486,044
Хуримтлагдсан ашиг	283,420,821	242,436,053
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг	66,997,372	54,468,576
Халаасны хувьцаа	-	(322,000)
<b>Нийт 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө</b>	<b>854,063,640</b>	<b>635,028,821</b>
<b>2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө</b>		
Давуу эрхтэй хувьцаа	-	25,778,900
Халаасны хувьцаа/Давуу эрхийн хувьцаа	-	(9,390,800)
<b>Нийт 2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө</b>	<b>-</b>	<b>16,388,100</b>
<b>Нийт өөрийн хөрөнгө/капиталын суурь</b>	<b>854,063,640</b>	<b>651,416,921</b>

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банкны өөрийн хөрөнгө нь 861,905,763 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 658,662,023 мянган төгрөг) байсан. Банк 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар болон 2021 оны жилийн эцсийн байдлаар өөрийн хөрөнгөнд тавигдах бүх шаардлагуудыг биелүүлсэн.

Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн зааварт үндэслэн тооцоолсон өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт болон Эрсдэлээр жинлэсэн активын харьцаа нь дээрх үзүүлэлтүүдээс ялгаатай байж болно. Монголбанк нь нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу нэмэлт сан байгуулах талаар Банкинд хүсэлт тавих эрхтэй.

## 40 Болзошгүй өр төлбөр ба үүрэг

**Шүүн таслах ажиллагаа.** Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Банк өөрийнх нь эсрэг мэдүүлсэн нэхэмжлэл хүлээн авах тохиолдлууд байдаг. Банк нь шүүхийн маргааны явцад баримтлах албан ёсны хяналт, бодлоготой. Хэрэв удирдлага өөрийн тооцоолол, дотоод мэргэжлийн зөвлөгөөг үндэслэн Банкинд материаллаг нөлөө үзүүлэхээр маргаан, зарга байна гэж үзвэл тэдгээрийн санхүүгийн тайланд нөлөөлж болзошгүй сөрөг үр дагаврыг тооцох зорилгоор залруулга хийдэг. 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар шүүхийн зарга, маргаантай холбоотой 179,771 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 47,274 мянган төгрөг)-ийн нөөц сан байгуулж бүртгэсэн.

**Татварын хууль тогтоомж.** Монгол Улсын татварын, валютын болон гаалийн зохицуулалттай холбоотой хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, мөн үе үе өөрчлөгдөх магадлалтай. Эдгээр хууль тогтоомжуудыг Банкны ажил гүйлгээ болон үйл ажиллагаанд удирдлагын тайлбарлан хэрэгжүүлсэн байдал нь татварын байгууллагынхаас зөрөх магадлалтай.

Монгол Улсын татварын байгууллагууд хууль тогтоомжийг тайлбарлан үнэлэхдээ илүү хатуу байр суурь баримталж болох бөгөөд өмнө нь маргалдаж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг татварын байгууллага үгүйсгэх боломжтой билээ. Үүний үр дүнд мэдэгдэхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алданги ногдуулах магадлалтай. Татварын байгууллагууд шалгагдаж буй жилийн өмнөх таван жилийн татварыг эргэн сөхөж шалгах эрхтэй байдаг. Зарим тодорхой нөхцөл байдалд түүнээс өмнөх хугацааг хамран шалгах боломжтой.

Монгол улсын татварын хууль тогтоомжуудын ялангуяа нэмэгдсэн өртгийн албан татвар, суутгагчийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үнэ шилжилт болон бусад татварын хуулиудын зарим нэгэн заалтууд нь тодорхой тайлбар зааварчилгаагүй байдаг. Ийм зарим нэг тохиолдолд удирдлага нь эдгээр тайлбар нь тодорхой бус байх боломжтой хууль тогтоомжуудыг Банкинд ногдох татварын хувь хэмжээг бууруулах байдлаар тайлбарлан үнэлдэг. Дээр дурдсаны дагуу сүүлийн үед бий болсон захиргааны болон шүүхийн практик байдалд гарч буй шинэчлэлийн үр дүнд дээрх тодорхой бус байдлын талаарх байр суурь улам хатуу хяналт шалгалтанд өртөж болзошгүй. Хэдийгээр байгууллагын санхүүгийн байдал хийгээд нийт үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлэх боломжтой боловч татварын байгууллагын байр суурийг урьдчилан баттайгаар таамаглах боломжгүй болно.

Банкны удирдлага нь холбогдох хууль тогтоомжийг тайлбарлан хэрэгжүүлсэн байдлаа зохистой бөгөөд Банкны татварын болон бусад хууль тогтоомжийн талаарх байр суурь тогтвортой гэж үзэж байгаа. Удирдлага нь татвар болон бусад хууль тогтоомжоос үүсэх эрсдэл бага гэж үзэж байна. Удирдлага татвараас үүсэх эрсдэлүүдээ тогтмол эргэн хянаж байдаг ба өнөө үед баттайгаар урьдчилан харах боломжгүй нөхцөл байдлын өөрчлөлтийн улмаас ирээдүйд Банкны байр суурь өөрчлөгдөж болно.

**Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт.** Банк төслийн зээлээр авсан эх үүсвэрийн гэрээний заалтаар тодорхой харьцаануудыг хангасан байх үүрэгтэй. Тодруулга 22-т заасны дагуу ямар нэгэн харьцаа үзүүлэлтийг зөрчөөгүй.

**Зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг.** Банк нь харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн буцаах нөхцөлгүй болзошгүй өр төлбөр болон үүргийг хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргүүдийг санхүүгийн байдлын тайланд тусгадаггүй ч эдгээр нь тодорхой хэмжээний эрсдэлийг агуулж байдаг тул Банкны нийт эрсдэлийн нэгээхэн хэсэг гэж үздэг.

Эдгээр хэрэглүүрүүдийн үндсэн зорилго бол харилцагчдад шаардлагатай үед нь санхүүжилтийн эх үүсвэрийг бэлэн байлгахад оршино. Баталгаа нь хэрэв харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй тохиолдолд Банк өмнөөс нь төлбөрийг барагдуулах гэсэн цуцлагдах боломжгүй баталгаанууд бөгөөд эдгээр нь зээлтэй ижил төрлийн зээлийн эрсдэл агуулдаг. Бичиг баримтын болон арилжааны аккредитив нь Банкнаас тодотгон заасан нөхцөлд гуравдагч этгээд тохиролцсон дүн хүртэлх хөрөнгийг татан авахыг харилцагчийн өмнөөс бичгээр зөвшөөрсөн үүрэг хүлээлт бөгөөд холбогдох бараа таваар буюу мөнгөн хадгаламжуудаар баталгаажсан байдаг тул шууд зээлээс арай бага эрсдэлтэй байдаг.

Зээл олгохоор хүлээсэн үүргүүд нь зээл, баталгаа эсвэл аккредитивын хэлбэрээр үүсгэсэн зээлийн шугамын ашиглагдаагүй хэсгийг илэрхийлж байгаа. Зээл олгох үүргийн зээлийн эрсдэлийн хувьд Банк нь ашиглагдаагүй зээлийг харилцагч авсан тохиолдолд ингэж авсан зээлийн нийт хэмжээгээр алдагдал хүлээх эрсдэлд өртдөг.

**40 Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)**

Гэвч харилцагч тодорхой зээлийн нөхцөл биелүүлж байж зээл авах эрх олж авдаг тул Банкны хүлээж болох алдагдлын дүн ашиглагдаагүй байгаа зээлийн шугамаас бага юм.

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2021 оны 12 сарын 31</b>
Олгосон санхүүгийн баталгаа	66,863,233	45,866,650
Олгосон гүйцэтгэлийн баталгаа	355,360,186	395,440,322
Аккредитив	244,371,440	165,377,364
Ашиглаагүй зээлийн шугам	284,861,192	221,576,038
<b>Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг</b>	<b>951,456,052</b>	<b>828,260,374</b>
Хасах нь: зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүргийн үнэ цэнийн бууралтын сангийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал	(1,447,410)	(938,074)
<b>Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг</b>	<b>950,008,642</b>	<b>827,322,300</b>

ХБЭА-ыг хэмжих зорилгоор зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүргийг 1-р үе шатанд оруулсан.

Хуулийн этгээд болон хувь хүнд олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн сангийн 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх өөрчлөлт, хөдөлгөөнийг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Олгосон санхүүгийн баталгаа</b>	<b>Олгосон гүйцэтгэлийн баталгаа</b>	<b>Аккредитив</b>	<b>Нийт дүн</b>
<b>2022 оны 1 сарын 1-нээрх хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн сан</b>	<b>248,091</b>	<b>650,374</b>	<b>39,609</b>	<b>938,074</b>
Тайлант жилд байгуулсан үнэ цэнэ бууралтын сангийн буцаалт	117,134	388,815	3,386	<b>509,336</b>
<b>2022 оны 12 сарын 31-нээрх хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн сан</b>	<b>365,225</b>	<b>1,039,189</b>	<b>42,995</b>	<b>1,447,410</b>

Хуулийн этгээд болон хувь хүнд олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн сангийн 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх өөрчлөлт, хөдөлгөөнийг дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Олгосон санхүүгийн баталгаа</b>	<b>Олгосон гүйцэтгэлийн баталгаа</b>	<b>Аккредитив</b>	<b>Нийт дүн</b>
<b>2021 оны 1 сарын 1-нээрх хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн сан</b>	<b>480,689</b>	<b>2,224,480</b>	<b>191,838</b>	<b>2,897,007</b>
Тайлант жилд байгуулсан үнэ цэнэ бууралтын сангийн буцаалт	(232,598)	(1,574,106)	(152,229)	<b>(1,958,933)</b>
<b>2021 оны 12 сарын 31-нээрх хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн сан</b>	<b>248,091</b>	<b>650,374</b>	<b>39,609</b>	<b>938,074</b>

Аккредитив, баталгаа (нээлттэй аккредитивийг оруулан) нь тусгайлсан ажил гүйлгээнд ихэнхдээ бараа бүтээгдэхүүний импорт болон экспорттой холбоотойгоор харилцагчийн өмнөөс төлбөр хийх үүргийг Банкинд ногдуулдаг байна. Баталгаа, нээлттэй аккредитив нь хэдийгээр болзошгүй шинж чанартай боловч зээлтэй ижил төрлийн эрсдэлийг агуулдаг. Эдгээр ажил гүйлгээний үр дүнд нөөц санг байгуулснаас бусад тохиолдолд материаллаг алдагдал байхгүй гэж таамаглаж байна.

Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талаас нөхөн олговор олгодог гэрээ юм. Гүйцэтгэлийн баталгааны нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар Тодруулга 4.24-өөс харна уу.



#### 40 Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)

Удирдлагын зүгээс 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зээлтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой 1,447,410 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 938,074 мянган төгрөг)-ийн эрсдэлийн санг тухайн харилцагчийн санхүүгийн нөхцөл байдалд шинжилгээ хийсний дараах учирч болзошгүй алдагдлын хэмжээг нээлттэй байгаа мэдээлэл болон давтагдах магадлалд үндэслэн тодорхойлсны дагуу байгуулах шаардлагатай гэж үзсэн.

**Барьцаалсан болон хязгаарласан хөрөнгө.** 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкинд байршуулсан 357,581,959 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 277,343,522 мянган төгрөг)-ийн заавал байлгах үлдэгдэл нь Банкны өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглах боломжгүй заавал байлгах нөөц хөрөнгө юм. (Тодруулга 8).

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 205,728,000 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 223,554,000 мянган төгрөг) болон 42,800,000 мянган төгрөгийн Монголбанкнаас авсан 28 хоногийн хугацаатай үнэт цаасыг нь репо хэлцэлд (Тодруулга 23) болон Алт 2 хөтөлбөрийн зээлэнд барьцаанд тавьсан.(Тодруулга 22).

Засгийн Газрын 180,152,580 мянган төгрөгийн (2021 оны 12 сарын 31: байхгүй) нэрлэсэн үнэтэй бондыг гадны банкнаас эх үүсвэр татахын тулд барьцаалсан. Тодруулга 22-оос үзнэ үү.

38,372,844 мянган төгрөгийн (2021 оны 12 сарын 31: байхгүй) нэрлэсэн үнэтэй, бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх компанийн бондыг репо хэлцэлд барьцаалсан. Тодруулга 23-аас үзнэ үү.

Бусад гадаадын банкууд дахь харилцах дансанд байршуулсан 300,000 мянган ам.доллар нь тухайн банкнаас авсан зээлийн барьцаа ба 25,000 мянган ам.долларын эх үүсвэр нь бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх засгийн газрын үнэт цаасаар баталгаажсан болно. Тодруулга 10-аас үзнэ үү.

Банк нь харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн буцаах нөхцөлгүй болзошгүй өр төлбөр болон үүргийг хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргүүдийг санхүүгийн байдлын тайланд тусгадаггүй ч эдгээр нь тодорхой хэмжээний зээлийн эрсдэлийг агуулж байдаг тул Банкны нийт эрсдэлийн нэгээхэн хэсэг гэж үздэг.

#### 41 Үүсмэл санхүүгийн хэрэглүүр

Банкны тайлант хугацааны эцсээрх гадаад валютын форвард болон своп хэлцлээс үүссэн гадаад валютын авлага болон өглөгийн бодит үнэ цэнийг дор үзүүлэв. Доорх хүснэгтэнд цэвэршүүлээгүй нийт позицыг үзүүлсэн бөгөөд хэлцлийн огноо нь тухайн тайлант хугацааны дараах хэлцлүүдийг мөн харуулсан болно.

Зах зээл дэх хүүний түвшний өөрчлөлт, гадаад валютын арилжааны ханшийн өөрчлөлт, хөдөлгөөн болон бусад гэрээний нөхцөл дэх өөрчлөлтөөс хамаарч үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь ашигтай (хөрөнгө) ашиггүй (өр төлбөр) байж болно. Үүсмэл санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн нийт бодит үнэ цэнэ нь цаг үргэлж их хэмжээгээр өөрчлөгдөж байдаг.

Санхүүгийн байдлын тайлангийн цэвэршүүлээгүй болон цэвэршүүлсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн нийт дүнг дор харуулав.

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2021 оны 12 сарын 31</b>
<b>Гадаад валютын форвард болон своп хэлцэл:</b>		
<b>тайлант хугацааны эцсээрх бодит үнэ цэнэ:</b>		
- Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө	457,415,688	218,372,256
- Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн өр төлбөр	(21,269,579)	(9,455,197)
<b>Гадаад валютын форвард болон своп хэлцлийн цэвэр бодит үнэ цэнэ</b>	<b>436,146,109</b>	<b>208,917,059</b>

**41 Үүсмэл санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2021 оны 12 сарын 31</b>
<b>Гадаад валютын форвард болон своп хэлцэл:</b>		
<b>тайлант хугацааны эцсээрх бодит үнэ цэнэ</b>		
- Ам.долларын авлага (+)	654,520,799	151,660,992
- Ам.долларын өглөг (-)	(22,613,278)	(23,830,079)
- Төгрөгийн авлага (+)	2,134,889	232,747,374
- Төгрөгийн өглөг (-)	(215,163,795)	(163,973,130)
- Бусад валютын авлага (+)	20,478,438	23,820,472
- Бусад валютын өглөг (-)	(3,210,944)	(11,508,570)
<b>Гадаад валютын форвард болон своп хэлцлийн цэвэр бодит үнэ цэнэ</b>	<b>436,146,109</b>	<b>208,917,059</b>

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 436,115,135 мянган төгрөг (2021 оны 12 сарын 31: 209,029,124 мянган төгрөг)-ийн санхүүгийн хөрөнгө нь Монголбанктай хийсэн урт хугацаат гадаад валютын хүүний своп хэлцэлтэй холбоотой. 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар урт хугацаат, гадаад валютын своп хэлцлийн нийт нэрлэсэн үнэ нь 1,134,331,616 мянган төгрөг, 12 сараас 96 сар хүртэлх хугацаатай (2021 оны 12 сарын 31: 1,028,689,759 мянган төгрөг, 12 сараас 96 сар хүртэлх хугацаатай).

